МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 23 50,
Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2024 02 15 № А-1/297

танай _____-ны №_____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2023 оны жилийн эцсийн тайлан, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3, 8.1, 10.7.2-т заасны дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Тайлан тус бүрийг дээр дурдсан журмын 10.7.1, 10.7.2-т заасны дагуу Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан http://new.unelgee.gov.mn системд оруулж, холбогдох баримт материалыг хавсарган баталгаажуулав.

Хавсралт 127 хуудастай:

1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай танилцуулга - 2 хуудас;

2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны хэрэгжилтийн тайлан - 120 хуудас;

3.Хяналтаас хасуулах санал бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт - 3 хуудас;

4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээс - 2 хуудас.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

132004397

А-4/2024

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024.02.15 Дугаар:01 Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлийн хурал тус газрын 216 тоот хурлын танхимд 14.00 цагт эхлэв.

Хуралд оролцсон гишүүд:

Зөвлөлийн дарга: Б.Цэнгэл

Гишүүд:

Н.Ганболд	Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
Ц.Баяр-Эрдэнэ	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга
Д.Нарангэрэл	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга
Ц.Түвшинзаяа	Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн дарга
Д.Дэлгэрмаа	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
В.Дарханбаатар	ТӨУЗХ-ийн Удирдлага, төлөөллийн албаны дарга
Ц.Шинэхүү	ТӨУЗХ-ийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга
Т.Нямсүрэн	ЗУХ-ийн Мэдээлэл технологийн албаны дарга
Н.Дагиймаа	Нарийн бичгийн дарга

Хурлын ирц 100 хувьтай байв.

Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Захиргаа, удирдлагын хэлтсийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн Д.Цэрэнлхам нар байлцав.

Хурлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл даргалав.

ХЭЛЭЛЦСЭН нь:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тухай.

Хэлэлцсэн асуудалтай холбоотой танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн Д.Цэрэнлхам танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг зөвшөөрч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр тогтов.
2. 2023 оны жилийн эцсийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хяналтад авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон нийт 8 төрлийн 120 шийдвэрийн 185 заалтын хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2023 оны жилийн эцсийн байдлаар дундаж үнэлгээ 90.1 хувь байна;
3. Чиг үүрэгт хамааралгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт нь тогтмолжсон, тодорхой шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй гэж үзсэн 110 заалтыг хяналтаас хасуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх;
4. Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” ТӨҮГ-ыг, Засгийн газрын 2023 оны 258 дугаар тогтоолоор “Цемент шохой” ТӨХК-ийг, Засгийн газрын 2023 оны 429 дүгээр тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд тус тус ажиллуулахаар шийдвэрүүд гарсантай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шууд хамааралгүй болсон учир хариуцан тайлагнах асуудлыг Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хариуцуулах нь зүйтэй гэж үзэж, уламжлах;
5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт нь удааширч байгаа, тасарсан заалтуудын хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилд эрчимжүүлэх арга хэмжээ авах;
6. Тайлангийн ил тод байдлыг хангаж, байгууллагын цахим системд нээлттэй мэдээлэх.

Тэмдэглэл хөтөлсөн:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ДАГИЙМАА

Хурлын тэмдэглэлтэй танилцсан :

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

Хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2023 оны жилийн эцсийн байдлаар тайлагнав)

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)

ATA11111 6098169 9023120816

2024-02-01

Улаанбаатар хот

Шийд-вэр-ийн д/д	Зүйл, заал-тын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалтын дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Нэг. Монгол Улсын хууль					
1	1	**Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/** 2017-12-07, Хэрэгжиж эхлэх: 2019.01.01 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	**ТӨБЗГ – ЗУХ** 1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/36 дугаар тушаалаар "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэв. Үүнд: Төрийн захиргааны 8 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг ахиулан болон шинээр олгов. Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн хэмжээг Засгийн газрын 2022 оны 488, 2023 оны 241 дугаар тогтоолын дагуу шинэчлэн тооцож мөрдөн ажилласан. Төрийн үйлчилгээний 4 албан хаагчид 2023 оны эхний хагас жилийн ажлын үнэлгээг үндэслэн 07 дугаар сарын 03-ны өдрөөс тус бүр 25 хувиар ур чадварын нэмэгдлийг тооцон олгов. Албан хаагчдын хоол, унааны зардлыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 12,000 төгрөг, 10 дугаар сарын 01-ний өдрөөс 22,000 төгрөг болгож нэмэгдүүлэн шийдвэрлэсэн. Албан хаагчдад холбогдох тусламж, дэмжлэгийг хууль тогтоомж, журмын дагуу олгов. Тухайлбал, Цагаан сар, Ахмадын баярын өдрийг тохиолдуулан байгууллагын ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэн 27 ахмад настанд 2 удаа тус бүр 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Албан хаагчдын 16 хүртэлх	"Бүрэн хэрэгжсэн" – 100 %	Хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай.

Хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2023 оны жилийн эцсийн байдлаар тайлагнав)

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)

2024-02-01 Улаанбаатар хот

Шийд-вэр-ийн д/д	Зүйл, заал-тын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалтын дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Нэг. Монгол Улсын хууль					
1	1	**Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/** 2017-12-07, Хэрэгжиж эхлэх: 2019.01.01 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	**ТӨБЗГ – ЗУХ** 1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/36 дугаар тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг батлав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэв. Үүнд: Төрийн захиргааны 8 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг ахиулан болон шинээр олгов. Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн хэмжээг Засгийн газрын 2022 оны 488, 2023 оны 241 дугаар тогтоолын дагуу шинэчлэн тооцож мөрдөн ажилласан. Төрийн үйлчилгээний 4 албан хаагчид 2023 оны эхний хагас жилийн ажлын үнэлгээг үндэслэн 07 дугаар сарын 03-ны өдрөөс тус бүр 25 хувиар ур чадварын нэмэгдлийг тооцон олгов. Албан хаагчдын хоол, унааны зардлыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 12,000 төгрөг, 10 дугаар сарын 01-ний өдрөөс 22,000 төгрөг болгож нэмэгдүүлэн шийдвэрлэсэн. Албан хаагчдад холбогдох тусламж, дэмжлэгийг хууль тогтоомж, журмын дагуу олгов. Тухайлбал, Цагаан сар, Ахмадын баярын өдрийг тохиолдуулан байгууллагын ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэн 27 ахмад настанд 2 удаа тус бүр 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Албан хаагчдын 16 хүртэлх	“Бүрэн хэрэгжсэн” – 100 %	Хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай.

			насны 67 хүүхдэд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр бэлэг, дурсгал гардуулав. Ар гэрт нь гачигдал тохиолдсон 4 албан хаагчид тус бүр 500,000 төгрөгийн, 1 өндөр настанд 300,000 төгрөгийн буцалтгүй тусламж, ар гэрийн гишүүдийн эрүүл мэндийн шалтгаанаар чөлөө авсан 3 албан хаагчид цалинтай чөлөө олгож, холбогдох журмын дагуу тусламж олгов. Ахмадын зөвлөлийг газрын даргын А/79 дүгээр тушаалаар нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, Ахмадын зөвлөлийн ажиллах журмыг батлан мөрдүүлэв. Төрийн сан банканд Ахмадын сангийн дансыг шинээр үүсгэж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу батлагдсан цалингийн сангийн 3 хувь буюу 38.7 сая төгрөгийг байршууллаа. ТӨБЗГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/17 дугаар тушаалаар 2023 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Сургалтын төлөвлөгөөний дагуу 2023 онд төрийн албаны мэргэшүүлэх сургалт (эрхэлсэн түшмэл – 1, ахлах түшмэл - 1, дунд хугацааны давтан – 2, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн дунд хугацааны сургалтад – 2, чиглүүлэх сургалтад - 2)-д нийт 8 албан хаагчийг хамруулав. Нийт албан хаагчдад зориулан ажлын байранд 20 удаагийн лекц, сургалтыг ёс зүй, харилцаа, хандлага, авлигын эсрэг соён гэгээрүүлэх, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, танин мэдэхүйн чиглэлээр зохион байгуулав. Албан хаагчдын англи хэлний түвшнийг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулсны үндсэн дээр гадаад хэлний “Абсолют сургалтын төв”-тэй хийгдсэн гэрээний дагуу англи хэлний сургалтад 2022 онд элссэн 9 албан хаагч сургалтаа төгссөн бөгөөд 2023 онд англи хэлний “Эдү Интерлинк” ХХК-тай гэрээ хийж, 2024 онд 15 албан хаагчийг шинээр хамруулахаар болсон.		
2	2	**Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай** 2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	**ТӨБЗГ – ЗУХ, МТА** Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ, аудит, бусад шалгалт байхгүй болно.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй”	Хяналтаас хасах саналтай.
3	3	**Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль** 2021-12-24, Хэрэгжиж эхлэх: 2022-02-07	**ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨХШХ, ТӨУЗХ, ТӨБАХ** Тайлант хугацаанд, Засгийн газраас Монгол Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Байнгын хорооны холбогдох тогтоолын хэрэгжилтийг хагас, бүтэн жил болон 2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 3 удаа гаргуулж, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай.

		(Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 оны, №05) 11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.)	ТӨБЗГ-аас 2022 оны жилийн эцсийн байдлаар УИХ-ын 7 тогтоолын холбогдох 15 заалтын, УИХ-ын Байнгын хорооны 3 тогтоолын холбогдох 3 заалтын хэрэгжилтийг дунджаар 100 хувийн дүнтэй, 2023 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын хяналтад авсан УИХ-ын 11 тогтоолын 26 заалтын, УИХ-ын Байнгын хорооны 5 тогтоолын 9 заалтын, нийт 16 тогтоолын 35 заалтын хэрэгжилтийг дунджаар 79.3 хувийн үнэлгээтэй, 2023 оны 3-р улирлын байдлаар УИХ-ын 13 тогтоолын 29 заалт, УИХ-ын Байнгын хорооны 8 тогтоолын 15 заалт, нийт 21 тогтоолын 44 заалтын хэрэгжилтийг дунджаар 80.6 хувийн үнэлгээтэйгээр тус тус тайлагнаж, Засгийн газарт хүргүүлсэн байна. Энэхүү тайланд мөн УИХ болон Байнгын хорооны нийт 21 тогтоолын 42 заалтын хэрэгжилтийг тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байгаа болно. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Нийслэлийн прокурорын газартай хамтран “Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад Прокурорын байгууллагатай хамтарч ажиллах нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулсан. Уулзалтаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төр, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хуулийн байгууллагууд, ялангуяа Прокурорын байгууллагатай хамтран ажиллаж, цаашид төрд учруулсан хохирлыг бүрэн арилгах талаар санал солилцсон.		
4	4	**Төрийн хэмнэлтийн тухай** 2022-04-29, Хэрэгжиж эхлэх: 2022.04.29 5.1. Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно.	**ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 онд мөрдөж, хэрэгжүүлэхтэй холбоотой дэд даргын орон тоог хассантай холбоотойгоор түүний цалин хөлс, автомашин, шатахуун, жолоочийн цалин хангамжийн зардалд хэмнэлт гарч, үр дүнг Засгийн газарт мэдээлж байсан. Тухайлбал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 22,777,009.0 төгрөгийн төсвийн зардал хэмнэгдэж байсан бол, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 87 хуулийн этгээдийн 104 тэргүүн дэд, дэд, орлогч даргын орон тоог цомхотгосноор 4.0 тэрбум төгрөгийн цалин хангамжийн, тэдгээрт үйлчилж байсан жолооч, туслахын цалин хөлс, унаа, шатахууны зардал болох 1.6 тэрбум төгрөгийн, нийт 5.6 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан. Улмаар 2023 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хариуцан хэрэгжүүлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 42 хуулийн этгээдэд орлогч, дэд даргын орон тоогүй ажиллаж байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Хуулийн хэрэгжилт хангагдаж, бүрэн хэрэгжсэн, зохион байгуулал-тын арга хэмжээ авсан тул цаашид хяналтаас хасах саналтай.

	5	**Төрийн хэмнэлтийн тухай** 2022-04-29, Хэрэгжиж эхлэх: 2022.04.29 10.1. Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 184 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг баталсан. Уг журмын 2 дугаар хавсралтаар “Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын албан тушаалын сарын хөдөлмөрийн хөлс тогтоох аргачлал”-ыг баталж, аргачлалын дагуу төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн захирлын жишиг цалинг тогтоон, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. <u>Тайлбар мэдээлэл:</u> Харин төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоох асуудал нь зөвхөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа 56,000 гаруй ажилтан, албан хаагчдын асуудал бус Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, салбар бүрийн үйлдвэрчний эвлэл, компани хоорондын “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт гэрээ”, хэлэлцээртэй салшгүй холбоотой учир өргөн хүрээний хэлэлцээр, судалгаа, шинжилгээний үр дүнд шийдвэрлэгдэхээр байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бие даан боловсруулж, Засгийн газарт оруулахад хүндрэлтэй нөхцөл байдалтай байгаа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уг асуудлаар хамтран ажиллах талаар холбогдох саналыг тавьсан болно. Төрийн өмчит хуулийн этгээдийн бусад албан хаагчдын цалин хөлсний талаар үүсээд байгаа нөхцөл байдлын талаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн мэдээлэлд тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт танилцуулахаар 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/1813 дугаартай албан бичгийг хүргүүлж байсан.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Цаашид энэ заалтыг хяналтаас хасуулж, дотоод хяналтад авах саналыг тухайн үед хүргүүлж байсан. Хяналтаас хасах саналтай.
	6	**Төрийн хэмнэлтийн тухай** 2022-04-29, Хэрэгжиж эхлэх: 2022.04.29 20.1. Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээд санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нээлттэй хувьцаат компанид тавигддаг шаардлагын дагуу бэлтгэж эрх бүхий этгээдэд тайлагнах бөгөөд аудитын	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн товхимлыг тухайн компани, үйлдвэрийн газрын аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийн үзүүлэлтийн дагуу нэгтгэн https://pcsp.gov.mn/?page_id=5572 цахим холбоосоор олон нийтэд нээлттэй ил тод байршуулсан. Цаашид тус товхимлыг визуал хэлбэрт шилжүүлэн, иргэд, олон нийт холбогдох мэдээллийг илүү хялбараар авах нөхцөл боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай.

		дүгнэлттэй хамт олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.	Мөн харьяа байгууллага бүрийн жагсаалт, цахим хуудасны холбоосыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын https://pcsp.gov.mn/?page_id=1822 цахим хуудсанд байршуулсан ба холбогдох компани, үйлдвэрийн газруудын тайлан, мэдээг тус холбоосоор нэвтрэн орж авах боломжтой болсон.		
	7	**Төрийн хэмнэлтийн тухай** 2022-04-29, Хэрэгжиж эхлэх: 2022.04.29 20.2. Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын төсөл, “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын төсөл, “Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсний дүнд Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолуудаар баталсан. Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 5.1 дэх хэсэгт заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар Зам, тээврийн салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-д төрийн өмчийн төлөөлөн хэрэгжүүлэх гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг, А/40 дүгээр тушаалаар Мэдээлэл, харилцаа холбооны салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөн хэрэгжүүлэх гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг, А/41 дүгээр тушаалаар Барилга, хот байгуулалтын салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг тус тус байгуулан сонгон шалгаруулалтыг гүйцэтгэсэн. ТӨБЗГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг, компаниудын ТУЗ хамтран “МИАТ” ТӨХК, “Архангай, Өвөрхангай, Хархорин А3ЗА” ТӨХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Дархан, Сэлэнгэ А3ЗА” ТӨХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК, “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК, “Эрдэнэс Монгол” ХК, “Тавантолгой түлш” ХХК, “Хөдөө аж ахуйн корпорац” ХХК зэрэг 10 гаруй компанийн ТУЗ-д төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх болон хараат бус гишүүдийг, “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ, “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” ТӨҮГ-ын захирал, “Монголын төмөр зам” ТӨХК, “Говь-Алтай А3ЗА” ТӨХК, “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, томилох асуудлыг холбогдох журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шийдвэрлэсэн байна. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/72 дугаар тушаалаар Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Эрчим хүчний яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан байгуулж, сонгон шалгаруулалтыг дээрх журмын 5 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулсан.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай.

			Нийт 39 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх 195 гишүүнийг, 49 компанийн ТУЗ-ийн 121 хараат бус гишүүнийг, 12 компани, 5 үйлдвэрийн газрын захирлыг холбогдох журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж, томилох асуудлыг шийдвэрлэсэн байна. ТӨБЗГ-ын цахим хуудас болон тухайн хуулийн этгээдийн цахим хуудсанд мэдээллийг нээлттэй байршуулсан болно.		
	8	**Төрийн хэмнэлтийн тухай** 2022-04-29, Хэрэгжиж эхлэх: 2022.04.29 20.3. Энэ хуулийн 15.4-т заасан гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хариуцан хэрэгжүүлж буй 41 (”Геологийн судалгааны төв” ТӨҮГ, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ууд нэгдсэн тул гэрээг дүгнээгүй) хуулийн этгээд буюу төрийн өмчит 24 компани, 17 үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хянаж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллуулсан. Ажлын хэсэг уг асуудлыг хэлэлцэн санал дүгнэлт гаргаж, ТӨБЗГ-ын хуралдаанаар шийдвэрлүүлсэн бөгөөд төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал болон төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирлуудтай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г байгуулан хэрэгжилтийг хангуулан ажилласан. Холбогдох шийдвэрийг ТӨБЗГ-ын болон тухайн аж ахуйн нэгжийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Эрчим хүчний салбарын компаниудын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурал (Эрчим хүчний яам 66 хувь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 34 хувь)-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг байгуулсан. Холбогдох шийдвэр мэдээллийг Эрчим хүчний яам болон тухайн хуулийн этгээдийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай.
	9	**Төрийн хэмнэлтийн тухай** 2022-04-29, Хэрэгжиж эхлэх: 2022.04.29 20.4. Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийт танилцах боломжтой	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн товхимлыг тухайн компани, үйлдвэрийн газрын аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийн үзүүлэлтийн дагуу нэгтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим хуудсанд байршуулан https://pcsp.gov.mn/?page_id=5572 холбоосоор олон нийтэд нээлттэй ил тод мэдээлсэн. Тус товхимлоос иргэд, олон нийт нэгдсэн байдлаар компани, үйлдвэрийн газар бүрийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл болон холбогдох бусад мэдээллийг нэгдсэн байдлаар авах боломжтой. Цаашид тус товхимлыг визуал хэлбэрт шилжүүлэн, иргэд, олон нийт холбогдох мэдээллийг илүү хялбараар авах нөхцөл боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай.

		хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.	Мөн харьяа байгууллага бүрийн жагсаалт, цахим хуудасны холбоосыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын https://pcsp.gov.mn/?page_id=1822 цахим хуудсанд байршуулсан ба холбогдох компаниудын тайлан, мэдээг тус холбоосоор нэвтрэн орж авах боломжтой болсон.		
	10	**Төрийн хэмнэлтийн тухай** 2022-04-29, Хэрэгжиж эхлэх: 2022.04.29 13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)	**ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ** Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулах төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно. ТӨБЗГ-ын харьяа төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд нь аж ахуйн тооцоонд суурилсан, өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг, төсвөөс хөрөнгө оруулалт авдаггүй болно. Тэмдэглэл: Тус хуулийн 13.1.1-т “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” гэж заасан заалтыг тус хуулийн 22.1-т 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр 2023 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	Цаг хугацааны хувьд нэг удаагийн шинжтэй тул цаашид хяналтаас хасах саналтай.
	11	**Төрийн хэмнэлтийн тухай** 2022-04-29, Хэрэгжиж эхлэх: 2022.04.29 17.2. Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг журмыг Засгийн газар батална.	**ТӨБЗГ – ХЭЗХ, ТӨБАХ** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгслийг ашиглахтай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолын 5 дахь заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг аван ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолыг үндэслэн ТӨБЗГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар “Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний үнэ тариф, зардлын норм, норматив болон Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишгийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан ажиллуулсан. Уг ажлын хэсэг нийтлэг жишиг, журмыг боловсруулахад чиглэсэн шаардлагатай судалгаа хийж, санал төсөл боловсруулж, танилцуулсан.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Зохион байгуулал-тын арга хэмжээ бүрэн хийгдсэн тул хяналтаас хасах саналтай.

			Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаар хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталсан. Журмыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Чиглэл хүргүүлж, санал авах тухай” А-1/194 дугаартай албан бичгийг төрийн өмчит бүх шатны байгууллагад хүргүүлсэн.		
		МУ-ын хууль: 4 хуулийн 11 заалт:	**100% - 9 заалт; ХБ – 2 заалт.**	**Дундаж үнэлгээ: 100%**	
Хоёр. УИХ-ын тогтоол					
5	12	**Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай** 2016-04-14, № 34 7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	**ТӨБЗГ – ЗУХ** “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулах асуудлаар холбогдох хууль тогтоомжийг судлан мэргэжлийн байгууллагын зөвлөгөө арга зүйг авах чиглэлээр санал боловсруулсан. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэ чиглэлээрх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр газар хөдлөлтийн гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтад байгууллагын нийт албан хаагчид оролцож, зохион байгуулагчдын зааварчилгаагаар ажиллан, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх дадлага хийж, зохих ойлголт мэдээллийн авсан. Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах үеийн цагийн байдлын мэдээллийг холбогдох зохион байгуулагчдад хүргэсэн.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	Чиг үүрэгт хамаарал-гүй тул цаашид хяналтаас хасах саналтай.
	13	**Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай** 2016-04-14, № 34 8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга	**ТӨБЗГ – ЗУХ** “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулах асуудлаар холбогдох хууль тогтоомжийг судлан мэргэжлийн байгууллагын зөвлөгөө арга зүйг авах чиглэлээр санал боловсруулсан. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэ чиглэлээрх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Барилга байгууламжийн хийц, бүтээцийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг тогтоох, барилгын төлөвлөлт, угсралт, ашиглалт, аюулгүй байдалд дүн шинжилгээ хийж, баталгаажуулахад бэлтгэв.	“Хэрэгжих шатанд” – 70%	

		хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.	2023, 2024 оны төсвийн төсөлд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангахад шаардагдах 25.0 сая төгрөгийн зардлын төсвийг тухай бүр тусгаж, саналаа Төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яаманд хүргүүлсэн боловч, шаардлагатай төсөв батлагдаагүй хасагдсан.		
6	14	**Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай** 2020-01-09, № 02 ТӨБЗГ хуулийн төсөл 2020. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	**ТӨБЗГ – ХЭЗХ** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр МУИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд ажлын хэсэг байгуулан ажиллуулсан. Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор уг ажлын хэсэгт чиглэл өгсний дагуу тодорхой ажлуудыг нэмж хийхээр зохион байгуулалтын арга хэмжээ аван ажилласан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, эдгээр хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий уг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга нар ажиллав. Дэд ажлын хэсэг хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 198 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 2023 оны 10 дугаар сард багтаан хүлээлгэн өгөхөөр ажилласан боловч хууль санаачлагчаас хуулийн төслийг эгүүлэн татсан. Хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал их гарсан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр хуулийн төсөл шинээр өргөн барихаар болж, Ажлын хэсгийг шинээр байгуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Ажлын хэсгээс зохион байгуулсан. 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Орон нутгийн өмчийн газрын дарга нартай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уулзалт зохион байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар мэдээлэл өгч, санал солилцлоо.	“Хэрэгжих шатанд” – 70%	

7	15	**“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай** 2020-05-13, № 52 3.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай: 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;	**ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ХЭЗХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуулиар хүлээсэн үүрэг, тусгайлан олгосон чиг үүрэгт хамаарах асуудлаар дунд хугацааны зорилтот болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах зорилт, арга хэмжээг боловсруулахад “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг тусгагдсан бодлогын зорилтыг үндэслэн уялдуулах зарчим баримталж байна. 2023 онд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төслүүдийг уг урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдуулан боловсруулсан болно. Албан хаагчдын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үет “Шинэ сэргэлтийн бодлого” сэдэвт зайны болон танхимын хэлбэр хосолсон 14 хоногийн сургалтад албан хаагчдыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 18-ны өдрийг хүртэл хамруулж, сертификат олгосон.	“Бүрэн хэрэгжсэн” – 100 %	
8	16	**Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай** 2020-12-04, № 39 1.5/. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төслийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын санхүүжилтээр уг ариун цэврийн байгууламжийг бий болгох талаар Улсын Их Хурлын энэхүү тогтоол гарсантай холбоотой Засгийн газрын 2021 оны 127 дугаар тогтоолоор Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл, арга хэмжээг нийгмийн хариуцлагын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр зохих журмын дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авах асуудлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захирал болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад зөвшөөрсөн байна. Уг төслийн нийт санхүүжилт 100.0 тэрбум төгрөг. Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийн дагуу Сангийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран санхүүжилтийн гэрээ байгуулж, Сангийн яамнаас Төрийн банкинд 104901845530 тоот данс нээж, санхүүжилтээ уг дансаар авахаар шийдвэрлэсэн.	“Бүрэн хэрэгжсэн” – 100 %	Засгийн газрын 2022 оны 255 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд шилжүүлсэн тул хяналтаас хасуулах саналтай.

			Уг гэрээний дагуу Сангийн яамнаас баталгаажуулж, нэхэмжилсэн үнийн дүнгээс “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2022 онд 29,092,968,320.0 төгрөгийн санхүүжилт, 2023 онд 31,363,874,444.0 төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр Сангийн яамны Төрийн банкин дахь дансанд шилжүүлсэн бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 505,692,058.0 төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ өгөхөөр үлдэгдэлтэй байна.		
9	17	**Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай** 2021-01-22, №12 3. Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	**ТӨБЗГ – ХЭЗХ** 2023 онд Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дор дурдсан асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр холбогдох мэдээлэл, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Уг асуудлыг УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай асуудлыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн байна. УИХ-ын зарим гишүүдийн зарчмын зөрүүтэй санал гарсантай холбоотой тогтоолын төслийг хууль тогтоомжийн санаачлагчид буцаасан тул УИХ-ын тогтоолын төслийг дахин өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна.	“Хэрэгжих шатанд” – 70%	
	18	**Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай** 2021-01-22, №12 4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.	**ТӨБЗГ – ХЭЗХ** Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан тус байгууллагын чиг үүрэгт шууд хамаарал бүхий Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулахад Засгийн газар болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас байгуулсан ажлын хэсгүүдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан ажиллуулж байгууллагын чиг үүрэгтэй холбоотой байр суурийг илэрхийлэх, холбогдох саналыг тусгуулах, ажлын хэсгийн шаардсан холбогдох судалгаа, тооцооллыг гаргаж хүргүүлэх чиглэлээр хамтран ажиллав. Дээрх 2 хуулийн төслийг хууль санаачлагчдаас УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд хэлэлцэх эсэх асуудлыг нэгдсэн чуулганаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороонд тус тус шилжүүлсэн. Уг Байнгын хорооны дэргэд УИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийг ажиллуулсан байна. Тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн өмчийн	“Бүрэн хэрэгжсэн” – 100 %	

			удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга нар ажиллаж 2023 оны 9-10 дугаар сард хуулийн төслийн заалт бүрд дүн шинжилгээ хийж, хэлэлцүүлэх чиглэлээр ажиллав. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Засгийн газрын хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр болон ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийн дагуу тухай бүр тайлагнах хүрээнд уг үндсэн чиглэлийн холбогдох заалтын хэрэгжилтийг тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажилласан байна.		
	19	**Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай** 2021-01-22, №12 ЗГХЭГ хуулийн төсөл 2021. Кибер аюулгүй байдлын тухай Гүйцэтгэх ажлын тухай /Шинэчилсэн найруулга/ Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Нийслэлийн эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Баялгийн сангийн тухай, **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай**	**ТӨБЗГ – ХЭЗХ** Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан бөгөөд уг төслийг Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн барихыг дэмжсэний дагуу 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр УИХ-д өргөн барьсан. УИХ-ын 06 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэн Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ажлын хэсэг байгуулж, ахлагчаар нь УИХ-ын гишүүн Б.Энхбаярыг томилсон. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн ажилтай уялдуулах чиглэлтэй ажилласан. МУИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд “Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, эдгээр хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулан ажиллуулж байна. Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор уг ажлын хэсэгт чиглэл өгсний дагуу тодорхой ажлуудыг нэмж хийхээр зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Уг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга нар ажилласан.	“Хэрэгжих шатанд” – 70%	

	20	**Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай** 2021-01-22, №12 ТӨБЗГ. хуулийн төсөл 2021. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай /Шинэчилсэн найруулга/ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай	**ТӨБЗГ – ХЭЗХ** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр МУИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд ажлын хэсэг байгуулан ажиллуулсан. Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор уг ажлын хэсэгт чиглэл өгсний дагуу тодорхой ажлуудыг нэмж хийхээр зохион байгуулалтын арга хэмжээ аван ажилласан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, эдгээр хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий уг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга нар ажиллав. Дэд ажлын хэсэг хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 198 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 2023 оны 10 дугаар сард багтаан хүлээлгэн өгөхөөр ажилласан боловч хууль санаачлагчаас хуулийн төслийг эгүүлэн татсан. Хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал их гарсан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр хуулийн төсөл шинээр өргөн барихаар болж, Ажлын хэсгийг шинээр байгуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Ажлын хэсгээс зохион байгуулсан. 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Орон нутгийн өмчийн газрын дарга нартай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уулзалт зохион байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар мэдээлэл өгч, санал солилцлоо.	“Хэрэгжих шатанд” – 70%	
10	21	**Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай** 2021-11-12, № 88 1.2/. Засгийн газраас дэвшүүлсэн төсвийн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн төрийн албанд ашиглаж байгаа суудлын автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, зэвсэгт хүчин, цагдаа, тагнуул, онцгой байдал, эрүүл мэндийн байгууллагаас бусад төрийн байгууллагын суудлын автомашины	**ТӨБЗГ – ТӨБАХ** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 195/260 дугаар хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталсан. Уг журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрийн өмчит нийт хуулийн этгээдэд мэдэгдэх, тухайн хуулийн этгээдийн автомашины тоо төрлийг тогтооход шаардлагатай мэдээллийг ирүүлэх талаар 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А-1/194 дүгээр албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Уг албан бичигт дурдсан шаардлагатай мэдээллийг төрийн өмчит хуулийн этгээдээс ирүүлснийг нэгтгэв. Эхний ээлжинд яамдын тоо төрлийг тогтоон батлуулахаар зорьж, тухайн яамнаас ирүүлсэн саналыг	“Бүрэн хэрэгжсэн” – 100 %	

	45	**Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2022-12-07, № 10 ҮББХ 2. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, төрийн өмчит компаниудын өмчлөлийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, өрсөлдөөнийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих, төрийн өмчит компаниудын комплайнсын асуудлыг судлах, сайн	“Бүрэн хэрэгжсэн” – 100 %	

		батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдүүдийг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, олон нийтэд нээлттэй худалдах бэлтгэл ажлыг хангах хүрээнд тулгамдаж буй асуудлыг судалж, Монгол Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах санал боловсруулж, өргөн мэдүүлэх;	туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас Франц улсын Парис хотод зохион байгуулсан 40 дэх удаагийн хэлэлцүүлэгт оролцож, OECD, EBRD болон БНХАУ-ын SASAC-тай цаашдын хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр тогтсон. OECD болон SASAC нар хамтран зохион байгуулсан 16 дахь удаагийн Азийн бүсийн төрийн өмчит компаниудын засаглалын чуулга, уулзалтад оролцож Азийн бүсийн улс, орнуудын Төрийн өмчит компанийн засаглалын бодлогын талаарх туршлагыг судаллаа. Төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах чиглэлээр томоохон ажлын эхлэл тавигдсан. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн хүрээнд: – “Төрийн банк” ХК-ийн нийт хувьцааны 5% буюу 34,745,000 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 590 төгрөгөөр тооцон 22.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж 5.71 хувийн хувьцааг 7306 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 67.3 тэрбум төгрөг; – “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хувьцааны 34% буюу 119,157,603 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 100 төгрөгөөр тооцон 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж 34 хувийн хувьцааг 7414 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 57.8 тэрбум төгрөг тус тус татан төвлөрүүлсэн болно. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй компани болгох, үр ашиг, засаглалыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 220 дугаар тогтоолоор авто замын засвар, арчлалтын чиглэлээр ажилладаг төрийн өмчит 20 компанийг нэгтгэн “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулсан. “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн дүрмийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 08 дугаар сарын 407 дугаар тогтоолоор баталсан. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, компанийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ТӨБЗГ-ын 527, 565 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилсон бөгөөд 485 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирлыг		

			томилох удирдамжийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд өгсөн. Цаашид ийнхүү нэгтгэл хэлбэрт оруулснаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар төлөвлөн ажиллаж байна. УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлын талаар санал боловсруулан хүргүүлсэн.		
	46	**Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2022-12-07, № 10 ҮББХ 4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийн үед төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг дээшлүүлэх, олон нийтийн оролцоо хяналтыг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр төсөлд тусгах санал, дүгнэлтээ танилцуулах.	**ТӨБЗГ – ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ** УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцээд Үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. Хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх үеэр эрх зүйн орчны шинэчлэлийн төсөлд тусгах асуудлаар УИХ-ын гишүүдэд тодорхой санал, дүгнэлтийг танилцуулах, мэдээлэл, тодруулга өгөх чиглэлээр оролцсон. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр МУИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна. Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор уг ажлын хэсэгт чиглэл өгсний дагуу тодорхой ажлуудыг нэмж хийхээр зохион байгуулалтын арга хэмжээ аван ажилласан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, эдгээр хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий уг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга нар ажиллаж байна. Дэд ажлын хэсэг хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 2023 оны 10 дугаар сард багтаан хүлээлгэн өгөхөөр ажилласан боловч хууль санаачлагчаас хуулийн төслийг эгүүлэн татаж, дахин өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.	“Хэрэгжих шатанд” – 70%	
	47	**Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2022-12-07, № 10	**ТӨБЗГ – ХЭЗХ, ТӨУЗХ**	“Хэрэгжих шатанд” – 70%	

		ҮББХ 2. Энэ тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр МУИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна. Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор уг ажлын хэсэгт чиглэл өгсний дагуу тодорхой ажлуудыг нэмж хийхээр зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллав. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, эдгээр хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий уг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга нар ажиллаж байна. Дэд ажлын хэсэг хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 2023 оны 10 дугаар сард багтаан хүлээлгэн өгөхөөр ажилласан боловч хууль санаачлагчаас хуулийн төслийг эгүүлэн татаж, дахин өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.		
24	48	**Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2023-04-11, № 03 ҮБХ 1.1/. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, мөн зах зээл дэх төрийн оролцоог багасгах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг ханган засаглалыг сайжруулах зорилгоор хувьцааг нь олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг Монгол Улсын урт,	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. Энэ хүрээнд ТӨБЗГ нь 2022 оны “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авсан. Мөн 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажлын хэсэг автозам засвар, арчлалтын компаниудын болон “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн нэмэлт хувьцаа “IPO” гаргах талаар танилцуулга болон тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх санал зэргийг танилцуулсан. Үүний үр дүнд Засгийн газрын 244 дүгээр тогтоолд зохих өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг ханган ажилласан.	“Хэрэгжих шатанд” – 70%	

		дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд “Төрийн банк” ХК-ийн нийт хувьцааны 5% буюу 34,745,000 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 590 төгрөгөөр тооцон 22.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж 5.71 хувийн хувьцааг 7306 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 67.3 тэрбум төгрөг;“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хувьцааны 34% буюу 119,157,603 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 100 төгрөгөөр тооцон 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж 34 хувийн хувьцааг 7414 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 57.8 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн болно. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй компани болгох, үр ашиг, засаглалыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 220 дугаар тогтоолоор авто замын засвар, арчлалтын чиглэлээр ажилладаг төрийн өмчит 20 компанийг нэгтгэн “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулсан. “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн дүрмийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 08 дугаар сарын 407 дугаар тогтоолоор баталсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж, тус нэгтгэл компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах ажлуудыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гүйцэтгэж томилгооны асуудлыг шийдвэрлэсэн. Цаашид нэгтгэл хэлбэрт оруулж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар төлөвлөн ажиллаж байна. УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлын талаар санал боловсруулан хүргүүлсэн. Мөн Монгол Улс дахь Өмч хувьчлалын явц, Улсын Их Хурлаас баталсан Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаарх танилцуулга, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А-1/1977, А-1/1976 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.		

	49	**Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2023-04-11, № 03 ҮБХ 1.2/. Хувьцаагаа нийтэд худалдсан төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, Монгол Улсын Их Хурлаас батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого’’-д нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлын хэрэгжилтийг хангах;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, засаглалыг сайжруулах чиглэлээр 3 хэсэгт хуваан авч үзэн санал боловсруулж, ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 5 дугаар тэмдэглэл гарган, саналын хамтаар ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үүнд: 1.Стратегийн ач холбогдолтой болон бусад томоохон төрийн өмчийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үнэ цэн бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх замаар өгөөжийг өсгөх, Үндэсний баялгийн санг бүрдүүлэн Монгол Улсын эдийн засагт хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-д уул, уурхайн салбарын компаниудыг нэгтгэн нэгдлийн хэмжээнд ажиллуулах. 2.“Эрдэнэс Монгол” нэгдэлд хамааруулснаас бусад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг “Төрийн өмчийн корпорац” ТӨХХК байгуулж, харьяалуулан нэгтгэх. 3. Одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд төрийн өмчит үйлдвэрийн газруудыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад харьяалуулах. Уул, уурхайн компаниуд нэгдлийн хэмжээнд ажиллаж эхэлсэн бөгөөд Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийг Засгийн газрын тогтоолоор тогтоосон. Ерөнхий сайдын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 130 дугаар захирамжаар эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудыг үндсэн үйл ажиллагааны чиглэлийг нь харгалзан өөрчлөн зохион байгуулах, хэрэглэгчдэд үйлчлэх төвийн чиг үүргийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судлан үзэж санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Төрийн өмчит компаниудын үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Авто замын засвар арчлалтын ажил эрхэлдэг төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулсан. ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 407 дугаар тогтоолоор уг нэгтгэл компанийн дүрмийг баталсан болно. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүднээс “Төрийн өмчийн корпорац” байгуулах тухай асуудлыг судлан, холбогдох санал, тогтоолын	“Хэрэгжих шатанд” – 70%	

			төсөл, танилцуулгыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд уг журмаар төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн чиг үүргийг тодорхой болгон шийдвэрлэсэн. Мөн Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам” баталж, мөрдүүлээд байна.		
25	50	**Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2023-04-25, № 05 ТБХ 3а/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, **өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах**, **хэрэгжиж дууссан төслүүдийн хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах,** зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн муутай, хэрэгжилт удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах;	**ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨХШХ** ТӨБЗГ-ын 2023 оны хуралдаанаар зээл, хандив тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг төрийн өмчид бүртгэх тухай асуудлыг хэлэлцэж, гаргасан 10 тогтоолоор нийт 84,939,788,645.93 (84.9 тэрбум) төгрөгийн хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэсэн байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	
	51	**Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2023-04-25, № 05 ТБХ 4а/. төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын биет болон биет бус хөрөнгийг бүртгэх, хянах тогтолцоог сайжруулж, өмчийн бүртгэл,	**ТӨБЗГ – ТӨБАХ, ХЭЗХ** Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын биет болон биет бус хөрөнгийг бүртгэх, хянах тогтолцоог сайжруулж, өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим систем бий болгох, нэгдсэн мэдээлэл, дүнг холбогдох байгууллагад мэдээлэх, танилцуулахтай холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Их Хуралд өргөн баригдаж, нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэгдэж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан болно.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	

		мэдээллийн нэгдсэн цахим систем бий болгох, нэгдсэн мэдээлэл, дүнг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод жил бүр танилцуулахтай холбоотой зохицуулалтыг хууль тогтоомжид оруулах санал бэлтгэх, танилцуулах;	2022 онд зохион байгуулсан төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод хөгжүүлэн ашигласан эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн системийг тодорхой түвшинд өргөжүүлж, зарим мэдээллийг нэмэх, боловсруулах, тухайлбал, хөрөнгийн орлого, зарлага, шилжилт хөдөлгөөн, их засвар, капиталжуулалт, данснаас хасах зэрэг үйлдлийг нэмж оруулан ашиглаж, 2022 оны улсын нэгдсэн статистикийн мэдээ тайланг гаргасан. Уг статистик мэдээнд төрийн болон орон нутгийн өмчит нийт 7113 хуулийн этгээдийн өмчийн талаарх захиргааны статистикийн мэдээ тайланг цахимаар авч нэгтгэн тусгасан. Нэгдсэн статистик мэдээг 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний Статистикийн хороонд medee@nso.mn цахим хаягаар хуулийн хугацаанд хүргүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн цахим системийг бий болгох асуудлыг тусгуулсан. Улмаар уг системийг бий болгоход шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийн зардлын төсвийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар шийдвэрлэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусган батлагдсан.		
	52	**Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2023-04-25, № 05 ТБХ 4б/. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтэц, орон тоо, зардлын зохистой байдлыг бий болгох, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын ил тод байдлыг хангах хүрээнд биржээр дамжуулан борлуулж, ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлэх, татварын дараах ашгийг хуваарилах, олон нийтийн оролцоог хангасан сайн засаглалтай болгох, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод болгох, тэдний эрх үүрэг, хүлээх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид нарийвчлан зохицуулах санал бэлтгэх, танилцуулах.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг төлөвлөх, хэрэгжилт, гүйцэтгэлийн хяналтыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд компаниудын мэдээллийг ил тод болгох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх үүднээс ТӨБЗГ-аас харьяа компани, үйлдвэрийн газруудад төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хянах, дүн шинжилгээ хийх, нийтэд ил тод мэдээлэх ажлыг эхлүүлсэн. Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж ажилласан - 45, Эрчим хүчний яам - 27, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар - 12 (Эрдэнэс монгол нэгдэл), Сангийн яам - 7, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам - 1, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам - 3, Зам, тээврийн хөгжлийн яам - 3 нийт 98 толгой (“Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа 23 охин, хараат компани, төслийн нэгж, Эрчим хүчний яамны харьяа 7 охин, хараат компани, харьяа 2 охин, хараат компаниудыг оролцуулаад) компани, үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засаг, үр ашгийн үзүүлэлтийг нэгтгэн товхимол гаргасан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 59,237.2 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж,	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	

			14,552.6 тэрбум төгрөгийн орлого олж, 2,075.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2021 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад орлого 36.7 хувиар буюу 3,903.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 100.4 хувиар буюу 1,040.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байв. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 20 хуулийн этгээд ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, 486 хүнийг журмын хүрээнд нээлттэй сонгон шалгаруулалтаар томилсон дүн мэдээтэй байна.		
	53	**Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2023-04-25, № 05 ТБХ 6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ЗУХ** 2024 оны төсвийн төлөвлөлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан хүргүүлсэн. Гүйцэтгэл хяналтыг Төрийн аудитын байгууллага болон бусад холбогдох байгууллагууд хийж байна. Байгууллагын хэмжээнд мэргэжлийн судлаач, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах төсөв тусгагддаггүй тул дээд шатны байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл авч төлөвлөдөг болно.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	
		УИХ-ын Байнгын хорооны тогтоол: 8 тогтоолын 15 заалт	**100% - 9 заалт; 70% - 5 заалт; ХБ. – 1.**	**Дундаж үнэлгээ: 89.29%**	
Дөрөв. Ерөнхийлөгчийн зарлиг					
26	54	**Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай** 2018-05-23, № 46 3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар,	**ТӨБЗГ – ЗУХ** Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, идэвх санаачилгыг өрнүүлэх талаар нийт албан хаагчдад мэдээлэн сурталчилж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн үзэл санааг дэмжин дэлгэрүүлэхэд анхааран ажиллаж байна. Байгууллагын мэдээллийн самбарын зарим хэсгийг монгол, кирилл бичгээр хослуулан бичиж, сурталчлан таниулах ажлыг хийсэн. Байгууллагын өрөө, танхимын хаягжилтыг шинэчилж, монгол бичиг, кирилл үсгээр хослуулан бичиж байршуулав. Мөн албан хаагчид аливаа мэдээллийг PPt танилцуулга хэлбэрээр бэлтгэхдээ байгууллагын нэрийг монгол бичиг, кирилл үсгээр хослуулан бичдэг болсон. ТӨБЗГ-ын албан хаагчдын монгол бичгийн унших, бичих чадварыг сайжруулах зорилгоор “Бичиг Соёл” төвтэй 2022 оны 11 дүгээр сарын 15-ний	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	

		холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	өдөр “Монгол бичгийн сургалт зохион байгуулах гэрээ”-г байгуулсан. Сургалтын зардалд байгууллагын 2022 оны төсвөөс нийт 3.2 сая төгрөгийг зарцуулсан. Энэхүү гэрээний дагуу сургалтыг 2023 оны 2 дугаар сараас эхлэх зохион байгуулж, байгууллагын нийт 35 албан хаагчийг 7 хоногт 3 удаагийн давтамжтайгаар 1 сарын хугацаанд нийт 30 цагийн монгол бичгийн сургалтад хамрууллаа. Амжилттай суралцаж, төгссөн албан хаагчдад “Бичиг Соёл” төвөөс гэрчилгээ олгосон байна.		
27	55	**Засгийн газарт чиглэл өгөх тухай (Тэрбум мод)** 2021-10-04, № 58 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	**ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ** “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид 2023 оны 10 дугаар сарын 14-ны өдөр нийслэлийн Хужир булан дахь “IGM” олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнд “Монголын төмөр зам” ТӨХК-тай хамтран 800 ширхэг буйлс, улиас модны суулгацыг тарив. 2023 онд ойн мэргэжлийн байгууллага болох “Ногоон байгууламжийг бий болгох мэргэжлийн байгууллага иргэдийн нөхөрлөл, бүлгүүдийг дэмжих сан” ТББ болон “Бухт Монголиан форест” ХХК-аас ирүүлсэн хамтран ажиллах санал, хүсэлтийг дэмжиж төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захирал нарт уламжлан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд идэвхтэй оролцохыг уриалсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 49 хуулийн этгээдтэй хамтран өрнүүлж, нийслэл, 7 аймгийн 19 газарт 12 төрөл зүйлийн 4.0 сая гаруй модыг тарьж суулгаад байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээд дэргэдээ хүлэмж байгуулж, тарьц, суулгацыг бойжуулан ажилласан байна. "Эрдэнэс Монгол" нэгдлийн хэмжээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжин 391.3 сая мод тарихаар төлөвлөсөн байна. Үүний 50 сая мод хангайн бүсэд, 83.2 сая мод ойт хээрийн бүсэд, 57 сая мод хээрийн бүсэд, 115.5 сая мод говийн бүсэд, 10.6 сая мод өөрийн эзэмшлийн талбайд, 31.9 сая мод орон нутагт, 40 сая мод дүйцүүлэх арга хэмжээнд тарих юм. Одоогоор 3,322,256 мод тариад байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ "Ойн генетикийн нөөцийн төв" байгуулан ААН болон иргэдийн оролцоотой нээлттэй өдөрлөг явуулж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг сурталчилсан. "Хөрсний төв" байгуулах барилгын ажил хийгдэж байгаа бөгөөд 2024 онд ашиглалтад оруулна. “Монгоросцветмет” ТӨҮГ 2030 он хүртэл 2.0 сая мод тарихаар амлалт авч, төлөвлөгөөтэй ажиллаж байна. “Бор-Өндөр” уулын баяжуулалтын үйлдвэрийн дэргэд байгуулсан хүлэмжид навчит модны 15.0 мянга,	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	

			шилмүүст модны 160.0 мянга орчим модны тарьц бойжуулсан байна. Үндэсний хөдөлгөөний хүрээнд “Монголросцветмет” ТӨҮГ нь 2021-2023 онд нийт 280.6 мянган модыг Баянзүрх дүүрэг, Хэнтий, Дорноговь, Дундговь, Төв, Булган аймгуудын нутагт тариад байна. Энэ ажилд томоохон төрийн өмчит компани, үйлдвэрийн газрууд тухайлбал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ идэвх санаачилгатай ажиллаж, өөрсдийн дэвшүүлсэн бүтээлч зорилтуудаа хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.		
28	56	**Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай** 2022-07-11, № 159 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	**ТӨБЗГ – ЗУХ** Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах ажилд шаардлагатай төсвийг шийдвэрлэж, байгууллагын даргын өрөөнд хүндэтгэн залсан болно.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай.
	57	**Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай** 2022-07-11, № 159 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	**ТӨБЗГ – ЗУХ** Ерөнхийлөгчийн зарлигийг албан хаагчдад таниулан сурталчилж, агуулга, үзэл санааг нь эрхэмлэн тунгааж, үйл хэрэгтээ тусган хэрэгжүүлэх, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн сургах талаар уриалгыг түгээсэн.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	
		Ерөнхийлөгчийн зарлиг: **3 зарлигийн 4 заалт.**	**100% - 4 заалт.**	**Дундаж үнэлгээ: 100%**	
Тав. Засгийн газрын тогтоол					
29	58	**Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2021-04-07, № 89	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн батлагдсан ТЭЗҮ-д 2023 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн ч гүйцэтгэгчээс давагдашгүй хүчин зүйл учирсан шалтгаанаар төслийг 2024 оны 1 дүгээр	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	“Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд шилжсэн

		3. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийг ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн “Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлэхээр тооцож, тус компанийн хө”рөнгөд бүртгүүлэх арга хэмжээг авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.	улиралд хэрэгжүүлж дуусгахаар хойшлуулаад байна. Ачилтын нэгдсэн төв байгуулах төслийн гүйцэтгэл 87.77 хувьтай байна. Төслийн ихэнх овор хэмжээ томтой, голлох төхөөрөмжүүдийг угсрах ажил дуусаж байна. Төслийн нийт санхүүжилтэд 266.2 тэрбум төгрөгийг олгоод байна.		тул хяналтаас хасуулах саналтай.
30	59	**Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай** 2021-05-05, № 129 2. Энэ тогтоолын 1-д заасан үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр”, “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр” болон “Засвар, механикийн заводын өргөтгөл”-ийг тус тус “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** 1.“Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” барих хүрээнд: үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэрийн төслийг БНХАУ-ын China ENFI Engineering (ENFI) компанитай хамтран хэрэгжүүлж байна. Үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэр барьж, туршилт хийх ажлыг БНХАУ-ын Шинжан Уйгарын өөртөө засах орны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн “Xinxin Metals” компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Үйлдвэрээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын ажил эхэлсэн. Үйлдвэрлэлийн туршилтын хамтарсан гэрээний дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн. шигшсэн нүүрсийг БНХАУ дахь туршилтын үйлдвэрт тээвэрлэж хүргэсэн. ТЭЗҮ-д шаардлагатай голлох үр дүнгүүдийг ойрын хугацаанд хүлээн авч, хамтран тодотгол хийж, гүйцэтгэхээр 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн уулзалтаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон ENFI компанийн удирдлагууд харилцан тохиролцсон. Үйлдвэрийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг шинэчлэн боловсруулж байна. Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг үйлдвэрийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. 2. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь “SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний	“Хэрэгжих шатанд” - 70%	“Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд шилжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

			ажлыг “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-аар үргэлжлүүлэн хийж байна. Уг ажилд Ажлын хэсэг хяналт тавин ажиллаж байна. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ) хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2023 оны 10 дугаар сарын 20-нд гэрээ байгуулсан. Исэлдсэн хүдэр боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн техник, технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж, батлуулсан. 3. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр шинээр барих ажлыг 2020 оны 05 дугаар сард байгуулсан “түлхүүр гардуулах” нөхцөлтэй гэрээний дагуу “Монголиан Инвестмент Корпорэйшн” ХХК гүйцэтгэж байна. Төслийн ашиглалтад оруулах хугацааг 2023 оны 06 дугаар сарын 30 хүртэл сунгасан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ажлын хэсэг уг төслийн ажилд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлэж, зохих арга хэмжээ аван ажиллаж байгаа боловч гүйцэтгэгч компаниас шалтгаалан ажил удаашралтай явагдаж байна. 4.Засвар, механикийн заводын өргөтгөл, шинэчлэлийн төсөл 3 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд Цутгуурын үйлдвэрлэлийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл, шинэчлэлийн барилга байгууламжийг барих ажлын гүйцэтгэл 45.9 хувьтай, Механик цехэд өргөтгөл, шинэчлэл хийх гүйцэтгэгчийн тендерийг зарласан, Шинэ Цутгуурын цехийн барилга байгууламж, дэд бүтцийн зураг төсөл боловсруулах ажлыг 2023 онд хийж, барьж байгуулах ажлыг 2024 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.		
	60	**Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай** 2021-05-05, № 129 3. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газартай Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4-т заасны дагуу гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), **хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг хуульд заасан журмын дагуу төрийн өмчид бүртгэж авахыг Төрийн өмчийн**	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ** Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр”, “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр” болон “Засвар, механикийн заводын өргөтгөл”-ийн төслүүд хэрэгжиж дуусаагүй, үйлдвэрүүд нь ашиглалтад ороогүй байгаа болно. Иймээс хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг төрийн өмчид бүртгэж авах хугацаа болоогүй байна.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	Урт хугацаанд хэрэгжих төсөл.

		бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.			
31	61	**Хөрөнгө гаргах тухай** 2021-10-27, № 334 1. Замын-Үүдийн хилийн боомтын бүсийг ногоон бүс болгох зорилгоор “Замын-Үүд” чөлөөт бүсэд хилийн хяналтын байгууллагын албан хаагчид болон ачаа тээврийн жолооч нарыг тусгаарлан байрлуулах байр, сууц байгуулахад шаардагдах 948,248,000 (есөн зуун дөчин найман сая хоёр зуун дөчин найман мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй. 3. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг зохих журмын дагуу төрийн өмчид бүртгэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т нарт даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ** Замын-Үүдийн хилийн боомтын бүсийг ногоон бүс болгох зорилгоор “Замын-Үүд” чөлөөт бүсэд хилийн хяналтын байгууллагын албан хаагчид болон ачаа тээврийн жолооч нарыг тусгаарлан байрлуулах байр, сууц байгуулж, улсын комисс хүлээж авсны дараа шинээр бий болсон хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэнэ. ТӨБЗГ-ын гүйцэтгэх ажлын хугацаа болоогүй, хүлээгдэж байна.	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-ХБ.	
32	62	**Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** 2022-01-05, № 07 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3.	**ТӨБЗГ – ЗУХ, Бүх хэлтэс, алба** Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, идэвх санаачилгыг өрнүүлэх талаар нийт албан хаагчдад сурталчлан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар зарлигийн үзэл санааг дэмжин дэлгэрүүлэх, энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна. Байгууллагын мэдээллийн самбарын зарим хэсгийг монгол, кирилл бичгээр хослуулан бичиж, шинэчилсэн. Байгууллагын өрөө, танхимын хаягжилтыг шинэчилж, монгол бичиг, кирилл үсгээр хослуулан бичиж байршуулав. Мөн албан хаагчид аливаа мэдээлэл, танилцуулгыг PPt хэлбэрээр бэлтгэхдээ байгууллагын нэрийг монгол бичиг, кирилл үсгээр хослуулан бичдэг болж, монгол бичгийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг тодорхой хэмжээнд өрнүүлсэн байна.	“Бүрэн хэрэгжсэн” – 100 %	

		төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.			
33	63	**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хараат бус гишүүнийг томилох тухай** 2022-04-20, № 167 3.Компанийн бизнесийн стратегийг тодорхойлж, сайн засаглалын зарчмын дагуу удирдлагыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Компанийн тухай хууль болон бусад холбогдох журам, дүрмийн хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүд, хараат бус гишүүдийг сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарлаж, тухайн компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтыг зохион байгуулан дүгнэлт гаргаж, шаардлага хангасан нэр дэвшигчийн материалыг Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэн шийдвэрлүүлж байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-т тусгагдсан зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”, “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, “Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ыг мөрдөн хэрэгжүүлж байна. Түүнчлэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”, мөн 2023 оны 174 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал”-ыг мөрдүүлэх арга хэмжээ аван ажиллав. Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллахад	“Бүрэн хэрэгжсэн” – 100 %	Энэ ямар компанитай холбоотой нь тодорхойгүй байгаа тул ерөнхий ойлголтын хүрээнд хэрэгжилтийг бичив. Легалинфо эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2022 оны 167 дугаар тогтоол байхгүй, ТӨБЗГ-т энэ тогтоол ирээгүй, бүртгэгдээгүй. “Эрдэнэс Монгол” ХХК-тай холбоотой гэж үзэн цаашид хяналтаас хасуулах саналтай. ТӨБЗГ-т хамааралгүй.

			анхаарч, компанийн засаглалын зарчмыг баримталж, хуулиар тогтоож, хүлээлгэсэн үүрэгтэйгээр ажиллаж байна.		
34	64	**Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** 2022-05-25, № 203 2. Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах санал боловсруулж, 2022 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ, ХЭЗХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний үнэ тариф, зардлын норм, норматив болон Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишгийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг Бүгд Найрамдах Турк Улс, Болгар, Казахстан, Хятад Ард Улсуудын төрийн захиргааны байгууллагын албан ажлын өрөө, тасалгааны нийтлэг жишиг, стандартын журмуудыг судалсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор яам болон агентлагуудаас төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалтын судалгаа авч нэгтгэсэн. Ажлын хэсэг нэгдсэн санал дүгнэлт гарган Засгийн газрын Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-т өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэн Монгол Улсын сайд Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А-1/2029 дугаар албан бичгээр танилцуулга болон холбогдох баримт материалыг хүргүүлсэн болно.	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	Цаашид хяналтаас хасуулах саналтай.
35	65	**Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** 2022-05-25, № 204 3. Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын	**ТӨБЗГ – ТӨБАХ** Засгийн газрын 204 дүгээр тогтоолын дагуу 437 автомашиныг татан төвлөрүүлсэн. Тэдгээрийг Засгийн газрын автобааз болон бусад байршилд байршуулж, 2022 онд хэрэгцээ шаардлагыг эрэмбэлсний үндсэн дээр зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байгууллагад нийт 85 автомашиныг балансаас баланст шилжүүлсэн, нийт 161 автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан 888.0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн. Үлдэх өртөгтэй нийт 59 автомашиныг УИХ-ын тогтоолын төсөлд тусгаж, орон нутгийн өмчит эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад шилжүүлэх (ашиглалтын гэрээ байгуулах замаар)-ээр тогтсон бол үлдэх өртөгүй нийт 80 автомашиныг данснаас хасаж, засвар үйлчилгээ хийж сэргээх, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож орон нутгийн өмчид бүртгэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай байна.

		болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байна. 2022 онд “Засгийн газрын автобааз” ТӨҮГ-т 52 автомашин шилжүүлж, парк шинэчлэлт хийсэн. Эдгээрийн үр дүнд нийт 3.8 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан. “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газар, яам, агентлаг, төр засгийн байгууллагуудын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардлагатай тээвэрлэлтийн нийтлэг үйлчилгээгээр хангах чиг үүргийнхээ хүрээнд Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-д заасан эрх бүхий албан тушаалтанд автомашины үйлчилгээ үзүүлэхээс гадна Улаанбаатар хотод дуудлагын, орон нутагт томилолтоор ажиллахад шаардлагатай автомашины үйлчилгээ гэсэн чиглэлээр үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 2023 онд тус үйлдвэрийн газар нь автомашин дуудлага худалдаа зохион байгуулж, автомашин худалдан борлуулаагүй болно. 2023 онд ТӨБЗГ-ын 2023 оны 26, 604 дүгээр тогтоолоор 120 автомашиныг орон нутгийн өмчит нийт 145 байгууллагад шилжүүлсэн бол ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 679 дүгээр тогтоолоор 12 автомашиныг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гаргаж, “Засгийн газрын авто бааз” ТӨҮГ-т шилжүүлсэн.		
	66	**Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** 2022-05-25, № 204 5. Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний үнэ тариф, зардлын норм, нормативыг боловсруулж Сангийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар батлуулан мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ, ХЭЗХ** Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах журам”-ыг баталсан. Журмыг мөрдөх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Чиглэл хүргүүлж, санал авах тухай” А-1/194 дүгээр албан бичгээр төрийн өмчит хуулийн этгээдүүдэд чиглэл хүргүүлж, журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулав. Автомашины дуудлагын үйлчилгээ үзүүлэх ажлыг “Засгийн газрын авто бааз” ТӨҮГ хариуцан ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагаандаа Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Зардлын норматив батлах тухай” 279 дүгээр тушаалыг мөрдлөгө болгон ажиллаж байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
	67	**Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**	**ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ, ЗУХ** Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилогдон ажиллаж, тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас

		2022-05-25, № 204 10. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, явц байдлыг шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	ажиллахаас гадна шаардлагатай тухай бүрд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Засгийн газрын хуралдаанд танилцуулан ажиллав. Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-д “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Уг асуудлыг УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай асуудлыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн байна. УИХ-ын гишүүдийн зарчмын зөрүүтэй санал гарсантай холбоотой тогтоолын төслийг хууль тогтоомжийн санаачлагчид буцаасан тул УИХ-ын тогтоолын төслийг дахин өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна. Мөн хяналтад авсан заалтын хэрэгжилтийн талаарх сар бүрийн явц, хагас, бүтэн жилийн тайлан мэдээллийг ЗГХЭГ-т тухай бүр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулж, тайлагнан мэдээлсэн.		хасуулах саналтай.
36	68	**Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай** 2022-05-31, № 220 1.1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан дараах зээлийн өр төлбөрийг барагдуулах дор дурдсан арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүн, хуулийн этгээдийн удирдлагад тус тус даалгасугай: 1.1. “Буянт-Ухаа-1”, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар “Төрийн орон сууцны корпорац” ХХК-д олгосон 142,693,633,474.83 (нэг зуун дөчин хоёр тэрбум зургаан зуун ерэн гурван сая зургаан зуун гучин гурван мянга дөрвөн зуун далан дөрвөн төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн зээлийн үндсэн төлбөр, гэрээний дагуу тооцсон үндсэн болон нэмэгдүүлсэн хүүгийн нийт дүнд “Төрийн орон сууцны корпорац” ХХК-аас үнэт	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-д олгосон 142,693,633,474.83 төгрөгийн үндсэн зээлийн төлбөр, гэрээний дагуу тооцсон үндсэн хүү болон нэмэгдүүлсэн хүүгийн нийт дүнгээр үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авснаар дор дурдсан үр дүн гарсан. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Бүртгэлийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас ““Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн өрийн хэрэгслийг бүртгэх тухай” БХ22/77 дугаартай тогтоол гарсан. Улмаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК нь нийт 180.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий, 60 сарын хугацаатай, 8.5%-ийн хүүтэй бондыг гаргаж, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр анхдагч зах зээлийн арилжаа хийгдсэнээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1”, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар авсан зээл, түүний хүү болох нийт 185.65 тэрбум төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулсан. Үнэт цаас гаргасантай холбоотойгоор Хөгжлийн банктай 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан 2/107 дугаартай "Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ"-ний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн өмчлөлийн газар болон түрээсийн орон сууцны санд шилжсэн орон сууцнуудыг барьцаалсан бөгөөд барьцааны гэрээнүүдийг улсын бүртгэлд бүртгүүлэх ажиллагаа хийсэн байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

		цаас гаргаж, Монгол Улсын Хөгжлийн банканд эзэмшүүлэх замаар зээлийн өрийг төлөх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Ганбат)-д;	“Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-иас үнэт цаасны хүүгийн төлбөрт хуваарийн дагуу 2023 оны 06 сарын 20-ны өдөр 7.6 тэрбум төгрөгийг Хөгжлийн банканд төлсөн байна.		
	69	**Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай** 2022-05-31, № 220 3. Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлийн өр төлбөрийг хугацаанд нь төлөхгүй байгаа, зээлийг зориулалтын бусаар ашигласан зэргээр зээлийн гэрээ зөрчсөн зээлдэгчдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах, төрд учирсан хохирлыг нэхэмжилж барагдуулах, гэм буруутай этгээдэд холбогдох хуулийн хүрээнд хариуцлага хүлээлгэх талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Ганбат)-д тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** 1.“Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК нь “Буянт-Ухаа 1”, “Буянт-Ухаа 2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар Хөгжлийн банкнаас авсан зээлийн үлдэгдэл өр төлбөр болох 142,693,633,474.83 төгрөгийг Засгийн газрын энэхүү тогтоолын дагуу 5 жилийн хугацаатай бонд гаргаж, Хөгжлийн банкны өр төлбөрийг барагдуулсан. 2.ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн хариуцан төлөх 24,604,103,971 төгрөгийг “Нью яармаг хаусинг прожект” ХХК-иас үл хөдлөх хөрөнгөөр төлж барагдуулсан. Хөгжлийн банк дахь “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн нэр дээрх “Шинэ яармаг” төслийн зээлийн өр төлбөр төлөгдөж дууссан. 3.“Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн нэр дээрх Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зээлийн өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/374, А96 дугаартай хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулагдан Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зээлийг балансаас баланст шилжүүлэх, тоног төхөөрөмжийн үнийг төсөвт тусгах тухай тогтоолын төслийг бэлтгэн холбогдох яамдаас санал авах ажлыг хийсэн байна. 4.“МИАТ” ТӨХК-ийн BOEING767-300ER агаарын хөлгийг худалдан авах зориулалтаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн үлдэгдлийг 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр мөнгөн хэлбэрээр төлж барагдуулсан. 5.“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-аас “Хөтөл” ХХК-ийн авсан өр төлбөртэй холбоотой Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дээр Зээлийн гэрээний үүрэгт 389,055,659,842.00 төгрөгийг гаргуулах талаар хэрэг үүссэн байгаа бөгөөд тус хэрэгт хамтран хариуцагчаар “Цемент шохой” ТӨХК оролцож байна. Тус хэргийн оролцогчидтой холбоотой эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх, арбитрын журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг (“Бэйзмэнт” ХХК (“Хөтөл” ХХК)-ийн өв залгамжлагч нь	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 258 дугаар тогтоолоор “Цемент шохой” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд шилжүүлж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК-ыг тогтоосон.

			Б.Тулга мөн эсэх асуудал тодорхой болох хүртэл), маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй үндэслэлээр түдгэлзсэн байна. Шүүх хурал 18 удаа хойшилсон ба одоогийн байдлаар дээрх шалтгааны улмаас түдгэлзсэн байна. Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 258 дугаар тогтоолоор “Цемент шохой” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд шилжүүлж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК байхаар тогтоосон болно. 6.“Эрдэнэс Монгол” ХК-ийн мэдээлэл: 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан нийт зээлийн үлдэгдэл 42.6 тэрбум төгрөг, хуримтлагдсан хүүгийн өглөг 877 сая төгрөг, нийт 43.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан. Гүйцэтгэх захирлын 2023 оны 4 дүгээр 19-ны өдрийн 01/296 тоот албан бичгээр Хөгжлийн банканд хандсан ба хуваарийн дагуу төлөлт хийсний дүнд зээлд 42.6 тэрбум төгрөг, зээлийн хүүд 3.2 тэрбум төгрөг, нийт 45.85 тэрбум төгрөгийн өр төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.		
37	70	**“Эрдэнэс Монгол” нэгдлийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-06-08, № 225 2.“Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа, стратеги болон бизнес төлөвлөгөө, тухайн жилийн зорилтот түвшний үзүүлэлт, хөрөнгө оруулалт, нийт үр ашгийг нэгдлийн хэмжээнд уялдуулан төлөвлөх саналаа боловсруулан энэ оны 8 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Энх-Амгалан)-д даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон “Монголросцветмет” ТӨҮГ-ыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд оруулахтай холбоотой энэхүү Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2019 оны 102, 103 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын дүрэмд Засгийн газрын 2022 оны 427, 428 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн. Уг дүрмийн өөрчлөлтөөр “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа, стратеги болон бизнес төлөвлөгөө, тухайн жилийн зорилтот түвшний үзүүлэлт, хөрөнгө оруулалт, нийт үр ашгийг нэгдлийн хэмжээнд уялдуулан төлөвлөх, батлах асуудлыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эрх хэмжээнд хамааруулан шийдвэрлэсэн. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулсан Засгийн газрын шийдвэр гарсан. Монгол Улсын Засгийн газраас Төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа, засаглалыг сайжруулахад онцгой анхаарч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд 2021, 2022 онуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 2022, 2023 онуудад дүрмийг шинэчлэн баталсан байна. “Эрдэнэс Монгол” нэгдлийг группын зохион байгуулалтад оруулан зэс, металлын болон нүүрс, эрчим хүчний групп болгох холбогдох шийдвэрийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын үйл ажиллагаа, стратеги болон бизнес төлөвлөгөө, тухайн жилийн зорилтот түвшингийн үзүүлэлт, хөрөнгө	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Шаардлага-тай арга хэмжээг авч, нэгдлийн хэмжээнд тус үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг явуулж эхэлсэн, Засгийн газрын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн холбогдох шийдвэрүүд гарсан тул цаашид хяналтаас хасах саналтай.

			оруулалт, нийт үр ашгийг нэгдлийн хэмжээнд уялдуулан төлөвлөх саналаа бэлтгэн Хувьцаа эзэмшигчид танилцуулсан. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 45 дугаар тогтоолоор “Нэгдлийн компани, хуулийн этгээдийг группийн зарчмаар ажиллуулах түр журам”-ыг батлан мөрдүүлж байна. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2022.12.20, 2022.12.28-ны өдрийн хурлуудаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2023 оны бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинг хэлэлцэн 52, 53, 54, 55 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.		
38	71	**Агаарын тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-06-22, № 238 4. “МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагааны менежментийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засаг, санхүүгийн бие даасан, тогтвортой байдлыг хангуулах арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “МИАТ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Мөнхтамир)-д тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагаа менежментийг сайжруулах талаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: 1. 2022 оны навигацийн өглөгөөс чөлөөлүүлэх асуудлын хүрээнд Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” 93 дугаар тогтоолоор “МИАТ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Нийслэлийн Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороонд байршилтай 6.0 тэрбум төгрөгийн 17 нэрийн хөрөнгийг ИНЕГ-т шилжүүлсэн; 2. Франкфуртын нислэгийн татаас 4.7 тэрбум төгрөгийг 07 дугаар сарын 06-ны өдөр хүлээн авч, Монгол Улсын хөгжлийн банкны зээлийн төлбөрт 100 хувь шилжүүлсэн; Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон агаарын тээврийн 4 тээвэрлэгч компанийн төлөөллийг оролцуулсан хамтарсан уулзалт зохион байгуулсан. Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцүүлэн 365 дугаар тогтоолоор Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын 2 дахь заалтын “…иргэдийн төлөх зээлийн нийт хүүгийн 10.0 нэгж хүртэл хувийг,” гэсний дараа “хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээлийн нийт хүүгийн 7.0 нэгж хувийг” гэсэн агуулгаар нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлсэн. 2023 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Монголбанк, арилжааны банкуудын хамтарсан “Зээлийн гэрээ”-г байгуулсан. Гуравласан гэрээний дагуу тээвэрлэгч компаниуд арилжааны банкуудаас зээл авах эрх нь үүссэн бөгөөд Голомт банк, Хаан банктай хийсэн гэрээний дагуу эргэлтийн хөрөнгийн болон дахин санхүүжилтийн нийт 45.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2023 оны 6 дугаар сард	“Хэрэгжих шатанд” - 70%	

			авсан бол 8 дугаар сард 9.0 тэрбум төгрөгийг хөнгөлөлттэй зээлийг шинээр нэмж авсан байна.		
39	72	**Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай** 2022-06-29, № 244 3. Төрийн өмчит хуулийн этгээдийг олон нийтийн шууд хяналтад оруулах бодлогын хүрээнд энэ тогтоолын 1-д заасан хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, хувьцаа гаргах бэлтгэл хангах, биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгож, өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, ажлын явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд тухай бүр нь танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлын хүрээнд зарим хуулийн этгээдийг татан буулгах, нэгтгэх, хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй худалдаж, нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үе шаттай хэрэгжүүлж байна. “Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжсэн. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэл хангаж байна. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн тухайд төрийн эзэмшлийн хувь 66% байх хэмжээнд нэмэлт хувьцаа гаргахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56.5 дахь хэсэг /5%/ заасан зохицуулалт нь хамаарах эсэх асуудлаар тодорхой чиглэл авахаар ЗГХЭГ-т ТӨБЗГ-ын 2023.10.24-ний өдрийн А-1/1975 дугаартай албан бичгийг хүргүүлээд байна. Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын дагуу өөрчлөн зохион байгуулагдсан “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн дүрмийг ТӨБЗГ-ын 2023 оны 407 дугаар тогтоолоор баталсан. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, компанийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ТӨБЗГ-ын 527, 565 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг томилж, 485 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирлыг томилох удирдамжийг Төлөөлөн удирдах зөвлөлд өгсөн. Цаашид нэгтгэл хэлбэрт оруулснаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар төлөвлөж байна. Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах (IPO гаргах) бэлтгэл ажлын явцыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтмол танилцуулж байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	
40	73	**Агентлаг байгуулах тухай** 2022-07-05, № 272 5. “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын орон тоо, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэг	**ТӨБЗГ – ТӨБАХ** Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Ойн газрыг байгуулж, татан буулгасан “Ойн судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгө, авлага, өр төлбөрийг шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг БОАЖ-ын сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/450	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай.

		эд хөрөнгө, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газрын чиг үүрэг, орон тоо, цалингийн сан, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг Ойн газарт тус тус шилжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	дугаар тушаалаар байгуулагдсан. Тус ажлын хэсэг хөрөнгийг газар дээр нь үзэж, хяналтын тооллого хийсэн. “Ойн судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгө, авлага, өглөгийн тооцоог баталгаажуулан шилжүүлэх ажиллагааг хийж, хаалтын баланс гарган шинээр байгуулагдсан байгууллагын үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 508 дугаар тогтоолоор “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 490,368,408.00 төгрөгийн хөрөнгө, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 559 нэрийн, нийт 11,052,243,876.40 төгрөгийн балансын үнэ, 2,706,971,390.86 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Ойн газарт балансаас баланст шилжүүлсэн.		
41	74	**Төрийн өмчит зарим үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай** 2022-08-24, № 317 4.“Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн батлахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. 4. “Геологийн судалгааны төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, “Геологийн төв лаборатори” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих журмын дагуу “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт шилжүүлэх, данс, бүртгэлд тусгуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ** “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ААТТӨҮГ-ын захирал, ерөнхий геологи, ерөнхий инженерийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/274 дүгээр тушаалаар байгуулан ажиллуулав. Уг ажлын хэсэг үйлдвэрийн газрын захирлыг нээлттэй сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн мэдээллийг УУХҮЯ-ны 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/3407 дугаар албан бичгээр ТӨБЗГ-т ирүүлсэн. Тус саналыг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар нэр дэвшигч Д.Мөнхбаатарыг томилж, ажлын хэсэг томилон үүрэгт ажлыг 2023 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хүлээлгэн өгсөн. Мөн ТӨБЗГ-ын 2023 оны 5 дугаар тогтоолоор тус байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг баталсан. ТӨБЗГ-ын даргын 2023 А/8 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллуулсан. ТӨБЗГ-ын 2023 оны 20 дугаар тогтоолоор “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 14,942,178,574.49 төгрөгийн балансын үнэ, 5,491,164,849.66 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 5,784,639,866.65 төгрөгийн үнэ бүхий эргэлтийн хөрөнгө, өр төлбөрийг “Геологийн судалгаа-шинжилгээний төв” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас баланст шилжүүлсэн. ТӨБЗГ-ын 2023 оны 21 дүгээр тогтоолоор “Геологийн судалгааны төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 2,835,043,069.41 төгрөгийн балансын үнэ, 1,176,884,805.26 төгрөгийн	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай.

			хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгө, 1,017,403,189.83 төгрөгийн үнэ бүхий хөрөнгө, өр төлбөрийг “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас баланст шилжүүлсэн.		
42	75	**Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-09-14, № 340 1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Эрдэнэс Монгол” ХК нь бүх төрлийн ажил, үйлчилгээ худалдан авалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулж явуулдаг. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ нь Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ, Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалт эрхлэх чиг үүргийг “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ, Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь Мэргэшсэн жолоочийн сургалт зохион байгуулах чиг үүргийг 30 гаруй сургалтын байгууллагаар, Авто тээврийн хэрэгсэлд техник хяналтын үзлэг хийх чиг үүргийн хүрээнд 12 оношилгооны төв үйл ажиллагаа явуулж байгаагийн 9-ийг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна. Мөн “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК нь Биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, итгэмжлэл олгох чиг үүргийг ТББ-д шилжүүлэх, Биржийн байнгын гишүүн брокеруудыг сургах, мэргэшүүлэх ажлыг гүйцэтгүүлэх, Биржийн байнгын бус гишүүн хоршоодыг сургах, чадавхжуулах ажлыг гүйцэтгүүлэх, “Монгол шуудан” ХК нь Шуудангийн транзит тээврийн үйлчилгээ, Орон нутгийн шуудан тээврийн үйлчилгээг, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ нь Авто замын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны 112 нэр төрлийн ажлуудыг хувийн хэвшил, ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Авто замын засвар арчлалтын төрийн өмчит компаниуд Авто зам засвар арчлалтын үйлчилгээ 12 хувийн хэвшлийн компаниар гэрээ байгуулах замаар гүйцэтгүүлж байна. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК, “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК зэрэг төрийн өмчит үйлдвэрийн газар, компани нь зарим чиг үүргийг 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах байдлаар хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр үе шаттай гүйцэтгүүлэхээр холбогдох бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна. Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд нь үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг ханган явуулахад шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлан сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих журмын дагуу хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж ирсэн. Жишээлбэл, 2022 онд урсгал зардал, хөрөнгө оруулалтын хүрээнд 7 их наяд орчим төгрөгийн 5496 ширхэг бараа, ажил,	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	

			үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан 2023 онд сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байна.		
43	76	**Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай** 2022-10-05, № 362 2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг **ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилох эрх бүхий этгээд, Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгаж,** орон нутгийн өмч давамгайлсан эрх бүхий этгээдэд зөвлөсүгэй. 2.1.Засгийн газрын шийдвэргүйгээр төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ бүх төрлийн шинэ гэрээ байгуулахыг зогсоох; 2.2. Төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ болон төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээний дагуу, эсхүл төлбөр нь нэн даруй хийгдэх ашигт малтмалын экспортыг валютын бодит орох урсгалыг нэмэгдүүлэхээр оновчтой зохион байгуулах; 2.3.Ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой албаны болон байгууллагын нууцад хамааралтай гэрээ, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2022 оны 11 дүгээр сард багтаан нууцаас гаргаж, ил тод болгох	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Тогтоолын заалтаар өгсөн үүрэг, чиглэлийг харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд мөрдөн хэрэгжүүлэх талаар анхааран ажиллаж, хэрэгжилтийг хангуулж байна. "Эрдэнэс Тавантолгой" ХХК-ийн мэдээлэл: 2022 он дуустал 500 сая ам.долларын орлого төвлөрүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн. Засгийн газрын тогтоолоор компанид онцгой дэглэм тогтоосноос хойш нүүрс экспортыг 2 дахин, нүүрс тээврийг 4 дахин нэмэгдүүлэн 11.2 сая тонн нүүрс олборлож төлөвлөгөөгөө давуулан биелүүлж борлуулалтын орлогыг 1.1 тэрбум ам.долларт хүргэсэн. Ашигт малтмалыг олборлох, боловсруулах, тээвэрлэх зэрэг бүх дамжлагуудад цахим төлбөрийн системийг нэвтрүүлж, гаалийн системд мэдээлэл татагдаж ажиллаж байна. Ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ бүх төрлийн шинэ гэрээ байгуулахыг зогсоосон. Төслийн санхүүжилтийг нүүрсээр барагдуулах гэрээнүүдийн нийлүүлэлтийг бууруулж, бэлнээр төлбөр төлөх боломжтой гэрээнүүдийн нийлүүлэлтийг давуу байдлаар зохион байгуулан ажиллаж, эрчим хүчний нүүрсний нийлүүлэлтийг нийт нийлүүлэлтийн 15%-иас хэтрүүлэхгүй байдлаар зохион байгуулж байна. Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/693 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс компанийн ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой төрийн болон албаны нууцад хамааралтай гэрээний хууль зүйн үндэслэлд шинжилгээ хийж, нууцаас гаргах талаарх дүгнэлт, Засгийн газрын тогтоолын төслийг ЗГХЭГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, нууцаас гаргасан. Нууцаас гаргасан гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн www.ett.mn сайтад байршуулан олон нийтэд хүргэсэн. 2022 оны 11 дүгээр сараас эхлэн томоохон компаниуд болон Баяннуур аймгийн худалдан авагч нартай уулзалт зохион байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал нийлүүлэх нүүрсний төлбөрийг бэлнээр хүлээн авахтай холбоотой хэлэлцээ хийсний үр дүнд 588.8 сая ам.долларын үнэлгээ бүхий 6.6 сая тонн нүүрс борлуулж, Монгол банканд 416.6 сая ам.долларыг тушаасан. Нүүрс олборлохоос экспортлох бүх үе шатыг олон нийтэд нээлттэй, ил тод болгон байгууллагын албан ёсны цахим хуудас /www.ett.mn/-т байршуулж,	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Уул уурхайн олборлол-тын компаниуд нь "Эрдэнэс Монгол" нэгдлийн хүрээнд ажиллаж байгаа тул цаашид хяналтаас хасуулах саналтай.

		арга хэмжээ авах, цаашид нууц гэрээ байгуулахгүй байх.	улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамжийг 1.5 дахин буюу 410 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн. Компанид онцгой дэглэм тогтоосон хугацаанаас хойш уурхайн ам нөхцөлөөр нүүрс борлуулах шинэ гэрээ байгуулаагүй бөгөөд Уурхайн ам нөхцөлтэй байгуулагдсан богино хугацаат гэрээнүүдэд 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж DAP-Ганцмод нөхцөл рүү шилжүүлсэн болно.		
44	77	**Төр, засгийн нийтлэг үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-11-09, № 400 2. Татан буугдсан төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын эд хөрөнгөд тооллого хийж, хаалтын баланс гаргах, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газарт шилжүүлэх, бүртгэх болон өр төлбөрийг барагдуулах, чөлөөлөгдсөн ажилтнуудад тэтгэмж олгох зэрэг хууль тогтоомжид заасан арга хэмжээг зохион байгуулах комисс томилон ажиллуулах талаар зохих арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ** Тогтоолыг хэрэгжүүлэхээр Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2022 оны 85 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дараах ажлыг хийж гүйцэтгэсэн: – “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ыг татан буулгаж, ТӨБЗГ-ын 2022 оны 723 дугаар тогтоолоор нийт 537.9 сая төгрөгийн хөрөнгийг Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газарт; – “Төрийн ордны мэдээлэл үйлчилгээний цогцолбор” ТӨҮГ-ыг татан буулгаж, ТӨБЗГ-ын 2023 оны 140 дүгээр тогтоолоор нийт 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газарт; – “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй нийт 66.6 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалыг Хил хамгаалах ерөнхий газарт; – “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 117.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий авлага болон хөрөнгийг Төр засгийн үйлчилгээ эрхлэх газарт тус тус балансаас баланст шилжүүлж, жилийн эцсийн болон хаалтын санхүүгийн тайланд тусгуулснаар хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг дуусгавар болгосон.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
45	78	**Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-11-23, № 417 2. 2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т тус тус даалгасугай: **2.1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгах ажлыг улсын хэмжээнд**	**ТӨБЗГ – ТӨБАХ** Татан буулгах комиссын саналын дагуу үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх асуудлыг ТӨБЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 03 дугаар тэмдэглэлээр дэмжин Засгийн газрын шийдвэр гаргуулахаар ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын 109 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгууд дахь Мэргэжлийн хяналтын газруудын хөрөнгөд бүртгэлтэй нийт 19.6 тэрбум төгрөгийн барилга байгууламж (газар эзэмших эрх)-ийг төрийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэхээр тогтож, шийдвэрлэсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний “Албан томилолтоор ажиллуулах тухай” А/42 дугаар тушаалын	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	ТӨБЗГ-аас гүйцэтгэх ажил хийгдсэн тул бүрэн хэрэгжсэн гэж үзэн хяналтаас хасуулах саналтай.

		зохион байгуулах Комиссыг байгуулж, удирдлагаар хангаж ажиллах, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дуусгалтын тайланг гаргуулан, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 2.2. аймаг, нийслэлийн хэмжээнд Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан дэд комиссыг байгуулж, аймаг, нийслэл дэх мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгах, чиг үүрэг, орон тоог шилжүүлэх ажлыг зохион байгуулах; 2.3. мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг орон тоо, төсөв, ашиглаж буй компьютер техник, хэрэгслийн хамт одоо эрхэлж байгаа чиг үүрэг, мэргэжлийн чиглэлийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д заасан байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах; 2.4. энэ тогтоолын 2.3-т заасан улсын байцаагчаас бусад албан хаагчийг тэргүүн ээлжид ажлын байраар хангах чиглэлийг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих; **2.5. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын баланст бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх**.	дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээг дүгнэх, татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын “Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох байгууллагуудад үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг шилжүүлэх, байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагын асуудлыг судлан, санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023.06.05-25-ны өдрүүдэд 21 аймагт ажиллаж, дээрх шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг хэрэгжүүлэв. ТӨБЗГ-ын 2023 оны 623 дугаар тогтоолоор 1.6 тэрбум төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бусад хөдлөх хөрөнгийг ТӨБЗГ-т шилжүүлсэн. ТӨБЗГ-ын 2023 оны 604 дүгээр тогтоолоор автомашинуудыг орон нутгийн өмчит байгууллагуудад шилжүүлсэн. Ингэснээр Мэргэжлийн хяналтын бүх байгууллагын хөрөнгийг шилжүүлж дууссан бөгөөд хаалтын баланс гаргаад байна.		
46	79	**Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-11-23, № 419 5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, зохих салбар нэгжтэй төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудад боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэхдээ Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ажиллах асуудлыг бодлогоор дэмжиж, төвлөрлийг сааруулах, орон нутгийн хөгжлийг түргэтгэх хүрээнд үе шаттай үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх чиглэл өгсөн. Энэ хүрээнд уг асуудалтай холбоотой тооцоо судалгааг хийлгэн 2023 оны бизнес төлөвлөгөөнд нь үе шаттай тусгуулж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байна.	“Хэрэгжих шатанд” - 70%	

		ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.			
47	80	**“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай** 2022-11-30, № 434 2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 94 дүгээр тушаалаар "Тавантолгой-Зүүнбаян", "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төсөл, "Богдхан" төмөр замын төслийн хэрэгжилтэд болон "Зүүнбаян төмөр зам" ХХК, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий хамтарсан ажлыг хэсэг байгуулагдсан бөгөөд ТӨБЗГ-аас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/ТТЗ-ЗБТ дугаартай шалгалтын удирдамжийг баталсан. Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт болон "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх дэд ажлын хэсэг байгуулагдан батлагдсан удирдамжийн дагуу хяналт, шалгалт хийж, холбогдох тайланг боловсруулан танилцуулсан байна. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөд хийх хөндлөнгийн аудитын дүгнэлт, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд хийх санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалтын дүнг тус тус үндэслэн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах эсэхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхт төлөөлөгч Н.Мягмарт үүрэг болгосон.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	ТӨБЗГ-ын газраас холбогдох ажлыг хийсэн тул хяналтаас хасуулах саналтай.
48	81	**“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-11-30, № 435 2. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Монголын төмөр зам” ТӨХК хэрэгжүүлэхээр тогтоосугай. 2. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудлыг нэгдсэн	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой галт тэрэг, ачаа тээвэр, зүтгүүр, вагоны цогц программын шаардлагатай төсвийн зардлыг хөрөнгө оруулалтын төсөвт тусган батлуулсан. Тээвэрлэлтийн ажлыг оновчтой зөв зохион байгуулах, технологи ажиллагааг мөрдөж ажиллах чиглэлээр өртөөдийн технологийн бичиг баримтад өөрчлөлт оруулж батлан мөрдүүлээд байна. Тавантолгой өртөө, Цогтцэций өртөө хооронд галт тэрэг солилцох түр журмыг өөрчлөх саналыг боловсруулан "Монголын төмөр зам" ТӨХК-ийн холбогдох албанд хүргүүлсэн. Хамтарсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, хоёр талаас	Хэрэгжих шатанд” - 70%	

		удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод тус тус даалгасугай.	саналуудаа тусган батлуулахаар бэлтгэж байна. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэлээр хатуу тооцоот багаж хэрэгслийг тогтмол шалгаж, хяналт тавьж байна. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч “Монголын төмөр зам” ТӨХК-иас төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахтай холбоотой асуудлаар тухай бүр чиглэл, үүрэг даалгавар өгч ажилласан байна.		
	82	**“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-11-30, № 435 3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 94 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/ТТЗ-ЗБТ дугаар удирдамжийн дагуу “Тавантолгой-Зүүнбаян”, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл, “Богдхан” төмөр замын төслийн хэрэгжилт болон “Зүүнбаян төмөр зам” ХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажилласан. Удирдамжийн дагуу ажлын хэсэг 2 дэд ажлын хэсэгт хуваагдан холбогдох чиглэлээр хяналт шалгалт хийсэн. "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төсөл, "Богдхан" төмөр замын төслийн хэрэгжилтэд болон "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх дэд ажлын хэсэг байгуулагдан батлагдсан удирдамжийн дагуу хяналт, шалгалтыг явуулж холбогдох тайланг боловсруулан танилцуулсан байна. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөд хийх хөндлөнгийн аудитын дүгнэлт, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд хийх санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалтын дүнг тус тус үндэслэн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах эсэхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхт төлөөлөгч Н.Мягмарт үүрэг болгосон.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
	83	**“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн зүгээс Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулсан	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	

		2022-11-30, № 435 4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Ж.Ганбат)-д тус тус даалгасугай.	хөрөнгө оруулалт, санхүүжилт, хувь эзэмшилтэй холбоотой гэрээ, хэлцэлд нэмэлт өөрчлөлт оруулах, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд олгосон санхүүжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэх санал, дүгнэлт, гэрээний төсөл боловсруулах ажлын хүрээнд "Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхэт төлөөлөгчийн 2023.08.18-ний өдрийн (өмнөх А/120) А/275 тоот тушаалаар болон “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2023.08.23-ны өдрийн А/113 дугаар тушаалаар тус хоёр компанийн хамтарсан ажлын хэсгийг шинэчлэн байгуулан ажиллуулж байна. Хамтарсан ажлын хэсэг 2023.08.24-ний өдөр хуралдаж үлдэгдэл санхүүжилтийг тээврийн асуудал шийдэгдсэний дараа шийдвэрлэхээр тохиролцсон. **“**Эрдэнэс Тавантолгой” ХК-аас нийт 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээс 71.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Уг үлдэгдэл санхүүжилтээр Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын төслийн ажлыг хийж дуусгахаар ажиллаж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхт төлөөлөгч Ж.Ганбатад 2023.08.30-ны өдрийн 01/1351 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтаар тээвэрлэх ачааны хэмжээг, 2 дугаар хавсралтаар Вагон паркын ашиглалтын мэдээллийг, 3 дугаар хавсралтаар Тавантолгой-Зүүнбаян-Эрээн чиглэлийн 1 галт тэрэгний тээврийн тооцоо (өөрийн эзэмшлийн болон хувийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүнээр, одоо мөрдөгдөж буй тарифаар гэсэн 4 хувилбараар хийсэн)-г, 4 дүгээр хавсралтаар Тавантолгой-Зүүнбаян төслийн барьцаа төлбөр ороогүй гүйцэтгэлийн өр төлбөрийн жагсаалтыг тус тус хүргүүлсэн. Хамтарсан ажлын хэсэг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зарцуулсан санхүүжилтийг "Монголын төмөр зам" ТӨХК-ийн зүгээс 20 жилийн хугацаатай, хүүтэй, эргэн төлөгдөх нөхцөл бүхий санхүүжилтийн гэрээ байгуулах замаар шийдвэрлэх гэрээний төслийг хамтран боловсруулсан. Гэрээ байгуулахтай холбоотойгоор уг асуудлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, гэрээ байгуулах зөвшөөрөл олгож, 18 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн байна.		
	84	**“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-11-30, № 435	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын ээлжит хурлаар тус компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төслийг хэлэлцсэн боловч тодорхой шийдэлд хүрээгүй. Тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг	“Хэрэгжих шатанд” - 70%	

		5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ, дүрэмд өөрчлөлт оруулах, бүтэц, зохион байгуулалтыг зохих журмын дагуу шинэчлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай.	шинэчлэн томилсон. Төлөөлөн удирдах зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүнээр компанийн дүрмийн төслийг хэлэлцэж, Хувьцаа эзэмшигч нарт танилцуулан шийдвэрлүүлэхээр талууд тохиролцсон.		
	85	**“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-11-30, № 435 6. Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтоор шинээр баригдах хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, хэрхэн санхүүжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр ТЭЗҮ болон иж бүрэн зураг төсөл боловсруулах Зөвлөх үйлчилгээний гэрээг “Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын Төмөр замын зураг төслийн корпорацийн хооронд байгуулсан ба 11 дүгээр сарын 28-ны өдөр дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ ажлын төслийн ТЭЗҮ-ийг ЗТХЯ-ны Шинжлэх, ухаан технологийн зөвлөлөөр 09 дүгээр сарын 28-ны өдөр хэлэлцүүлсэн нь дэмжигдсэн бөгөөд уг зөвлөлөөс өгсөн 22 зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн "...болон "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 4 дэх хэсэгт санхүүжүүлэх арга хэмжээ авах үүргийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасан. 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын 310 дугаар тогтоолоор Монгол-Хятадын “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д 5 жилийн хугацаатай олгосон. “Тавантолгой төмөр зам” ХХК нь 2023 онд тус төслийн ТЭЗҮ боловсруулах, магадлуулах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх, нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулах ажлын зардалд нийт 21.4 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний 3 дугаар хавсралтанд заасан төлөвлөгөөний дагуу төслийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулж дуусмагц уг төсөлд шаардагдах санхүүжилтийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас гаргахаар шийдвэрлэсэн.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	

			Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 310 дугаар тогтоолоор үүрэг өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хүрээнд хилийн түр гарц нээх, журам тогтоох асуудлаар хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт бэлтгэх, хятадын талтай хэлэлцэн тохиролцох чиглэлээр ажлын хэсэг байгуулагдсан.		
49	86	**Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-12-07, № 448 1.20.төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшлийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 1 хувиар тооцсон дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашиг тооцон хуваарилж төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; 1.21.төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулах арга хэмжээг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулж, улирал бүр дүгнэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; 1.22.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгож өөрчлөх, хувийн хэвшлийн зонхилох байр суурийг	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ, МТА** 1.20. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу улсын төсөвт 570.1 тэрбум төгрөгийн орлогыг төрийн өмчид ногдох ногдол ашгаас болон төрийн өмчийн түрээсийн орлогоос төвлөрүүлэх үүрэг хүлээж байна. Үүнээс Ирээдүйн өв санд 540.1 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийг төвлөрүүлнэ. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх ногдол ашгийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор тогтоов. Уг тогтоолоор 2023 онд нийт дүнгээр 611.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2022 оны цэвэр ашгаас төвлөрүүлэхээс 126.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 20 хуулийн этгээд улсын төсөвт нийт 59.7 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашиг, ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч 3 хуулийн этгээдийн нийт 1.9 их наяд төгрөгийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд 552.0 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийг төвлөрүүлэх хувь, хэмжээг тогтоосон байна. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажилласнаар 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар Улсын төсөвт 29.5 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 416.2 тэрбум төгрөг, нийт 445.7 тэрбум төгрөгийн төрийн өмчид ногдох ногдол ашгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн дүнтэй байна. 1.21.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн товхимлыг тухайн компани, үйлдвэрийн газрын аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийн үзүүлэлтийн дагуу нэгтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим хуудсанд байршуулан https://pcsp.gov.mn/?page_id=5572 холбоосоор олон нийтэд нээлттэй ил тод мэдээлсэн. 1.22.“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлж, амжилттай хэрэгжсэн. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасуулах саналтай.

		нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц судалгаа хийж, бодлогын чиглэлийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т.	бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэл хангаж байна. Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын дагуу өөрчлөн зохион байгуулагдсан “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн дүрмийг ТӨБЗГ-ын 2023 оны 407 дугаар тогтоолоор баталсан. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, компанийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ТӨБЗГ-ын 527, 565 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг томилж, 485 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирлыг томилох удирдамжийг Төлөөлөн удирдах зөвлөлд өгсөн. Цаашид нэгтгэл хэлбэрт оруулж Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар төлөвлөн ажиллаж байна.		
	87	**Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-12-07, № 448 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2023 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ уг хуульд тусгагдан батлагдаагүй болно.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй”	Цаашид хяналтаас хасах саналтай.

50	88	**“Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-12-09, № 450 3.5. компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт;	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ** Энэ тогтоолын дагуу зохион байгуулсан 2 удаагийн ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажилласан байна. 1. Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хамтарсан Ажлын хэсэг байгуулагдан удирдамжийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн тус компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд иж бүрэн хяналт шалгалтын ажлыг хийсэн. Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд хийх санхүүгийн хяналт шалгалтын удирдамж, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын даргын батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу дараах чиглэлээр хяналт шалгалт хийв: - Эрх бүхий байгууллагаас өмнө хийгдсэн хяналт шалгалт, аудитын тогтоол, шийдвэр, акт, зөвлөмжийн хэрэгжилт; - Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 345 дугаар тогтоолын хэрэгжилт; – Байгуулалтын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, газар болон компанийн биет болон биет бус хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний талаар; – Компанийн засаглал, бүтэц зохион байгуулалт зэрэг асуудал болно. Шалгалтын ажил батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу явагдсан бөгөөд тайланг нэгтгэн ажлын хэсэгт хүргүүлж баталгаажуулсан. 2. Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн СХЭУГ/01 дугаартай удирдамжийн дагуу “Тавантолгой” ХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 45 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. ТӨБЗГ-аас томилогдон ажилласан ажлын хэсгийн гишүүний шалгалтын дүнгээр тус компанид мөрдөж буй хууль, тогтоомжийг зөрчиж компанийн ТУЗ-ийн гишүүдэд илүү олгосон цалин, урамшуулал, орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр, хяналтын тооллогоор дутагдсан үндсэн хөрөнгө, ТУЗ-ийн тогтоол шийдвэрийг зөрчин хөрөнгө илүү акталсан, төрийн хэмнэлтийн хууль тогтоомж зөрчин үргүй зардал гаргасан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээг сонгон шалгаруулалтгүй хэрэгжүүлсэн зэрэг нийт 170 гаруй тэрбум төгрөгийн	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

			зөрчил илэрсэн бөгөөд шалгалтын тайланг ажлын хэсгийн нэгдсэн тайлан, дүгнэлтэд нэгтгүүлсэн болно.		
51	89	**“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2022-12-12, № 459 3.4. “Богдхан” төмөр зам төсөл болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Төрийн худалдах авах ажиллагааны газар (Ц.Батзул) нарт;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 94 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/ТТЗ-ЗБТ дугаар удирдамжийн дагуу “Тавантолгой-Зүүнбаян”, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл, “Богдхан” төмөр замын төслийн хэрэгжилт болон “Зүүнбаян төмөр зам” ХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажилласан байна. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөд хийх хөндлөнгийн аудитын дүгнэлт, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд хийх санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалтын дүнг тус тус үндэслэн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах эсэхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхт төлөөлөгч Н.Мягмарт үүрэг болгосон. "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төсөл, "Богдхан" төмөр замын төслийн хэрэгжилтэд болон "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх дэд ажлын хэсэг байгуулагдан батлагдсан удирдамжийн дагуу хяналт, шалгалтыг явуулж холбогдох тайланг боловсруулан танилцуулсан байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/145 дугаартай тушаалаар төслийг “Улаанбаатар төмөр зам” ХХН-д шилжүүлэх эсэхтэй холбогдуулан “Богдхан төмөр зам” төслийн ТЭЗҮ боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хэрэгжүүлсэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт, бүртгэл, явц дундын төлбөрийн баталгаажуулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, компанийн үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэлд Олон улсын хөндлөнгийн аудитын компаниар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах хөндлөнгийн аудит хийлгэх	“Хэрэгжих шатанд” - 70%	

			үйлчилгээ үзүүлэх талаар 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн АГГ-2023/33 дугаартай гэрээг "Грант тронтон аудит" ХХК-тай байгуулж, 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл тайлан зөвлөмжийг эцэслэн ирүүлэхээр ажиллаж байна.		
52	90	**Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай** 2022-12-28, Дугаар 488 5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	**ТӨБЗГ – ЗУХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны батлагдсан төсөвт багтаан нийт 54 албан хаагчийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо https://hrm.csc.gov.mn цахим системд бүртгэн оруулсан байна. Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоосонтой холбогдуулан ТӨБЗГ-ын даргын 2023 оны Б/10 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин дээр 20 хувийн нэмэгдлийг тооцон олгох асуудлыг шийдвэрлэсэн. Уг шийдвэрийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна. ТӨБЗГ нь төрийн үйлчилгээний нийт 11 орон тоотой бөгөөд, тэдгээрт үндсэн цалингаас тооцон 20 хувийн нэмэгдэл, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны болон бусад нэмэгдлүүдийг олгож байна. Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол хүчингүй болсон бөгөөд төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөхөөр болж байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн бөгөөд дараачийн шийдвэр гарч, энэ тогтоол хүчингүй болсон тул хяналтаас хасах саналтай.
53	91	**Орон сууц хувьчлах тухай** 2023-02-08, № 50 2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Энэ тогтоолоор “Монголросцветмет” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 айлын орон сууцыг тус үйлдвэрийн газарт 29 жил тасралтгүй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ба 2020 оны 09 дүгээр сараас тус үйлдвэрийн газрын эзэмшлийн Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны 16 хороололд Апартмент-5 хотхоны 52/9 байрны 78 тоот байранд оршин сууж байгаа ахмад настан Д.Баярсайханд, 45 жил тасралтгүй ажилласан Гавьяат уурхайчин Я.Сүхбат агсны эхнэр Д.Нинад 2020 оны 09 дүгээр сараас тус үйлдвэрийн газрын эзэмшлийн Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны 16 хороололд Апартмент-5 хотхоны 52/9 байрны 81 тоот байранд оршин сууж байгаа орон сууцыг нь, мөн тус үйлдвэрийн газарт 25 жил тасралтгүй ажилласан Б.Баяр агсны эхнэр А.Даваад 1982 оноос тус үйлдвэрийн газрын эзэмшлийн Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны 18 дугаар байрны 11 тоотод оршин сууж байгаа орон сууцыг нь тус тус үнэ төлбөргүй хувьчлахаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу ТӨБЗГ-ын даргын шийдвэрээр 2023	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

			оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 25, 26, 27 дугаартай "Орон сууц эзэмших эрхийн бичиг"-ийг тус 3 иргэнд гардуулж өгсөн.		
54	92	**Үл хөдлөх эд хөрөнгө нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тухай** 2023-02-08, № 51 2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг шинэчлэн хийлгэсний үндсэн дээр нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгын зах зээлийн өнөөгийн үнэ цэнийг үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний эрх бүхий байгууллага болох “Капитал зууч” ХХК-аар шинэчлэн үнэлүүлсэн. 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 1/331 дүгээр албан бичгээр үнэлгээний тайлан болон дуудлага худалдааны доод үнийн саналыг компаниас авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцүүлсэн. Хэлэлцсэн асуудалтай холбоотой “Үл хөдлөх эд хөрөнгө нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тухай” 319 дүгээр тогтоол гаргав. Нээлттэй дуудлага худалдааны зарыг Өдрийн сонины 118 дугаарт, тухайн компанийн болон ТӨБЗГ-ын газрын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбараар тус тус нийтэд ил тод зарласан. Нээлттэй дуудлагын худалдааг 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, иргэн Дашийн Сайнхүү хамгийн өндөр үнэ болох 110,200,000.00 (нэг зуун арван сая хоёр зуун мянган) төгрөгийг санал болгосноор ялагч болсон. Ялагч Д.Сайнхүүтэй 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр 01 дугаар бүхий “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулсан бөгөөд иргэн Д.Сайнхүү үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлсөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын санхүүгийн орлогын дансны хуулга, тооцоо нийлсэн актаар баталгаажсан болно. ТӨБЗГ-ын 2023 оны 388 дугаар тогтоолоор иргэн Д.Сайнхүүд өмчлөх эрхийг шилжүүлэн олгож, өмчлөх эрхийн 01/2023 дугаар бүхий (Үндэсний үнэт цаасны хэвлэх үйлдвэр, MNSPC) гэрчилгээг олгон дуусаагүй барилгыг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр газар дээр нь очиж хүлээлгэн өгч, акт үйлдсэн болно. Дуусаагүй барилгын хувьчлалын тайланг ТӨБЗГ-ын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 434 дүгээр тогтоолоор баталгаажуулсан.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
55	93	**Үл хөдлөх эд хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай** 2023-02-08, № 52 2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үл хөдлөх хөрөнгийг балансаас баланст	**ТӨБЗГ – ТӨБАХ** Малын удмын сангийн барилга, түүний доорх газар (эзэмших эрх)-ийг Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар хүлээн авч үндсэн хөрөнгөдөө бүртгэсэн. Тогтоолын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 1/77 дугаарт албан бичгээр тус газраас ирүүлсэн.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

		шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.			
56	94	**Үл хөдлөх эд хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай** 2023-02-08, № 53 2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үл хөдлөх хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай	**ТӨБЗГ – ТӨБАХ** Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 2,711,869,016 төгрөгийн балансын үнэ бүхий газар эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгийг тус газрын Ар талын 115 дугаар анги, Уул уурхайн 09 дүгээр ангид шилжүүлэн авч тайлан баланстаа тусгасан талаарх мэдээллийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 42/127 дугаартай албан бичгээр ирүүлсэн.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
57	95	**Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулах тухай** 2023-02-08, № 69 4."Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийг улсын бүртгэлд бүртгүүлж, компанийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Улсын бүртгэлийн ерөнхий газар хэрэгжүүлж байгаа болно.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
58	96	**“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** 2023-03-01, № 82 5. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрчимжүүлэхийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэгт, ажлын	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Газрын тос боловсруулах үйлдвэрийн хотхоны барилга угсралтын ажлыг эрчимжүүлэхээр 1-р ээлжийн хотхоны санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулагдсан ажиллаж байна. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д 8 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс хийсэн байна. Цаашид санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар тогтоолын төсөл боловсруулсан. “Эрдэнэс Монгол” ХХК-аас 1-р ээлжийн хотхоны барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай барьцаа хөрөнгөөс илүү гарсан хэсэгт (8.1 тэрбум төгрөгт) баталгаа гаргах	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй”-ХБ.	ТӨБЗГ-т хамаарах-гүй, тухайн заалтаар тус байгуул-лагад даалгасан үүрэг байхгүй тул цаашид хяналтаас

		явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогтод, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай.	зөвшөөрөлд Сангийн Яамнаас татгалзах зүйлгүй гэдгээ илэрхийлсэн хариуг ирүүлсэн байна. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д 2022 оны 8 дугаар сараас хойш Хөгжлийн банкны зээл олголт зогссон, үүнээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа доголдож эхэлсэн. 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны санхүүжилт болох 2,405,882,108 төгрөгийг зээлийн гэрээгээр олгосон байна. Тэмдэглэл: “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Засгийн газрын 2023 оны 82 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийг тогтоож, “Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд тус компанийг ажиллуулж байгаа тул энэ тогтоол болон тухайн заалтын хэрэгжилт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамаарахгүй байна.		хасуулах саналтай.
59	97	**Журам батлах тухай** 2023-03-07, № 85 2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг журамд нийцүүлэх, холбогдох дүрэмд тусган батлуулж, мөрдүүлэх арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулан хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг энэхүү тогтоолоор баталсан бөгөөд уг журмыг мөрдөж ажиллах талаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад чиглэл хүргүүлсэн. 2023 онд нийт 49 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 121 гишүүнийг журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулсан дүн мэдээтэй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хариуцан хэрэгжүүлдэг төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж өгсөн. 2023 онд төрийн өмчит 25 компанийн 21 хараат бус гишүүнийг энэ журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж, томилох асуудлыг ТӨБЗГ-ын тогтоолоор шийдвэрлэсэн байна. ТӨБЗГ-ын цахим хуудас болон тухайн хуулийн этгээдийн цахим хуудсанд мэдээллийг нээлттэй байршуулсан болно. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023.04.21-ний А/35 дугаар тушаалаар Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Ажлын хэсэг энэ тогтоолоор батлагдсан журмын дагуу тус компанийн Төлөөлөн удирдөх зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулсан байна. “Эрдэнэс Монгол” ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийн төлөөлөл болон хараат бус гишүүдийг хууль, тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, компаниудын Төлөөлөн удирдах	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн, цаашид хэрэгжилт тогтмолжин хэвших боломжтой тул хяналтаас хасуулах саналтай.

			зөвлөлийн бүрэлдэхүүн дэх хараат бус гишүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн хяналтыг сайжруулах арга хэмжээ авав. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, томилох, захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх зэрэг асуудлуудыг зохих хууль журмын хүрээнд тодорхой болгох талаар Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газрын удирдлагад зөвлөмж өгч, холбогдох хууль тогтоомж, журмын талаар танилцуулж, сурталчилсан. Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 13/18 дугаар тогтоолоор Орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой” хувьцаат компанийн “Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам” боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ТӨБЗГ-ын төлөөлөл ажиллаж, холбогдох журмын хэрэгжилтийг хангахад байр суурь, саналаа тусган ажилласан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А-1/1844 дүгээр албан бичгээр “Тавантолгой” хувьцаат компанийн “Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам”-ын төсөл болон саналаа хүргүүлж ажилласан болно.		
60	98	**Нийтлэг журам батлах тухай** 2023-03-07, № 86 2. Нийтлэг журмыг хэрэгжүүлэн, төрийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, онцлогийг харгалзан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохих удирдамж, чиглэл өгч, хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т үүрэг болгосугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд “Төрийн өмчит хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалтаар явуулах нийтлэг журам”-д нийцүүлэн холбогдох журамд өөрчлөлт оруулах, журмын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг хүргүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 20 хуулийн этгээд ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, 486 хүнийг журмын хүрээнд нээлттэй сонгон шалгаруулалтаар томилсон дүн мэдээтэй байна. Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, нээлттэй ил тод болгох ажлын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 88 ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, сонгон шалгаруулалтын үе шатыг хараат бус, ил тод, нээлттэй зарчмаар хөндлөнгийн хяналттайгаар зохион байгууллаа. Сонгон шалгаруулалтад нийт 3500 гаруй иргэн оролцсон байна.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Хэрэгжилт тогтмолжиж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, хэвших боломжтой тул хяналтаас хасуулах саналтай.
61	99	**Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай**	**ТӨБЗГ – ТӨБАХ**	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул цаашид

		2023-03-15, № 93 2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	“МИАТ” ТӨХК-ийн баланс бүртгэлтэй, 17 нэрийн нийт 6,004,168,044.52 төгрөгийн балансын үнэ, 462,339,127.31 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 59,648 м.кв талбай бүхий газар эзэмших эрх, барилга байгууламжийг Иргэний нисэхийн ерөнхий газарт балансаас баланст шилжүүлсэнтэй холбоотой холбогдох байгууллагуудад чиглэл өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Холбогдох байгууллагуудаас хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланд тусгаж, хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн талаарх хэрэгжилтийн мэдээллийг ирүүлсэн байна.		хяналтаас хасуулах саналтай.
62	100	**Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай** 2023-03-15, № 94 2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх, өр авлагыг тооцоо нийлж, хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ** Энэ тогтоолоор “МИАТ” ТӨХК-ийн баланс бүртгэлтэй, нийт 1,224,568,102.46 төгрөгийн балансын үнэ, 51,014,641.76 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 9046 м.кв талбайтай газар эзэмших эрх, агуулахын барилгуудыг нийт 1,224,568,102.46 төгрөгийн төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т балансаас баланст шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор холбогдох байгууллагуудад чиглэл өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Холбогдох байгууллагуудаас хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланд тусгаж, хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн талаарх хэрэгжилтийн мэдээллийг ирүүлсэн байна. Үл хөдлөх хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх, өр авлагыг тооцоо нийлж, хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах хүрээнд “МИАТ” ТӨХК, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь төлбөр төлөх тухай асуудлаар 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн НГ 23/01 дугаар бүхий хамтын гэрээг байгуулан ажиллаж байна. Тогтоолд заасны дагуу нийт 1.2 тэрбум төгрөгийг төлөх нөхцөлтэй байснаас одоогоор төлбөрийн үлдэгдэл 400.0 сая төгрөг байна. 2024 оны 4 дүгээр сард төлбөрийн хуваарийн дагуу төлөлт дуусна.	“Хэрэгжих шатанд” – 70%	
63	101	**Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай** 2023-03-29, № 109 2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний “Албан томилолтоор ажиллуулах тухай” А/42 дугаар тушаалын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээ”-г дүгнэх, татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын “Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох байгууллагуудад үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг шилжүүлэх, байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагын асуудлыг судлан, санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023.06.05-25-ны өдрүүдэд 21 аймагт ажиллаж, тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг хэрэгжүүлэв.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай

			Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан хөрөнгийг шилжүүлэн авсан дараах байгууллагууд данс бүртгэлдээ бүртгэн авсан талаарх биелэлтийн мэдээллээ ирүүлсэн: 1. Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын харьяа байгууллагууд нийт 3,077,332,003.92 (гурван тэрбум далан долоон сая гурван зуун гучин хоёр мянга гурван төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн үл хөдлөх хөрөнгө болон газар эзэмших эрхийг данс бүртгэлдээ тусгасан талаар Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 05/6227 дугаартай албан бичгээр; 2. Стандарт хэмжил зүйн газрын харьяа байгууллагууд нийт 3,714,275,436.35 (гурван тэрбум долоон зуун арван дөрвөн сая хоёр зуун далан таван мянга дөрвөн зуун гучин зургаан төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн үл хөдлөх хөрөнгө болон газар эзэмших эрхийг данс бүртгэлдээ тусгасан талаар Стандарт хэмжил зүйн газрын 2023.09.05-ны өдрийн 03/750 дугаартай албан бичгээр; 3. Нийт 2,462,699,587.00 (Хоёр тэрбум, дөрвөн зуун жаран хоёр сая зургаан зуун ерэн есөн мянга таван зуун наян долоо) төгрөгийн үл хөдлөх хөрөнгө болон газар эзэмших эрхийг бүртгэлд тусгасан талаар Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023.07.28-ны өдрийн 359 дугаартай албан бичгээр.		
64	102	**Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** 2023-05-03, № 160 1.5. “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-д дотоодын агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК, “Хүннү Эйр” ХХК, “Аэро Монголиа” ХХК-аас төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын хуримтлагдсан өрийг барагдуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-тай холбоотой НӨАТ-ын хуримтлагдсан өр төлбөрийн талаарх асуудлаар "МИАТ" ТӨХК, Татварын Ерөнхий Газар болон Иргэний нисэхийн үндэсний төв, бусад агаарын тээвэрлэгч байгууллагын төлөөлөл бүхий хамтарсан уулзалтыг 2023 оны 5 дугаар сарын 23-нд удирдлагуудын түвшинд зохион байгуулсан. Уулзалтаар холбогдох байгууллагын удирдлагуудад тус асуудлын талаарх танилцуулга, мэдээлэл хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн байна. Мөн тус асуудлыг шийдвэрлэж өгөх талаар гаргасан хүсэлтэд Татварын ерөнхий газраас “Гэрээний үнийн дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар шингэсэн гэж үзэн гуравдагч этгээд буюу “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК нь НӨАТ төлж тайлагнах эрх зүйн зохицуулалт үйлчилнэ" гэсэн зөвлөмжийг 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 06/1541 тоот албан бичгээр өгсөн. “МИАТ” ТӨХК нь “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-тай хамтарсан гэрээний хүрээнд агаарын хөлгийн зурвас, буулт, хөөрөлт, зогсоол, хүзүүвч, тээш дамжуулах систем, нисэх буудлын аэродромын маневрлах талбай, перроны хамгаалалтын 5 төрлийн үйлчилгээний төлбөр хураамжийг сар бүр	“Хэрэгжих шатанд” – 70%	

			“Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-д НӨАТ-тай дүнгээр хүлээн зөвшөөрч, шилжүүлэн гэрээний үүргээ бүрэн биелүүлж байна. “МИАТ” ТӨХК хамтарсан гэрээний хүрээнд зорчигч үйлчилгээний хураамж $25 /MN Такс/, зорчигчийн аюулгүй байдлын хураамж $5 /J2 такс/ байхаар тогтсон ба тус хураамжид НӨАТ шингэсэн гэж үзэн тайлагнах тухай ТЕГ-ын зөвлөмжийг дагаж мөрдөх саналыг 2023 оны 07-р сарын 18-ны өдрийн 01/1469 албан тоот бичгээр “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-д, ТЕГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр хамтарч ажиллах тухай хүсэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд 2023.08.18-ны өдрийн 01/1726 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2023.08.18-ны өдөр тус асуудлаар Иргэний нисэхийн үндэсний төвд 01/1728 тоот албан бичгээр, “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-д 01/1727 тоот албан бичгээр тус тус хандсан. НӨАТ-ын асуудлаар Сангийн Яаманд 2023.09.26-ны өдрийн 01/2028 тоот албан бичгийг тус компаниас хүргүүлсэн байна.		
65	103	**Орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг үйлдэх зарим арга хэмжээний тухай** 2023-05-24, № 201 3. “МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагааны ашгаас 2023 онд улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг төрийн өмчит бусад хуулийн этгээдээс төвлөрүүлсэн орлогын давсан хэсгээс нөхөх арга хэмжээ авах, цаашид тус компанийн 2024-2026 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусган төлөвлөж, хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** "МИАТ" ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 01/2144 дүгээр албан бичгээр ирүүлсэн “Ногдол ашиг төлөхөөс чөлөөлж өгөхийг хүссэн хүсэлт”-ийг харгалзан Засгийн газрын энэхүү тогтоолын заалтыг хэрэгжүүлэх үндэслэлээр “МИАТ” ТӨХК-ийн 2022 оны үйл ажиллагааны ашгаас 2023 онд улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг бусад хуулийн этгээдээс төвлөрүүлэх орлогын давсан хэсгээс нөхөх арга хэмжээ авч, тус компанийг улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогоос чөлөөлсөн. Уг асуудлыг ТӨБЗГ-ын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 704 дүгээр тогтоолоор компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд 2024 онд төрийн өмчийн ногдол ашиг төвлөрүүлэхгүй байхаар төлөвлөсөн болно. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар Орон нутгийн зарим чиглэлд хуваарьт нислэг үйлдэх болсонтой холбоотойгоор “МИАТ” ТӨХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн 466 дугаар тогтоолоор тодотгол хийсэн болно.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Зохион байгуу-лалтын арга хэмжээ авч, хэрэгжил-тийг хангасан тул хяналтаас хасуулах саналтай.
66	104	**Авто замын засвар арчлалтын компаниудыг өөрчлөн зохион**	**ТӨБЗГ – ТӨУЗХ**	“Хэрэгжих шатанд” – 70%	

		байгуулах зарим арга хэмжээний тухай 2023-06-07, № 220 3. Засгийн газрын гадаад зээллэгийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгө, түүнтэй холбоотой дамжуулан зээлийн өр төлбөрийг хавсралтад заасан компаниудтай тооцоо нийлж баталгаажуулах, энэхүү хөрөнгө, өр төлбөр болон бусад өр төлбөр, авлага, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг холбогдох хууль, журамд заасны дагуу “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн санхүүгийн тайланд шилжүүлэх арга хэмжээ авах, авлага, өр төлбөр, хөрөнгийг хүлээн авсантай холбогдуулан тооцоо нийлж баталгаажуулах, компанийн дүрэм, бүтцийг батлах, зардал бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Төрийн өмчит компаниудын үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Авто замын засвар арчлалтын ажил эрхэлдэг төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулсан. ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар тус нэгтгэл компанийн дүрмийг хэлэлцүүлэн 407 дугаар тогтоолоор батлсан. Нэгтгэл компани байгуулагдсантай холбогдуулан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүн болон хараат бус гишүүн, компанийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар байгуулан сонгон шалгаруулалтыг нээлттэй зохион байгуулав. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 485 дугаар тогтоолоор “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлаар Баярсайханы Наранбатыг томилохыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосон. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг ТӨБЗГ-ын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 527, 565 дугаар тогтоолоор томилсон. Төлөөлөн удирдах зөвлөл хуралдаж Гүйцэтгэх захирлыг томилон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан байна.		
	105	**Авто замын засвар арчлалтын компаниудыг өөрчлөн зохион байгуулах зарим арга хэмжээний тухай** 2023-06-07, № 220 4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит компаниудын үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 220 дугаар тогтоолоор авто замын засвар арчлалтын ажил эрхэлдэг төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулсан. Цаашид нэгтгэл хэлбэрт оруулснаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар төлөвлөж байна. УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд тогтоолд дурдсан нэр бүхий 26 компанийн	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	

		худалдах үндсэн чиглэл”-д өөрчлөлт оруулах талаар саналаа боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	IPO гаргах ажлын явц, тулгарч буй асуудал, шийдэл, саналаа боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүрд нь танилцуулсан.		
67	106	**Арьс, ширний талаар авах зарим арга хэмжээний тухай** 2023-02-08, № 65 3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан боловсруулаагүй бүх төрлийн арьс, ширийг Хөдөө аж ахуйн биржээр бүртгэлжүүлэн, дэл, сүүлгүйгээр арилжих ажлыг зохион байгуулахыг Хөдөө аж ахуйн бирж (О.Нарандэлгэр)-д, биржээр арилжсан арьс, ширийг экспортлох үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т тус тус үүрэг болгосугай	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Боловсруулаагүй бүх төрлийн арьс шир”-ийг 2023 оны 1-р сарын 01-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд экспортод гаргахыг зөвшөөрсөн бөгөөд Хөдөө аж ахуйн биржээр боловсруулаагүй бүх төрлийн арьс, ширийг бүртгэлжүүлэн дэл, сүүлгүйгээр арилжих ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосон. Энэ ажлын хүрээнд 2200 ширхэг боловсруулаагүй үхрийн ширийг биржээр арилжаалан экспортод гаргаад байна. Уг тогтоол болон тухайн заалт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамааралгүй бөгөөд тус байгууллагад даалгасан үүрэг байхгүй байна.	Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй – ХБ.	ТӨБЗГ-т хамаарах-гүй, тухайн заалтаар тус байгуул-лагад даалгасан үүрэг байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай.
68	107	**Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албыг татан буулгах тухай** 2023-07-05, № 269 2.Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Ажлын албыг татан буугдсантай холбогдуулан тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өр төлбөр, авлагыг энэ тогтоол батлагдсан өдрөөр тасалбар болгон "Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүрэн шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Төрийн өмчийн	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ** 1.Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны А/450 дугаар тушаалаар байгуулагдсан “Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл томилогдон ажиллав. Ажлын хэсэг Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан. Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулахаар олон нийтэд зарлаад байна. 2.“Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/05 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сард нийт 8 салбарт ажиллаж, тус газрын үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг газар дээр үзэж, тооллого хийн бүртгэлийг нягталж, архив бичиг хэргийн баримтуудыг	“Хэрэгжих шатанд” – 70%	

		бодлого зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	цэгцлэн Архивын ерөнхий газраас баталсан дүрэм, журмын хүрээнд хүлээлгэн өгөх, нийт хөрөнгийн жагсаалт гарган холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх чиглэлийг өгч ажилласан. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Ажлын алба (хуучин нэрээр) болон 8 салбарын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 263,457,630,808.14 төгрөгийн хөрөнгө, (үүнээс авлага 213,959,201,912.16 (хоёр зуун арван гурван тэрбум есөн зуун тавин есөн сая хоёр зуун нэг мянга есөн зуун арван хоёр төгрөг арван зургаан мөнгө), 257,027,318,679.86 төгрөгийн богино болон урт хугацаат өр төлбөр, 1605 нэрийн 107,967,557,813.45 төгрөгийн балансын үнэ, 26,671,185,959.19 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг тус тус “Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас баланст шилжүүлэх ажлыг судлан боловсруулж, уг асуудлыг ТӨБЗГ-ын 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 505 дугаар тогтоолоор балансаас баланст шилжүүлэхээр шийдвэрлэсэн.		
69	108	**Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай** 2023-08-09, № 287 2. 1.“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 1,360,414,112.76 (нэг тэрбум гурван зуун жаран сая дөрвөн зуун арван дөрвөн мянга нэг зуун арван хоёр төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 138,875,607.39 (нэг зуун гучин найман сая найман зуун далан таван мянга зургаан зуун долоон төгрөг гучин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий энэ тогтоолын хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Зам, тээврийн хөгжлийн яаманд балансаас баланст шилжүүлсүгэй. 2.Үл хөдлөх хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ** “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 1,360,414,112.76 (нэг тэрбум гурван зуун жаран сая дөрвөн зуун арван дөрвөн мянга нэг зуун арван хоёр төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 138,875,607.39 (нэг зуун гучин найман сая найман зуун далан таван мянга зургаан зуун долоон төгрөг гучин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Засгийн газрын энэ тогтоолын хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Зам, тээврийн хөгжлийн яаманд балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлдээ тусгасан. Хэрэгжилтийг албан бичгээр ирүүлсэн. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ байрыг сулласан.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

70	109	**Орон сууц хувьчлах тухай** 2023-08-09, № 288 2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 98,710,508.80 /ерэн найман сая долоон зуун арван мянга таван зуун найман төгрөг наян мөнгө/ төгрөгийн балансын үнэ бүхий, 2004 онд ашиглалтад орсон, Дархан-Уул аймаг, Дархан сум, Өргөө баг, 21 дүгээр хороолол, 9 дүгээр байрны 50 тоот 62.77 м2, 53 тоот 62.14 м2 орон сууцыг ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зорилгоор тогооч А.Даваасүрэн, жолооч Ж.Ганбаатар нарт үнэ төлбөргүй хувьчлах Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 288 дугаар тогтоолын дагуу 2023.09.20-ны өдөр 31, 32 дугаар бүхий Орон сууц эзэмших эрхийн бичгийг газар нь гардуулан өгөв.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
71	110	**Орон сууц хувьчлах тухай** 2023-08-09, № 289 2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** ”Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Буянт-Ухаа-1” хороollын 15 айлын орон сууц, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд байрлах “Эрчим” хотхоны 27 айлын, нийт 42 айлын орон сууцыг 40-ийг нь үнэ төлбөргүй, 2-ыг нь үнэ төлбөртэй одоо амьдарч байгаа албан хаагчдад нь хувьчлах асуудлыг Засгийн газрын тогтоол гарсантай холбогдуулан өмчлөх эрхийн гэрчилгээг ”Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани дээр ТӨБЗГ-ын удирдлагууд очиж иргэдэд гардуулж өгсөн.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
72	111	**Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай** 2023-08-16, № 296 2. Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ** Тус тогтоолын дагуу "Тавантолгой түлш" ХХК нь гүйцэтгэх захирлын А/433 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, "Дулааны хоёрдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн шингэн шилний үйлдвэрийн барилгыг 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр хүлээлцэж ажилласан талаар 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 17/2287 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлсэн.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
73	112	**Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах тухай** 2023-08-16, № 300 2. Энэ тогтоолын 1-д заасан компанийн дүрмийг баталж, мөрдүүлэхийг	**ТӨБЗГ – ТӨУЗХ** "Монголын төмөр зам" ТӨХК-ийн оролцоотой Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын "Сайншанд-Баруун-Урт-Хөөт төмөр зам" ХХК-ийг байгуулж, дүрмийг боловсруулж байна. Дүрмийг эцэслэх асуудалтай холбоотой судалгаа,	“Хэрэгжих шатанд” – 70%	

		“Монголын төмөр зам” ТӨХК (Б.Отгонсүх)-д даалгасугай.	боловсруулалтын ажлыг хийж байгаа бөгөөд санал зөвлөгөөг холбогдох эрх бүхий байгууллагаас авах чиглэлээр ажиллаж байна. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/131 тоот тушаалаар хөрөнгө оруулагчийг сонгох бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Хөрөнгө оруулагчид тавигдах шаардлагууд, бүрдүүлэх баримт бичиг зэрэг бусад мэдээллийг багтаасан “Хөрөнгө оруулагч сонголтын баримт бичиг”-ийн төслийг боловсруулан гишүүдийн саналыг тусгасан. 2. “Хөрөнгө оруулагч сонголтын баримт бичиг”-ийн төсөлд санал авахаар Зам, тээврийн хөгжлийн сайдад 2023 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн 01/1531 тоот албан бичгээр хүргүүлсэн. 3. Засгийн газрын 300 дугаар тогтоолын 3-т заасны дагуу шууд гэрээ байгуулах хуулийн этгээдэд тавигдах шаардлага болон хөрөнгө оруулагчийг ямар шалгуур үзүүлэлтээр сонгох талаар дэмжлэг үзүүлэх хүсэлтийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2023 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1528 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.		
74	113	**Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай** 2023-08-23, № 302 2. 2.Үл хөдлөх хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай**.**	**ТӨБЗГ – ТӨБАХ** “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3,000,000.00 төгрөгийн балансын үнэ бүхий “ОХУ-ын Эрхүү хотын Красных Мадьяр гудамжны, 78 дугаар байр, 3 дугаар орц, 7 дугаар давхар, 21 тоот” хаягт байрлах 2 өрөө орон сууцыг Монгол Улсаас ОХУ-ын Эрхүү хотод суугаа Ерөнхий Консулын газарт хүлээн авч акт үйлдэн данс бүртгэлдээ тусгасан тухай биелэлтийн мэдээллийг ирүүлсэн.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
75	114	**Хамтарсан сургууль байгуулах тухай** 2023-08-30, № 320 3. Энэ тогтоолын 1-д заасан сургуульд боловсролын сургалтын үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл олгох, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дүрмийг зохих журмын дагуу батлах арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг	**ТӨБЗГ – ТӨБАХ** Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдахаар тухайн тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах тул хүлээгдэж байна**.**	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	

		Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд, **сургуулийн барилга байгууламж, үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авахыг** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус даалгасугай.			
76	115	**Орон сууц хувьчлах тухай** 2023-10-11, № 373 2. Орон сууцыг хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Нийслэлийн Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 74 дүгээр байрны 33 айлын орон сууцыг Засгийн газрын 2023 оны 373 дугаар тогтоолын хавсралтад заасан нэр бүхий оршин суугчдад үнэ төлбөргүй хууль тогтоомжийн дагуу хувьчлах арга хэмжээг зохион байгуулан “Орон сууцны эрхийн бичиг”-ийг олгосон.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
	116	**Орон сууц хувьчлах тухай** 2023-10-11, № 373 3. Ус сувгийн удирдах газрын баланст дуусаагүй барилга нэртэйгээр бүртгэлтэй, 354.6 (гурван зуун тавин дөрвөн сая зургаан зуун мянга) сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг үндсэн хөрөнгийн данс бүртгэлээс хасах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т үүрэг болгосугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ** Уг асуудал нь хууль журмын дагуу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бүрэн эрхийн асуудал тул шийдвэрлэж, хэрэгжилтийг ойрын хугацаанд ирүүлэхийг Нийслэлийн өмчийн газарт мэдэгдэж албан бичиг хүргүүлсэн.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	
77	117	**Тогтоолын хавсралт хүчингүй болгох тухай** 2023-11-01, № 396 3. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны эд хөрөнгөд тооллого хийж, хаалтын баланс гаргах, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг бүртгэх болон өр төлбөрийг барагдуулах, чиг үүрэг, орон тоо, шаардлагатай эд хөрөнгийг шилжүүлэх, улсын төсвөөс	**ТӨБЗГ – ТӨБАХ** Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрчим хүчний сайдын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/622, А/294 дугаартай хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл оролцон ажиллаж байна. Ажлын хэсгийн 2 удаагийн хурал зохион байгуулагдаж, ажлын чиглэлээ тодорхойлж, төлөвлөгөө, ажил үүргийн хуваариа тогтож, ажлын чиглэл, хуваарийн дагуу орон нутагт ажиллаж байна. Энэ хүрээнд 21 аймаг дахь хөрөнгийн тооллогыг	“Хэрэгжих шатанд” – 70%	

		санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэх талаар хуульд заасан арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт тус тус даалгасугай.	хийх болон тус хөрөнгийг шилжүүлэн хүлээж авах байгууллагуудтай уулзалт хийх чиглэлээр орон нутагт ажиллаж байна.		
78	118	**Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” байгуулах тухай** 2023-11-22, № 411 6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчийг түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалгаа тооцоолол хийх зэрэг үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.	**ТӨБЗГ – ТӨБАХ** Тогтоолыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр хүрээн авч бүртгэсэн бөгөөд байгууллагын удирдлага, хэлтэс, албаны дарга нар, нийт албан хаагчдад байгууллагын дотоод сүлжээний мэдээллээр хүргэж, сурталчлан таниулсан. Одоогоор холбогдох байгууллага, албан тушаалтнаас энэ заалтаар үүрэг болгосон чиглэлийн дагуу хамтран ажиллах талаар санал ирүүлээгүй байна.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	
79	119	**Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай**	**ТӨБЗГ – ТӨБАХ**	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул

		2023-11-29, № 414 2. Хөрөнгө балансаас баланст шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Цагдаагийн ерөнхий газар (Т.Сүхболд)-т тус тус даалгасугай.	Уг тогтоолыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авч, бүртгэсэн бөгөөд тогтоолын биелэлтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,144,133,375.27 төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, 58,900,000.0 төгрөгийн балансын үнэ бүхий биет бус хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Дотоодын цэргийн штабт балансаас балансад шилжүүлсэн.		хяналтаас хасуулах саналтай.
		ЗГТогтоол: 51 шийдвэрийн 62 заалт	**100% - 40 заалт; 70% - 12 заалт; ХБ. – 10 заалт.**	**Дундаж үнэлгээ: 93.08%**	
Зургаа. Ерөнхий сайдын захирамж					
80	120	**Ажлын хэсэг байгуулах тухай** 2023-02-06, Дугаар 28 2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааны чиглэл, салбар, хүрээг оновчтой тогтоож, өмчлөл, засаглалын зохистой бодлогыг хэрэгжүүлэх, бүтээмж, үр ашгийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний цогц санал боловсруулан танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Арга хэмжээний цогц саналаа шуурхай боловсруулан танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Амарбаясгалан)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, засаглалыг сайжруулах чиглэлээр 3 хэсэгт хуваан авч үзэн санал боловсруулж, ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 5 дугаар тэмдэглэл гарган, саналын хамтаар ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үүнд: 1.Стратегийн ач холбогдолтой болон бусад томоохон төрийн өмчийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үнэ цэн бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх замаар өгөөжийг өсгөх, Үндэсний баялгийн санг бүрдүүлэн Монгол Улсын эдийн засагт хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-д уул, уурхайн салбарын компаниудыг нэгтгэн нэгдлийн хэмжээнд ажиллуулах. 2.“Эрдэнэс Монгол” нэгдэлд хамааруулснаас бусад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг “Төрийн өмчийн корпорац” ТӨХХК байгуулж, харьяалуулан нэгтгэх. 3. Одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд төрийн өмчит үйлдвэрийн газруудыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад харьяалуулах. Засгийн газрын шийдвэрээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой дулааны станц” ХХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Цемент шохой” ТӨХК зэрэг хуулийн этгээдийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд ажиллуулахаар шийдвэрлэсэн. “Эрдэнэс Монгол” нэгдлийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байхаар тогтоосон. Ерөнхий сайдын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 130 дугаар захирамжаар эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудыг үндсэн үйл ажиллагааны чиглэлийг нь харгалзан өөрчлөн зохион байгуулах, хэрэглэгчдэд үйлчлэх төвийн чиг үүргийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

			дээр гүйцэтгүүлэх боломжийг судлан үзэж санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын дагуу өөрчлөн зохион байгуулагдсан “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн дүрмийг ТӨБЗГ-ын 2023 оны 407 дугаар тогтоолоор баталсан. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, компанийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ТӨБЗГ-ын 527, 565 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг томилж, 485 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирлыг томилох удирдамжийг Төлөөлөн удирдах зөвлөлд өгсөн. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүднээс “Төрийн өмчийн корпорац” байгуулах тухай асуудлыг судлан, холбогдох санал, тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.		
81	121	**Ажлын хэсэг байгуулах тухай** 2023-05-22, № 93 2. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, үр ашиггүй зардлыг бууруулах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн нэгдсэн тооллогын ажлыг зохион байгуулж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Хуульд заасны дагуу болон бусад эрх бүхий этгээдийн шийдвэрээр үүсгэн байгуулагдсан, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд (компани тэдгээрийн охин, хараат компани, сан, үйлдвэрийн газар)-ийн тоо, дүнг нэгтгэн 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Цэнгэл)-т даалгасугай.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, үр ашиггүй зардлыг бууруулах ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд (компани тэдгээрийн охин, хараат компани, сан, үйлдвэрийн газар)-ийн тоо, дүнг нэгтгэж, мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны А-1/1185 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн болно.	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
		Ерөнхий сайдын захирамж: 2 шийдвэрийн 2 заалт.	**100% - 2 заалт.**	**Дундаж үнэлгээ: 100%**	
Долоо. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					

82	122	**“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай** 2021-02-24, № 13 XI.2.1. “Төрийн орон сууцны корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах замаар төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. “Төрийн орон сууцны корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах асуудлыг нарийвчлан судалж, санал солилцож нэгдсэн байр сууринд хүрэх талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалантай хамтран зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Их Хурлын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл”-д ипотекийн хөтөлбөрийг 2023 оны эхний хагас жилд багтаан Засгийн газарт шилжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийг “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” болгон зохион байгуулж, “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг Засгийн газрыг төлөөлж тус байгууллагад шилжүүлэхээр Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар 15-ны өдрийн 51 дүгээр захирамжаар Ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсгийн хурлыг 2023 оны 05, 06 дугаар сард нийт 3 удаа зохион байгуулж, хурлын үеэр ипотекийн зээлийн хөтөлбөрийг шилжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох журам, гэрээний төслийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран эцэслэн боловсруулж, танилцуулсан. Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/2050 тоот албан бичгийг Засгийн газрын гишүүд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх тогтоолын төсөлд санал авч байна. Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хэлэлцүүлгийн үеэр ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн бондыг Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулан, эзэмшүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Үндэсний орон сууцны корпорацыг Олон улсын донор байгууллагуудаас бие даан хөнгөлөлттэй эх үүсвэр босгох чадамжтай байдлаар чиг үүргийг тодорхойлон бүтэц зохион байгуулалтыг хийх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийг үүрэг болгосон. Энэ чиглэлээр Ерөнхий сайдын 2023 оны 51 дугаар захирамжаар Барилга, хот байгуулалтын сайдаар ахлуулан, Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллийг оролцуулан байгуулсан ажлын хэсгээс уг асуудлыг судалж, санал, дүгнэлт гарган танилцуулахаар ажиллаж байна.	“Хэрэгжих шатанд” - 70%	

	123	**“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай** 2021-02-24, № 13 XI.2.2. “Төрийн орон сууцны корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах замаар “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах асуудлыг холбогдох компаниудын хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах, хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг боловсруулж, хувь эзэмшигчийн хэмжээ, шинээр байгуулах компанийн хөрөнгийн хэмжээ зэргийг нэг мөр тооцож, зохих шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Их Хурлын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл”-д ипотекийн хөтөлбөрийг 2023 оны эхний хагас жилд багтаан Засгийн газарт шилжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийг “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” болгон зохион байгуулж, “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг Засгийн газрыг төлөөлж тус байгууллагад шилжүүлэхээр Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар 15-ны өдрийн 51 дүгээр захирамжаар Ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсгийн хурлыг 2023 оны 05, 06 дугаар сард нийт 3 удаа зохион байгуулж, хурлын үеэр ипотекийн зээлийн хөтөлбөрийг шилжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох журам, гэрээний төслийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран эцэслэн боловсруулж, танилцуулсан. Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/2050 тоот албан бичгийг Засгийн газрын гишүүд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх тогтоолын төсөлд санал авч байна. Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хэлэлцүүлгийн үеэр ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн бондыг Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулан, эзэмшүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Үндэсний орон сууцны корпорацыг Олон улсын донор байгууллагуудаас бие даан хөнгөлөлттэй эх үүсвэр босгох чадамжтай байдлаар чиг үүргийг тодорхойлон бүтэц зохион байгуулалтыг хийх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийг үүрэг болгосон. Энэ чиглэлээр Ерөнхий сайдын 2023 оны 51 дугаар захирамжаар Барилга, хот байгуулалтын сайдаар ахлуулан, Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллийг оролцуулж байгуулсан ажлын хэсгээс уг асуудлыг судалж, санал, дүгнэлт гарган танилцуулахаар ажиллаж байна.	“Хэрэгжих шатанд” - 70%	
	124	**“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай** 2021-02-24, № 13	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Өр төлбөрийн тухайд: - 180.5 тэрбум төгрөгийн бондын эргэн төлөлтийг Хөгжлийн банктай байгуулсан “Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ”-ний хуваарийн дагуу төлж байгаа бөгөөд 2023 оны эхний хагас жилийн төлбөр болох 7.6 тэрбум төгрөгийг түрээсийн орон сууцны орлого болон Засгийн	“Бүрэн биелсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

		XI.2.3. “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани шинээр байгуулахтай холбогдуулан “Төрийн орон сууцны корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, шилжүүлэх, өр төлбөрийг хэрхэн барагдуулах талаар судалж, шийдвэрлүүлэх талаар тодорхой саналаа холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулан хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (С.Наранцогт)-д;	газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоолын дагуу улсын төсөвт суусан хөрөнгөөс бүрдүүлэн хугацаанд нь төлж байгаа. - Томоохон дүнтэй өр төлбөрийн хувьд, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээтэй нийт 7 байгууллагын 18.9 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулахаар ажиллаж байна. Үүнээс нийт 902.1 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн. Дээрх өр төлбөр барагдуулах ажлын хүрээнд 6 байгууллагын 8.9 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс ажиллаж байна, 1 байгууллагын 9.0 тэрбум төгрөг нь шүүхийн шийдвэр гарсан байна. Хэрэгжүүлж буй төслийн тухайд: 1. *Түрээсийн орон сууцны хөтөлбөр:* Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2016 оны 38, 169 болон 298 дугаар тогтоолоор нийт 1,520 айлын орон сууцыг төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэн, үүнээс Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын дагуу нийт 890 айл өрхтэй “Түрээслээд өмчлөх гэрээ” байгуулан, үлдсэн 630 орон сууцыг энгийн түрээсийн гэрээгээр түрээслүүлж, түрээсийн орлого болон орон сууцны урьдчилгаа төлбөрийг төвлөрүүлэн, Хөгжлийн банкны өр төлбөрийг төлж байна. 2. *Солонго 1, 2 төсөл:* 2022-2027 онд ХУД, 21-р хороонд байршилтай 5002 айлын 9 давхар 67 блок орон сууцны цогцолбор хорооллыг БНСУ-ын Эксим банкны 266.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэгчээр шалгарсан БНСУ-ын ”Колон Глобал Корпорэйшн” компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 онд багтаан барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. 3. *Эко яармаг төсөл:* Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 2021-2026 онд ХУД, 4-р хороо, 146 нэгж талбар газарт 689.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,800 айлын 16 давхар 13 орон сууцны төслийг “Түм Арвижих” ХХК, “УБАЗБК” ХХК-ийн түншлэлтэй хамтран бүтээн байгуулахаар ажиллаж байна. Төслийн хүрээнд 1-р ээлжийн барилгажих талбайг чөлөөлөх ажил эхэлж, хамрагдсан иргэдийг түр суурьшуулах ажил хийгдсэн. Мөн төслийн 1-р ээлжийн орон сууцны барилга угсралтын бэлтгэл ажлыг хангаж, суурийн ажлыг эхлүүлсэн. 4. *Залуус 1 төсөл:* 2021-2028 онд ХУД, 21-р хороонд байршилтай, 5,616 айлын 9 давхар 94 блок орон сууцны цогцолбор хорооллыг төр, хувийн хэвшлийн түншлэл хамтран 1.6 их наяд төгрөгийн санхүүжилтийг хийн ажиллахаар төлөвлөлт хийгдсэн байна. Төслийн эхний ээлжийн барилгын талбайн дэд бүтцийн шугам сүлжээний угсралтын ажил 2023 оны 4-р сараас эхлэн үргэлжилж байна.		

	125	**2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл** 2021-02-24, № 13 XI.2.4. “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулахтай холбогдуулан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг орон сууцжуулахтай холбогдсон зорилт, арга хэмжээг компанийн дүрэмд хэрхэн тусгаж, уялдуулах саналаа танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт.”	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг орон сууцжуулахтай холбогдсон зорилт, арга хэмжээг “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон компанийн дүрмийн төсөлд тусгахаар боловсруулж байна. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл”-д ипотекийн хөтөлбөрийг 2023 оны эхний хагас жилд багтаан Засгийн газарт шилжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийг “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” болгон зохион байгуулж, “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг Засгийн газрыг төлөөлж тус байгууллагад шилжүүлэхээр Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар 15-ны өдрийн 51 дүгээр захирамжаар Ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсгийн хурлыг 2023 оны 05, 06 дугаар сард нийт 3 удаа зохион байгуулж, хурлын үеэр ипотекийн зээлийн хөтөлбөрийг шилжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох журам, гэрээний төслийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран эцэслэн боловсруулж, холбогдох байгууллагаас санал авах ажлыг зохион байгуулсан байна.	“Хэрэгжих шатанд” - 70%	
83	126	**Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн өмчлөлийн хэлбэр, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, компанийн засаглал, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай** 2021-03-10, № 17 XII.2.1. Төрийн өмчит үйлдвэрийн газар, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн өмчлөлийн хэлбэр, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох,	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг хэт ерөнхий болон давхцал, хийдэлтэй зохицуулсны улмаас хяналт хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүнд тавих хяналтыг сулруулж, үр өгөөжгүй захиран зарцуулах үр дагаварт хүргэж байна. Иймээс, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор уг асуудлыг шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудлыг тусгасан.	“Хэрэгжих шатанд” - 70%	

		компанийн засаглал, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: **1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн үндэслэл, зохицуулах харилцааны давхардал, зөрчлийг арилгах, өмчийн тухай ойлголтыг эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан шинээр тодорхойлох, өмчийн удирдлагыг боловсронгуй болгох, өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх зүйн үндсийг тодорхой болгох, холбогдох хуулиудын уялдаа холбоог хангах судалгаа хийж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг** Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Засгийн газраас, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус тус бусад холбогдох хуулийн төслийн хамт 2022 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. УИХ-ын чуулганаар уг хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар уг хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх анхны хэлэлцүүлэгт бэлтгэх, Эдийн засгийн Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Уг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан.		
84	127	**XY.7. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын исэлдсэн хүдрийн болон тодорхой нөхцөлд үр ашигтай буюу ядуу агуулгатай хүдрийн овоолгын ашиглалтын тухай** 2021-10-13, № 55 “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын исэлдсэн хүдрийн болон тодорхой нөхцөлд үр ашигтай буюу ядуу агуулгатай хүдрийн овоолгыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үндэслэл, хүдрийн нөөцөд тулгуурлан одоогийн нөхцөлөөс илүү үр ашигтай	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Эрдэнэтийн Овоо зэс молибденийн ордын исэлдсэн хүдрийн үүсмэл ордыг ашиглах өнөөгийн ашиглагдаж буй хувилбарт үнэлэлт дүгнэлт өгөх ажил хийгдсэн. Үүнд: 1.2023 оны байдлаар 0.497%-ийн дундаж агуулгатай 53.19 сая.тн исэлдсэн хүдрийн овоолго үүсээд байгаа ба исэлдсэн хүдрийг SX-EW буюу нуруулдан уусгах технологиор “Эрдмин” ХХК, “Ачит Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК гэсэн аж ахуй нэгжүүд хамтран ажиллах гэрээгээр үйлдвэрлэл явуулж байна. Үйл ажиллагаа явуулж буй компаниуд нь өөр өөр гэрээний нөхцөлүүдтэй байна. 2.Исэлдсэн хүдрийг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлийн хүрээнд одоогийн ажиллаж байгаа гэрээний нөхцөлүүд болон шинээр ашиглаж болох гэрээний нөхцөлүүдийг харьцуулж тооцоолол хийсэн. Үүнд:	“Бүрэн биелсэн” – 100%	"Эрдэнэс Монгол" нэгдлийн харьяанд шилжсэн тул цаашид хяналтаас хасуулах саналтай

		нөхцөлөөр ашиглах санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэлд даалгав.	**Борлуулалтын орлогыг 2 хувиар** хамтран ажиллах гэрээ байгуулах. (“Ачит ихт” ХХК байгуулсан гэрээ бөгөөд тооцоолол хийж үзэхэд хамгийн үр ашиг муутай байна) **Үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд 34%** хүртэл хувь эзэмших. (“Эрдмин” ХХК-тай байгуулсан гэрээний нөхцөл ба хөрөнгө оруулалт үр ашиг, хяналт зэрэг эрсдэлүүд үүсэх магадлал өндөр) Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах (Үр ашиг эрсдэл талаас хамгийн эрсдэл багатай хувилбар ба сонгон ашиглаж болно.) **Исэлдсэн хүдрээ биржээр арилжах** (Эдийн засаг, нийгэм талаар хамгийн зөв зохистой хувилбар ба хүдэр нийлүүлэлт дээр асуудал үүсэх эрсдэлтэй.) Хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдэд хүдэр нийлүүлэхээ больж, “**Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ өөрийн хөрөнгөөр үйлдвэр барих**. (Овоолгоос ашиглалт явуулж буй аж ахуй нэгжүүд болон орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарах эрсдэлтэй) Дээрх нөхцөлүүдээр судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийж үзэхэд хамгийн үр өгөөж өндөртэй нь “Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах” хувилбар байна. **Тулгамдаж буй асуудал:** Эрдэнэтийн Овооны зэс молибденийн орд нь стратегийн ач холбогдол бүхий орд газар учир исэлдсэн хүдрийг ашиглах асуудлыг зайлшгүй Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэх, чиглэл авах ба “Эрдэнэс Монгол” ХХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ дангаар шийдвэр гаргах боломжгүй юм.		
85	128	**Y. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** 2021-11-10, № 59 1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2.Энэ тогтоолын 1, 2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагатай	**ТӨБЗГ – ТӨУЗХ** ТӨБЗГ-аас хувьцаа эзэмшигчийн 100 хувийн эрхийг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал нартай байгуулсан 2021 оны гэрээг 2022 онд үзүүлэлт бүрээр дүгнэн дүгнэлт гаргаж, “Хангалтгүй” дүгнэгдсэн хуулийн этгээдийн удирдлагуудтай байгуулсан гэрээг цуцлах, 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах талаар тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд Төрийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа гишүүдэд удирдамж, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулсан байна. Гүйцэтгэх захирал болон захирал нартай байгуулсан 2022 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан журам, аргачлалын дагуу дүгнэхээр удирдамж, чиглэл өгсөн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчийн 100 хувийн эрхийг хэрэгжүүлж буй 41 хуулийн	“Бүрэн биелсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

		холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нарт тус тус даалгав.	этгээдийн болон Эрчим хүчний салбарын компаниудын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг тус тусын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Дээрх ажлын дүн болон аудитаар баталгаажсан 2022 оны санхүүгийн тайлангийн дүнгийн нэгтгэлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 87 хуулийн этгээд нийт дүнгээр 14,553,979.9 сая төгрөгийн орлого олж, 11,561,950.2 сая төгрөгийн зардал гаргаж, 2,055,798.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.		
86	129	**XIII.9. В.И.Лениний нэрэмжит клубын барилга, газар эзэмшлийн тухай** 2021-11-17, № 60 YIII.9. В.И.Лениний нэрэмжит клубын барилга, түүний эзэмшилд хамаарах газрын улсын тусгай хэрэгцээнд авах боломжтой эсэхийг судлан үзэх, үүний зэрэгцээ уг газраас бусдад эзэмшүүлэх, ашиглуулахаар олгосон шийдвэрийг цуцлах талаар холбогдох иргэн, хуулийн этгээдтэй яриа хэлэлцээ хийх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.	**ТӨБЗГ – ТӨБАХ** “Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах ОХУ-ын эдэлбэр газар болон үл хөдлөх хөрөнгө (Ленин клуб)-ийн эрхийг дахин бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг эцэслэж тохиролцсон. Хэлэлцээрийг хийж ОХУ-ын талтай ойлголцолд хүрсэн. Газар олгосон шийдвэрийг цуцлах асуудал нь Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд хамаарах асуудал бөгөөд хэлэлцээр батлагдсаны дараа шийдвэрлэхээр хүлээгдэж байна. Одоо дипломат шугамаар ноот солилцох, соёрхон батлуулах ажлыг Гадаад харилцааны яам хариуцан гүйцэтгэнэ. Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын комиссын нэгдсэн хуралдаан 2023 оны 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд болсон бөгөөд уг хуралдааны протоколд тухайн асуудлаар хэлэлцээр байгуулахаар туссан. Хэлэлцээрийн төслийг Ерөнхий сайдын 2016 оны 91 дүгээр захирамжаар байгуулагдсан “Монгол Улс дахь ОХУ-ын өмч, үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлыг шийдвэрлэх” Ажлын хэсгийн хуралдаанаар харилцан тохиролцсон. Одоогоор газар болон үл хөдлөх хөрөнгийн маргаан шүүх, хяналтын байгууллагаар хянагдаж байгаа. Шүүхийн шийдвэр эцэслэн гарахыг хүлээж байна. Энэ талаар тайлбар бэлтгэн Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын нэр дээр албан бичиг хүргүүлээд байна.	“Хэрэгжих шатанд” – 70%	ТӨБЗГ-аас хамаарах хэлэлцээр хийх ажил хийгдсэн тул хяналтаас хасах саналтай.
87	130	**Тэмдэглэл** 2021-11-24, № 61 XI.4.7. Хилийн Шивээхүрэн-Сэхээ боомтын хилийн төмөр замын боомтын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх асуудлаар хятадын талтай яриа, хэлэлцээ хийхийг Гадаад харилцааны	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Засгийн газрын 2022 оны 446 дугаар тогтоолоор Шивээхүрэн-Сэхэ боомтын төмөр замын бүтээн байгуулалтын асуудлаар Хятадын талтай хэлэлцээ хийх эрхийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон. Уг тогтоолын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК нь “Хятадын төмөр замууд корпорац”-тай 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Бээжин хотод Шивээхүрэн – Сэхээ хилийн боомтын төмөр замын бүтээн байгуулалтын асуудлаар мэргэжилтнүүдийн	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	

		сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийг татан буулгах эсэх, “Монголын төмөр зам” ТӨХК болон “Өсөх зоос” ХХК-ийн хамтарсан компани байгуулах эсэх асуудлыг судалж 2021 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	түвшинд уулзалт хийсэн. Хэлэлцсэн асуудлаар 2 тал протокол үйлдэж боомтуудын асуудлаар яриа хэлэлцээг эхлүүлсэн байна. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 23/04 тоот тогтоолыг үндэслэн “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 51 хувь, “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийн 49 хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээ, дүрмийг баталж, компанийг үүсгэн байгуулав. Шивээхүрэн боомтын төмөр замын бүтээн байгуулалтыг 2023 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөс эхлүүлсэн.		
88	131	**Тэмдэглэл** 2022-02-09, № 9 IY.1. Монгол Улсын Хөгжлийн банкнаас төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор зээл авсан төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, холбогдох төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** 1. Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-д олгосон зээл, зээлийн хүүгийн төлбөрийн нийт дүнгээр үнэт цаас гаргах асуудлыг шийдвэрлэсэн. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Бүртгэлийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн өрийн хэрэгслийг бүртгэх тухай” БХ22/77 дугаартай тогтоол гарсан. 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 180.5 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж, анхдагч зах зээлийн арилжаа хийгдсэнээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1”, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар авсан зээл, түүний хүү болох нийт өр төлбөрийг төлж барагдуулан, Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан. 2. Шүүхийн шийдвэрийн дагуу “Төрийн орон сууц” ТӨХХК-ийн хариуцан төлөх 24,604,103,971 төгрөгийг “Нью яармаг хаусинг прожект” ХХК үл хөдлөх хөрөнгөөр төлж барагдуулсан. Хөгжлийн банк дахь “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн нэр дээрх “Шинэ яармаг” төслийн зээлийн өр төлбөр төлөгдөж дууссан. 3.“МИАТ” ТӨХК-ийн BOEING767-300ER агаарын хөлгийг худалдан авах зориулалтаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн үлдэгдлийг 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр мөнгөн хэлбэрээр төлж, хугацаанаас нь 2 сарын өмнө барагдуулсан. 4.“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны “Тогтоолын хэрэгжилтийг хангуулах тухай” 31 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д үүрэг болгосны дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2022.09.26-ны өдрийн 32 дугаарт тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Монгол Улсын Хөгжлийн банкнаас зээлсэн зээлийн өр болох төлбөрийн асуудлыг	“Бүрэн хэрэгжсэн” - 100%	

			шийдвэрлэсэн. Үүний дагуу “Эрдэнэс Монгол” ХК-ийн мэдээлэл: 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан нийт зээлийн үлдэгдэл 42.6 тэрбум төгрөг, хуримтлагдсан хүүгийн өглөг 877 сая төгрөг, нийт 43.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан. Гүйцэтгэх захирлын 2023 оны 4 дүгээр 19-ны өдрийн 01/296 тоот албан бичгээр Хөгжлийн банканд хандсан ба хуваарийн дагуу төлөлт хийсний дүнд зээлд 42.6 тэрбум төгрөг, зээлийн хүүд 3.2 тэрбум төгрөг, нийт 45.85 тэрбум төгрөгийн өр төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.		
89	132	**Тэмдэглэл** 2022-03-09, № 15 XXII.1.5. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлын хүрээнд зарим хуулийн этгээдийг татан буулгах, нэгтгэх, хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, биржээр олон нийтэд нээлттэй худалдаж, нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үе шаттай хэрэгжүүлж байна. “Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO амжилттай хэрэгжсэн. “Үндэсний давхар даатгал” ТӨХК нь үнэт цаасны танилцуулгаа боловсруулж, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрлүүдээ авсан, IPO-г зарлахад бэлэн болсон. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн үнэт цаасны танилцуулгыг боловсруулж байгаа, 10 дугаар сард багтаан дуусгахаар ажиллаж байна. “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO хийх бэлтгэл ажлыг хангаж байна. Төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах чиглэлээр томоохон ажлын эхлэл тавигдсан. “Төрийн өмчит хуулийн этгээдийг хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн хүрээнд: – “Төрийн банк” ХК-ийн нийт хувьцааны 5% буюу 34,745,000 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 590 төгрөгөөр тооцон 22.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж 5.71 хувийн хувьцааг 7306 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 67.3 тэрбум төгрөг; – “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хувьцааны 34% буюу 119,157,603 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 100 төгрөгөөр тооцон 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Зохион байгуулал-тын арга хэмжээ авсан тул хяналтаас хасуулах саналтай.

			амжилттай болж 34 хувийн хувьцааг 7414 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 57.8 тэрбум төгрөг тус тус татан төвлөрүүлсэн болно. Төрийн өмчит компаниудын үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын дагуу өөрчлөн зохион байгуулагдсан “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн дүрмийг ТӨБЗГ-ын 2023 оны 407 дугаар тогтоолоор батлсан. Тбус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, компанийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ТӨБЗГ-ын 527, 565 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг томилж, 485 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирлыг томилох удирдамжийг Төлөөлөн удирдах зөвлөлд өгсөн.Цаашид нэгтгэл хэлбэрт оруулснаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар төлөвлөн байна.		
90	133	**Тэмдэглэл** 2022-04-08, № 21 I.1.6. “Суудлын автомашин ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоол, Төрийн албан хаагчийн албан унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	**ТӨБЗГ – ТӨБАХ, ХЭЗХ** ТӨБЗГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний үнэ тариф, зардлын норм, норматив болон Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишгийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн ажлын хүрээнд дараах ажлуудыг хийв: 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203, 204 дүгээр тогтоолоор энэхүү тэмдэглэлд заасан холбогдох арга хэмжээг авсан. Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолоор төрийн албанд ашиглагдах суудлын автомашины хэрэглээг зохицуулж, суудлын автомашин ашиглах эрх бүхий 21 албан тушаалтны жагсаалтыг баталж, холбогдох бусад арга хэмжээг авсан байна. Уг тогтоолоор “Суудлын автомашин ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталсан. Журмыг мөрдөх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай.

			31-ний өдрийн “Чиглэл хүргүүлж, санал авах тухай” А-1/194 дүгээр албан бичгээр төрийн өмчит хуулийн этгээдүүдэд чиглэл хүргүүлэв. Засгийн газрын 2022 оны 203 тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх хүрээнд ажлын хэсгээс холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийсний дүнд Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор батлсан “Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, тавилга хэрэгслийн нийтлэг жишиг”-т өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэн Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А-1/2029 дугаартай албан бичгээр танилцуулга болон холбогдох баримт материалыг хүргүүлсэн.		
	134	**Тэмдэглэл** 2022-04-08, № 21 I.1.7. Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай анхдагч хуулийн төсөлд тусгагдаж байгаа болно. УИХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5-д “...Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно...”, 6-д “...Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.5-д заасан улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээд биржээр арилжаалах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг эзэмшихийг хориглоно...”, 7-д “...Энэ хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална...” гэж тус тус заасан өөрчлөлтийг оруулсан. “Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO амжилттай хэрэгжсэн. “Үндэсний давхар даатгал” ТӨХК нь үнэт цаасны танилцуулгаа боловсруулж, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хороонооос холбогдох зөвшөөрлүүдээ авсан, IPO-г зарлахад бэлэн болсон. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн үнэт цаасны танилцуулгыг боловсруулж байгаа, 10 дугаар сард багтаан дуусгахаар ажиллаж байна. “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO хийх бэлтгэл ажлыг хангаж байна.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

			Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолоор авто замын засвар, арчлалтын ажил эрхэлдэг төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулсан. ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 407 дугаар тогтоолоор тус нэгтгэл компанийн дүрмийг баталсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, компанийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан.		
91	135	**Тэмдэглэл** 2022-05-11, № 28 XYI.12. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх улсын тусгай хэрэгцээний газраас 50 га талбайг ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүс байгуулах зориулалтаар тусгай хэрэгцээнд авч, “Монголросцветмет” ТӨҮГ-т олгох асуудлыг холбогдох журмын дагуу судалж, танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт, **гаалийн хяналтын бүс байгуулснаар гарах үр дүн, техник, эдийн засгийн үндэслэлийг танилцуулахыг** Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), **“Монголросцветмет” ТӨҮГ-ын захирал (Б.Мөнхбат) нарт;**	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Монголросцветмет” ТӨҮГ нь талбайн кадастрын зургийг “Аэрогеодезн” ХХК-иар, ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүсийн техник, эдийн засгийн урьдчилсан үндэслэлийг “Рейлвэй консалтинг сервис” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Гаалийн хяналтын бүсийг байгуулах эхний ээлжийн хөрөнгийн эх үүсвэрийг “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2022 оны төсөвт суулгасан бөгөөд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр хамтран ажиллах, Засгийн газрын тогтоол гаргахад дэмжлэг хүссэн албан тоотуудыг холбогдох яам болон “Монголын төмөр зам” ХХК-д илгээсэн боловч Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 11-ний 01/4678 тоот албан бичгээр дэмжих боломжгүй гэдэг хариу ирсэн. “Эрдэнэс Монгол” ХХК-аас 2023 оны 06 сарын 14-ны өдрийн 01/485 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яамд хүсэлт хүргүүлсэн боловч дэмжих боломжгүй гэдэг хариу ирүүлсэн.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	Хэрэгжих боломжгүй болсон тул хяналтаас хасуулах саналтай.
	136	**Тэмдэглэл** 2022-05-11, № 28 XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард	**ТӨБЗГ – МТА** Албан хаагчдыг тоон гарын үсэг хэрэглэх боломжийг судалж, тоон гарын үсгийг хэрхэн авах, түүний ач холбогдол, хэрэглэх талаар албан хаагчдыг мэдээлэл, заавар, арга зүйгээр хангах ажлыг хийв. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран, 2022 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 1-ний өдрүүдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдад тоон гарын үсэг авах ажлыг ажлын байранд зохион байгуулсны дүнд нийт 32 албан хаагч тоон гарын үсэг авсан.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	

		багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, **тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.**	Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа дахь гүйлгээний баримт бичгүүдэд эрх бүхий албан тушаалтнууд цахим гарын үсэг ашиглаж байгаа болно.		
92	137	**Тэмдэглэл** 2022-05-18, № 29 XIY.3.3. Циркийн урлагийн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах чиг үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсэг байгуулж ажиллан саналаа 2022 оны 10 дугаар сард багтаан танилцуулахыг Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгав;	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ** Соёлын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/267, А/1035, А/48 дугаартай хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2 дахь удаагийн хурал 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан. Ажлын хэсгийн өмнөх хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу Үндэсний архивын газар хадгалагдаж буй Циркийн хувьчлалтай холбоотой 40 гаруй бодит материалыг нэг бүрчлэн үзэж, холбогдох материалыг хувилж авч танилцан судалсан бөгөөд эдгээр материалуудад тулгуурлан ТӨБЗГ-ын төлөөллийн зүгээс Циркийн хувьчлал болон “Худалдах, худалдан авах тухай” 399 дүгээр гэрээний биелэлтийн талаар холбогдох мэдээллийг ажлын хэсэгт танилцуулсан. Мөн “АСА консалтинг” ХХК-ийн төлөөлөл циркийн барилгын хөрөнгө оруулалтын талаар танилцуулга хийсэн. Ажлын хэсэг “АСА консалтинг” ХХК-ийн гүйцэтгэх удирдлагыг байлцуулан 14 хоногийн дараа дахин хуралдахаар шийдвэрлэсэн бөгөөд Ажлын хэсгийн хурлаас тус компанийн төлөөлөлд холбогдох хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн болно. Хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийн талаар “АСА консалтинг” ХХК-иас хариу ирүүлээгүй ба ажлын хэсэг дахин хуралдаагүй байна. Тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор тус циркийн захирал н.Отгонцэцэгтэй уулзалт хийх шаардлагатай байгааг удаа дараа мэдэгдэж, нийт 10 гаруй албан тоотыг тус байгууллага руу илгээсэн хэдий ч гадаадад томилолтоор явсан гэх мэдээллийг өгч өнөөдрийг хүртэл барилгын батлагдсан зураг төсвийг ирүүлээгүй, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааны төлөвлөгөө, урын сангийн бодлого, АСА циркт	“Хэрэгжих шатанд”-70%	ТӨБЗГ-аас хийх болон шалтгаалах ажил дууссан гэж үзэж байгаа.

			харьяалах циркийн уран бүтээлчдийн нийгмийн асуудлын талаар ямар ч мэдээлэл ирүүлээгүй байдлаас ажлын хэсгийн ажлыг удаашруулж байна.		
	138	**Тэмдэглэл** 2022-05-18, № 29 XIY.3.4. Төрийн өмчийн хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, “Аса консалтинг” ХХК хооронд улсын циркийн урлагийн мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр, зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгөөр байгуулсан “Худалдах, худалдан авах гэрээ №399” болон үүнтэй холбогдож гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.”.	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ** Соёлын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2 дахь удаагийн хурал 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан. Ажлын хэсгийн өмнөх хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу Үндэсний архивын газар хадгалагдаж буй Циркийн хувьчлалтай холбоотой 40 гаруй бодит материалыг нэг бүрчлэн үзэж, холбогдох материалыг хувилж авч танилцан судалсан бөгөөд эдгээр материалуудад тулгуурлан ТӨБЗГ-ын төлөөллийн зүгээс Циркийн хувьчлал болон “Худалдах, худалдан авах тухай” 399 дүгээр гэрээний биелэлтийн талаар холбогдох мэдээллийг ажлын хэсэгт танилцуулсан. Уг баримт материалыг холбогдох газруудад хүргүүлсэн. Төрийн өмчийн хорооны 2006 оны 630 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын циркийг удирдах үйл ажиллагааг гүйцэтгэж, менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах баг сонгон шалгаруулах нээлттэй уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам”-ын 1.4-д “...Уралдаант шалгаруулалтад шалгарсан этгээд нь “Менежментийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ биелүүлж, өмчлөгч болсон нөхцөлд Стратегийн төлөвлөгөөгөө 2007-2011 он хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах тухай гэрээг БСШУЯ-тай байгуулна...” гэж заасан боловч энэхүү гэрээнүүд хийгдээгүй байна. ТӨХ-ны 2008 оны 352 дугаар тогтоолын 5-р заалтаар Улсын циркийн баланст бүртгэлтэй хуучин циркийн барилгыг төрийн мэдэлд үлдээж, циркийн сургуулийн зориулалтаар Хөгжим бүжгийн коллежийн мэдэлд түр эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн тул “Соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах тухай гэрээ”-г БСШУЯ-тай байгуулах шаардлагагүй болсон гэж үзэж байна. Харин “Менежментийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ биелүүлж, өмчлөгч болсон нөхцөлд “Стратегийн төлөвлөгөөгөө үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэрээ”-г БСШУЯ-тай байгуулаагүй байна.	“Хэрэгжих шатанд”-70%	ТӨБЗГ-аас хийх болон шалтгаалах ажил дууссан гэж үзэж байгаа.
93	139	**Тэмдэглэл** 2022-05-25, № 30 I.4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ** Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 28 дугаар тэмдэглэлийн “1.12. Өмнөговийн Мэргэжлийн хяналтын байрыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас түр өгсөн байгаа, тус барилгыг “Эрдэнэс Тавантолгой” ХК”-д шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх”, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 109 дүгээр тогтоолоор Өмнөговь аймгийн мэргэжлийн хяналтын газрын барилгыг газрын хамт	“Хэрэгжих шатанд” – 70%	

		байршуулах талаар санал боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК (О.Хулан) нарт даалгав.	ТЗҮЭГ-т балансаар шилжүүлж тус барилгыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ашиглуулах тухай шийдвэрүүд гарсан. Энэ шийдвэрийн дагуу Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхт Төлөөлөгчийн 2023 оны А/344 дугаартай “Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын барилгыг хүлээлцэх ажлын хэсэг байгуулах тухай” тушаал гарч, уг ажлын хэсэг Засгийн газрын ажлын хэсэгтэй энэ чиглэлээр хамтран ажилласан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 221 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2023 оны 10 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Өмнөговь аймагт газар дээр нь ажилласнаар Мэргэжлийн хяналтын газрын тус барилгын 1-2 давхарт бүхэлд нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг түрээсээр байршуулах ажлыг зохион байгуулав. “Төрийн өмчийн түрээсийн гэрээ” байгуулахаар холбогдох журмын дагуу баримт материалыг бэлтгэж, Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хооронд ашиглалтын гэрээ байгуулан албажуулсан бөгөөд Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоол болон 28 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт хангагдсан байна. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын газар нутагт байрлах төв оффисын барилгын зураг төслийг хийж гүйцэтгэх ажлыг 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхт Төлөөлөгчийн 2023 оны А/107 тоот тушаалаар зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтын үнэлгээний хороог байгуулсан.		
94	140	**Тэмдэглэл** 2022-06-22, № 34 XII.1.2. “Монгол ган” цогцолбор I төслийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр төслийн ТЭЗҮ, санхүүжилт, эрчим хүч, тээвэр логистик зэрэг дэд бүтцийн тулгамдсан асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Монгол ган цогцолбор I” төслийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр төслийн ТЭЗҮ, санхүүжилт, эрчим хүч, тээвэр логистик зэрэг дэд бүтцийн тулгамдсан асуудлаар “Шинэ сэргэлт-Монгол ган” хэлэлцүүлгийг 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-иас “Монгол ган цогцолбор I” төслийн танилцуулга, тулгамдсан асуудлуудыг танилцуулсан. Хэлэлцүүлэгт оролцсон холбогдох эрх бүхий байгууллага болох Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Эрчим хүчний яам, “Улаанбаатар төмөр зам” ХНН төслийн тулгамдсан асуудлуудтай холбоотой илтгэл тавьж, асуудлуудыг шийдвэрлэх шийдэл, зөвлөмж гаргасан. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг бүс нутгийн уул уурхай, металлургийн кластер хэлбэрээр хөгжүүлэх талаар судлан тус үйлдвэрийг “Эрдэнэс Монгол нэгдэл” ХХК-ийн бүрэлдэхүүнд ажиллуулах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 22 дугаар тэмдэглэл гарсан бөгөөд уг тэмдэглэлийг 2022 оны А-1/2102 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	"Эрдэнэс Монгол" нэгдлийн харьяанд шилжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

		(Б.Цэнгэл), “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК (А.Ариунболд) нарт;	Улмаар Засгийн газрын 2022 оны 429 дүгээр тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол нэгдэл” ХХК-ийн бүрэлдэхүүнд ажиллуулахаар шийдвэрлэсэн болно. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн металлургийн цогцолбор байгуулах ажлын хүрээнд "Монгол ган цогцолбор-I" төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлснээр 2022 оны 12-р сарын 9-ний өдөр засвартайгаар хүлээн авахаар болсон ба зохих засварууд хийгдэж 2023 оны 2-р сард эцсийн байдлаар хүлээн авсан. Төслийн гадна цахилгаан хангамжийн ТЭЗҮ, зураг төслийн ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр хийлгэхээр саналаа 2022 оны 8-р сараас хойш УУХҮЯ, ЭХЯ, БХБЯ, Сангийн яаманд тавьж ирсэн ба 2023 оны 8-р сарын 15-ны өдөр ЭХЯ-ны 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулж, Сангийн яаманд хүргүүлэх арга хэмжээ авсан.		
95	141	**Тэмдэглэл** 2022-06-29, № 35 XXYII.8. Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд хэрэгжүүлж буй “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” жишиг төслийн бүтээн байгуулалтын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн жишиг болох, Бэрхийн уурхайд суурилсан “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн бүтээн байгуулалтыг төлөвлөсөн хугацаанд дуусгахад төслийн нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн судалж шийдвэрлэх, жишиг нөхөн сэргээлтийн бүтээн байгуулалтын ажилд	**ТӨБЗГ – ТӨУЗХ** 2023 оны эхний хагас жилийн байдлаар Эрдсийн музейн барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Уурхайд орох агаарыг уурын зуухны дулаанаар халаах ажил (ажлын зураг төсөл, тоног төхөөрөмжийн угсралт)-ын тендер зарласан. Монголын үйлдвэрлэлийн түүхэн танхимын тохижилт, заслын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн. Монголын уул уурхайн үүсэл хөгжлийн танхимын тохижилт, заслын ажлын, уулзалтын өрөөний ажлын, цахим үзүүлбэрийн өрөөний ажлын тендер зарлаж, нээсэн, үнэлгээний хороо үнэлгээ хийж байна. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил 2021, 2022, 2023 он дамжин хийгдэж байна. Төслийн гадна тохижилтын ажил 60 хувь, “Очирваань” бурхан бүтээх, хүслээ даатгах танхимын тохижилтын ажлын тендер зарласан, VR өрөөний угсралт, заслын ажил 30 хувь, газрын доорх байгууламжуудын инженерийн хангамж /халаалт агаар сэлгэлт, цэвэр бохир ус, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг, холбоо дохиолол/-ийн ажил 100 хувийн тус тус гүйцэтгэлтэй. Газрын доорх байгууламжийн агааржуулалтын системийн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажил бүрэн хийгдсэн байна.	“Хэрэгжих шатанд”-70%	

		уул уурхайн салбарын төрийн өмчит томоохон компаниудын оролцоог хууль тогтоомжид нийцүүлэн хангуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт;			
96	142	**Тэмдэглэл** 2022-08-17, № 41 YIII.4.3. “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн урсгал зардлыг тооцож үзсэний үндсэн дээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эгийн голын усан цахилгаан станцын биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг дуусгаж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлэх” гэж тусгасны дагуу төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2023 оны зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн нэгжээс боловсруулав. Үйл ажиллагааны зардалд нийт 3,010.19 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт тусгуулахаар саналаа ЭХЯ-нд 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/50 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд ЭХЯ-ны 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн а/3133 тоот албан бичгээр уг төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлсэн байна. Улсын төсөв батлагдахад 1,500.0 сая төгрөг тусгагдсан.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
97	143	**Тэмдэглэл** 2022-08-24, № 42 YIII.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн шинэчлэлийн бодлогын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Шинжлэх ухааны академийн Геологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Газарзүй, геоэкологийн хүрээлэн, Одон орон, геофизикийн хүрээлэнг нийлүүлэх асуудлаар Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан 2022 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Төрийн	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчит төсөвт байгууллагуудтай холбоотой уг асуудлыг холбогдох яамдаас мэдээлэл авч, судалж байна. Тухайн чиг үүргийн яамны санал Засгийн газарт танилцуулагдана. Төрийн өмчит хуулийн этгээдийн шинэчлэлийн бодлогын хүрээнд геологи, уул уурхайн салбараас эхний ээлжид төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болох “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газар болон “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нэгтгэн “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨААТҮГ болгон өөрчлөн зохион байгуулах асуудлыг Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн өмчит зарим үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай” 317 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн. Төрийн өмчит төсөвт байгууллагыг өөрчлөн зохион байгуулах асуудлыг ТӨБЗГ хариуцах чиг үүрэггүй болно. Иймээс салбарын яам хариуцах тул ТӨБЗГ-т шууд хамаарахгүй байна.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	Төрийн өмчит төсөвт байгуул-лагыг өөрчлөн зохион байгуулах асуудал ТӨБЗГ-ын шууд хариуцах асуудал биш, тухайн салбарын яам хариуцна. Тиймээс цаашид

		өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгав.			хяналтаас хасуулах саналтай.
	144	**Тэмдэглэл** 2022-08-24, № 42 ХҮ.2.2.1.Хөгжлийн банкнаас зээл авсан төрийн байгууллагын удирдлага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Засгийн газрын холбогдох гишүүд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран дүгнэлт гаргах, “Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, холбогдох арга хэмжээг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авч, хариуцлага тооцож ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Хөгжлийн банкны өр, зээлтэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК, “Цемент шохой” ТӨХК, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, “Монгол Улсын Хөгжлийн банк”-ХХК-ийн Гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллуулсан. Засгийн газрын 2022 оны “Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай” 220 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдсан. “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-аас “Хөтөл” ХХК-ийн авсан өр төлбөртэй холбоотой Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дээр Зээлийн гэрээний үүрэгт 389,055,659,842.00 төгрөгийг гаргуулах талаар хэрэг үүссэн байгаа бөгөөд тус хэрэгт хамтран хариуцагчаар “Цемент шохой” ТӨХК оролцож байна. Тус хэргийн оролцогчидтой холбоотой эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх, арбитрын журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргаан (“Бэйзмэнт” ХХК (“Хөтөл” ХХК)-ийн өв залгамжлагч нь Б.Тулга мөн эсэх асуудал тодорхой болох хүртэл)-ыг хянан шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй үндэслэлээр түдгэлзсэн байна. Шүүх хурал 18 удаа хойшилсон ба одоогийн байдлаар дээрх шалтгааны улмаас түдгэлзсэн байна. “Эрдэнэс Монгол” ХК-ийн мэдээлэл: 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан нийт зээлийн үлдэгдэл 42.6 тэрбум төгрөг, хуримтлагдсан хүүгийн өглөг 877 сая төгрөг, нийт 43.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан. Гүйцэтгэх захирлын 2023 оны 4 дүгээр 19-ны өдрийн 01/296 тоот албан бичгээр Хөгжлийн банканд хандсан ба хуваарийн дагуу төлөлт хийсний дүнд зээлд 42.6 тэрбум төгрөг, зээлийн хүүд 3.2 тэрбум төгрөг, нийт 45.85 тэрбум төгрөгийн өр төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.	“Хэрэгжих шатанд”-70%	
98	145	**Тэмдэглэл** 2022-09-14, № 45 ХХ.2. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын	**ТӨБЗГ – ТӨБАХ** Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар холбогдох ажлын хэсгийг ТӨБЗГ-ын төлөөллийг оролцуулан байгуулсан бөгөөд ОХУ-ын Москва хот дахь Элчин сайдын яамны эзэмшилд байгаа Хоёрдугаар байрны түрээслэгч “Центр регион эстейт” компанийн зүгээс	“Хэрэгжих шатанд”-70%	

		яамны Хоёрдугаар байрны түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болж буйтай холбогдуулан тухайн байрыг түрээслэгчээс хүлээн авах ажлын явцыг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны Хоёрдугаар байрны түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болж буйтай холбогдуулан түрээслэгч “Центр регион эстэйт” компанитай үүссэн өр төлбөрийн асуудлаар монголын талд ашигтай хувилбараар хэлэлцээ хийх, өр төлбөргүйгээр эцэслэн шийдвэрлэх, тус байрыг хүлээн авах чиглэлээр ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгав.	байрыг хүлээн авах, тус байрын засвар, тохижилтод зарцуулсан хөрөнгийн хэмжээг үнэлэх болон холбогдох стандарт, арга зүйн дагуу хэмжээг бодитой тогтоож, цаашид уг байртай холбогдуулан авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. “Центр регион эстейт” компаниас нийт 1.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт, засвар сайжруулалтын дүнг нэхэмжилж, тухайн үедээ албан бичиг ирүүлсэн боловч уг дүнг хүлээн зөвшөөрөх боломжгүй байсан бөгөөд манай талаас мөн нэхэмжлэх авлагын асуудлаар тооцоо, судалгаа хийж, өр, авлагагүйгээр эцэслэн шийдвэрлэх саналыг хүргүүлсэн. Тус компаниас дахин Элчин сайдын яаманд хандаагүй байгаа бөгөөд ашиглалтын зардлын тооцоо нийлэх, төлбөр барагдуулах ажил хийгдсэн байна. Элчин сайдын яам Хоёрдугаар байрыг “Центр регион эстейт” компаниас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр албан ёсоор актаар хүлээн авч, байрыг чөлөөлсөн. Тус байрыг төрийн өмчид хүлээн авч, үр ашигтай ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээг авах зорилгоор Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны Хоёрдугаар байрыг Худалдааны төлөөлөгчийн газар, Соёлын төвийн зориулалтаар ашиглахад дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын хуулийн этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна.		
	146	**Тэмдэглэл** 2022-09-14, № 45 ХХ.4.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг байгуулагдаж, уг асуудалтай холбоотой судалгаа хийх, шийдэл гаргах арга хэмжээг судлан боловсруулах арга хэмжээ аван ажиллав. Үүний үр дүнд “Монгол шуудан” ХК-ийн зарим хэсгийг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын хэсэгт шилжүүлэн байршуулах зохион байгуулалтын арга хэмжээг авсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд шинээр байгуулагдсан агентлагийг мөн “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын хэсэгт шилжүүлэхээр шийдвэрлэж, тодорхой засвар үйлчилгээний ажлыг хийсэн. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т холбогдох судалгаа, тооцоолол, зураг төслийн ажлыг гүйцэтгэсэн.	“Хэрэгжих шатанд”-70%	

	147	**Тэмдэглэл** 2022-09-14, № 45 XX.4.4. “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг зориулалт бусаар ашиглуулахгүй байхад анхаарч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан)-т тус тус үүрэг болгов.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Судалгаа тооцоолол хийж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тэмдэглэлийн энэ заалтаар өгсөн үүргийг холбогдох байгууллагуудад танилцуулж, анхааралдаа авсан.	“Хэрэгжих шатанд”-70%	
99	148	**Тэмдэглэл** 2022-10-10, № 49 XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.	**ТӨБЗГ – МТА** “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах мэдээллийн систем байхгүй болно.	Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй – ХБ.	Цаашид хяналтаас хасуулах саналтай.
100	149	**Тэмдэглэл** 2022-11-09, № 54 X.8.10. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын бүтээгдэхүүнийг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглан төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулж, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны № 04 дүгээр тэмдэглэлийн дагуу “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-иас 150 ширхэг вагоныг түрээсээр ашиглаж байсан боловч “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д өөрсдийн экспортын ачаа тээвэрийг хэвийн явуулахад хүндрэл үүссэн тул “Монгол Улсын Сангийн Сайд”-ын 2023 оны 05 дугаар сарын 31 өдрийн 01/3896 тоот болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 14 өдрийн 01/484 тоот чиглэл өгсөн албан бичгүүдээр “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн түрээсийн вагоныг буцаан өгсөн. Тээврийн тасралтгүй үйл ажиллагааг хангах Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 362-р тогтоолын хэрэгжилтийг хангаж, төлөвлөгөөт валютын орлогыг төвлөрүүлэхээр үүрэг хүлээсэн ба тухайн үүргийг биелүүлэхийн тулд хувьдаа вагонтой аж ахуй нэгжүүдээс вагон түрээслэхээр үнийн санал авч дээрх үнийн саналын дагуу “Аксис Оф Ворлд” ХХК-иас 400 ширхэг вагоныг түрээслүүлэх санал ирэн гэрээ байгуулаад байна. “Аксис Оф Ворлд” ХХК нь ОХУ-аас 400 ширхэг вагоны түрээсийн гэрээ байгуулсан ба эхний 50	“Хэрэгжих шатанд”-70%	"Эрдэнэс Монгол" нэгдлийн харьяанд дээрх байгуулла-гууд ажиллаж байгаа тул хяналтаас хасуулах саналтай.

		(Ш.Мөнхцэрэн), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	ш вагоныг экспортод ашиглаж эхэлсэн ба дараагийн вагонуудыг оруулж ирэхээр ажиллаж байна.		
101	150	**Тэмдэглэл** 2022-11-23, № 56 XIX.1.4. “Монголросцветмет” ТӨҮГ-ын экспортын бүтээгдэхүүнийг тээвэрлэх төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Улаанбаатар төмөр зам” ХНН (Х.Хэрлэн), “Монголросцветмет” ТӨҮГ (Б.Мөнхбат)-т;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны №04 дүгээр тэмдэглэлийн дагуу “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-иас 150 ширхэг вагоныг түрээсээр ашиглаж байсан боловч “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д өөрсдийн экспортын ачаа тээврийг хэвийн явуулахад хүндрэл үүссэн тул “Монгол Улсын Сангийн Сайд”-ын 2023 оны 05 дугаар сарын 31 өдрийн 01/3896 тоот болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 14 өдрийн 01/484 тоот чиглэл өгсөн албан бичгүүдээр “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн түрээсийн вагоныг буцаан өгсөн. Тээврийн тасралтгүй үйл ажиллагааг хангах Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 362-р тогтоолын хэрэгжилтийг хангаж, төлөвлөгөөт валютын орлогыг төвлөрүүлэхээр үүрэг хүлээсэн ба тухайн үүргийг биелүүлэхийн тулд хувьдаа вагонтой аж ахуй нэгжүүдээс вагон түрээслэхээр үнийн санал авч дээрх үнийн саналын дагуу “Аксис Оф Ворлд” ХХК-иас 400 ширхэг вагоныг түрээслүүлэх санал ирэн гэрээ байгуулаад байна. “Аксис Оф Ворлд” ХХК нь ОХУ-аас 400 ширхэг вагоны түрээсийн гэрээ байгуулсан ба эхний 50 ш вагоныг экспортод ашиглаж эхэлсэн ба дараагийн вагонуудыг оруулж ирэхээр ажиллаж байна. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төмөртэй өртөөний үйл ажиллагаа 2022 оны 11 дүгээр сарын 15-аас хэвийн явагдаж байна. “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын төмрийн хүдрийг тээвэрлэж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрийн хооронд нийт 2766 вагон 190,550 тонн ачаа тээвэрлэсэн байна. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь "Монголын төмөр зам" ТӨХК, "Улаанбаатар төмөр зам" ХНН-тэй "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулан төмөр замын тээвэр, экспортын үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Зохион байгуулал-тын арга хэмжээ авагдсан тул хяналтаас хасуулах саналтай. "Эрдэнэс Монгол" нэгдлийн харьяанд ажиллаж байна.
	151	**Тэмдэглэл** 2022-11-23, № 56 XIX.1.5. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор “Төмөртэй” өртөөний үйл ажиллагааг сэргээх арга хэмжээ авахыг “Монголын төмөр зам” ТӨХК (П.Ганхүү), “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК (Г.Дугаржав)-д;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Монголын төмөр зам” ТӨХК-тай төмөр замын тээврийн гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж, энэ үеэр төмөр замын гэрээний төлбөрийн асуудлын талаар тусгайлан хэлэлцсэн. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн Төмөртэй уурхай түшиглэн бий болсон “Монголын төмөр зам” ТӨХК-ийн “Төмөртэй” өртөөний үйл ажиллагааг 2022 оны 11 дүгээр сарын 20-нд эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын төмрийн хүдрийн тээвэрлэлтийн тухайд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрийн хооронд нийт 2766 вагон 190,550 тонн ачаа тээвэрлэсэн байна.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Бүрэн хэрэгжиж, зохион байгуулал-тын арга хэмжээ авагдсан тул хяналтаас хасах саналтай.

102	152	**Тэмдэглэл** 2022-12-07, № 58 XXI.1.2. Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, тэдгээрийг томилох эрх бүхий этгээдэд;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх чиглэлээр Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд зөвлөмж, чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Засгийн газрын 2022 оны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар улсын гадаад валютын нөөц нэмэгдэж байна.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдааны 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд цаашид хэрэгжилтийг хянах боломжтой, ижил агуулгатай дараагийн тогтоол шийдвэр гарсан, зарим үүрэг даалгавар нь бүрэн хэрэгжиж, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. Цаашид хяналтаас хасах саналтай.
	153	**Тэмдэглэл** 2022-12-07, № 58 XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим	**ТӨБЗГ – МТА** Төрийн байгууллага хоорондын албан бичгийн солилцоог цахим хэлбэрээр хийх шийдлийг хэрэгжүүлэх чиглэлээр 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан цахим сургалтад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдыг хамруулж, https://docx.gov.mn цахим системийн талаарх ойлголт,	“Хэрэгжих шатанд”-70%	

		хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	мэдээллийг өгсөн бөгөөд системийн хэрэглээ, ашиглалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглаж, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож байна.		
103	154	**Тэмдэглэл** 2022-12-12, № 61 XIX.1. “Соёлын төв өргөө”-ний ашиглалтын нөхцөл байдлын талаар Соёлын сайд Ч.Номин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Соёлын төв өргөө”-ний байрны өмчлөлийн асуудлыг судалж эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр саналаа танилцуулахыг Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав.	**ТӨБЗГ – ТӨБАХ** Соёлын төв өргөөг УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчид /орон нутгийн өмчид/ шилжүүлсэн тул ТӨБЗГ-аас уг асуудлаар шийдвэр гарах эрх зүйн зохицуулалт байхгүй талаар Соёлын дэд сайд М.Батбаярт 2022 оны А-1/2227 дугаар албан бичгээр тайлбар хүргүүлсэн. Соёлын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Соёлын төв өргөө"-ний байрны өмчлөлийн асуудлыг судалж, эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр санал танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ТӨБЗГ-аас ажиллах төлөөллийн нэрийг 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А-1/959 дугаартай албан бичгээр Соёлын яаманд хүргүүлсэн.	“Хэрэгжилт хангалтгүй” – 30%.	ТӨБЗГ-аас хийх эхний ажил хийгдсэн. Холбогдох байгууллагын зохион байгуулал-таас шалтгаалан удааширч байна.
104	155	**Тэмдэглэл** 2023-01-18, № 4 VIII.2. 2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашины талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгав: 2.1.төрийн өмчийн ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн автомашинуудыг данснаас хасаж, засвар	**ТӨБЗГ – ТӨБАХ** 1. Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Уг асуудлыг УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай асуудлыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн байна. УИХ-ын зарим гишүүдийн зарчмын зөрүүтэй санал гарсантай холбоотой тогтоолын төслийг хууль тогтоомжийн санаачлагчид буцаасан тул УИХ-ын тогтоолын төслийг дахин өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	

		үйлчилгээ хийж сэргээх, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож орон нутгийн өмчид бүртгэх асуудлыг тухай бүр нь зохих журмын дагуу шийдвэрлэж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; 2.2.төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн суудлын автомашины ашиглалтыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хамтарсан 95/280 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын дагуу зохицуулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн болон Мэргэжлийн хяналтын газар (татан буугдсан)-ын эзэмшилд байсан үлдэх өртөгтэй 54 автомашиныг УИХ-ын тогтоолын төсөлд тусгаж, шийдвэр гарах хүртэл орон нутгийн өмчит эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад ашиглалтын гэрээ байгуулан хүлээлцэж, алслагдсан сумын төрийн үйл ажиллагаанд ашиглуулах ажлыг зохион байгуулсан. 2023 онд ТӨБЗГ-ын 2023 оны 26, 604 дүгээр тогтоолоор 120 автомашиныг орон нутгийн өмчит нийт 145 байгууллагад шилжүүлсэн бол ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 679 дүгээр тогтоолоор 12 автомашиныг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гаргаж, “Засгийн газрын авто бааз” ТӨҮГ-т шилжүүлсэн. Дуудлага худалдаа 2023 онд зохион байгуулагдаагүй. 2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах журам”-ыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Чиглэл хүргүүлж, санал авах тухай” А-1/194 дүгээр албан бичгийг төрийн өмчит бүх шатны байгууллагад хүргүүлж, мөрдөж ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан.		
	156	**Тэмдэглэл** 2023-01-18, № 4 Х.2. “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Төмөр замын экспортын тээвэрлэлтийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт тус тус Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1.Төрийн өмчид бүртгэлтэй ачааны хагас вагоныг тэргүүн ээлжид төрийн өмчит хуулийн этгээдэд ашиглуулж байх,	**ТӨБЗГ – ТӨҮЗХ** “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын бүтээгдэхүүнийг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглан төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулж, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран "Улаанбаатар төмөр зам" ХХН болон компаниудын гүйцэтгэх удирдлагуудад тодорхой чиглэл өгч ажилласан. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-аас “Монголросцветмент” ТӨҮГ нь 150 ш вагоныг түрээсээр авч, 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл экспортод гаргах ашигт малтмалын тээвэрлэлтэд ашиглаж байсан. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д өөрсдийн экспортын ачаа тээврийг хэвийн явуулахад хүндрэл үүссэн тул Сангийн Сайд”-ын 2023 оны 05 дугаар сарын 31 өдрийн 01/3896 тоот, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 14 өдрийн 01/484 тоот албан бичгүүдээр өгсөн чиглэлийн дагуу “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн түрээсийн вагоныг буцаан өгсөн.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Бүрэн хэрэгжиж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, хэрэгжилт тогтмолжсон тул хяналтаас хасах саналтай.

		гадаад валютын нөөцийг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой хуваарилалт хийх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь экспортын бүтээгдэхүүнийг тээвэрлэх талаар “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй байгуулсан гэрээний дагуу зэс, молибденийн баяжмалын тээвэрлэлтийг зохион байгуулж байна. Засгийн газрын 2022 оны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар улсын гадаад валютын нөөц нэмэгдсэн байна.		
	157	**Тэмдэглэл** 2023-01-18, № 4 Х.2.2. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн түрээслүүлж байгаа ачааны хагас вагоны түрээсийн гэрээ дуусмагц тэдгээр вагоныг “Монголросцветмет” ТӨҮГ-т ашиглуулах арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Дугаржав нарт;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Эрдэнэс Монгол” ХХК-аас хүргүүлсэн чиглэлийн дагуу “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр “Монголросцветмет” ТӨҮГ-тай “Вагон ашиглуулах гэрээ” байгуулж 150 хагас ачааны вагоныг төмрийн хүдрийн баяжмалын экспортод 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл ашиглуулсан. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д өөрсдийн экспортын ачаа тээврийг хэвийн явуулахад хүндрэл үүссэн тул “Монгол Улсын Сангийн Сайд”-ын 2023 оны 05 дугаар сарын 31 өдрийн 01/3896 тоот болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 14 өдрийн 01/484 тоот чиглэл өгсөн албан бичгүүдээр “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн түрээсийн вагоныг буцаан өгсөн. Тээврийн тасралтгүй үйл ажиллагааг хангах Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 362-р тогтоолын хэрэгжилтийг хангаж, төлөвлөгөөт валютын орлогыг төвлөрүүлэхээр үүрэг хүлээсэн ба тухайн үүргийг биелүүлэхийн тулд хувьдаа вагонтой аж ахуй нэгжүүдээс вагон түрээслэхээр үнийн санал авч дээрх үнийн саналын дагуу “Аксис Оф Ворлд” ХХК-иас 400 ширхэг вагоныг түрээслүүлэх санал ирэн гэрээ байгуулаад байна. “Аксис Оф Ворлд” ХХК нь ОХУ-аас 400 ширхэг вагоны түрээсийн гэрээ байгуулсан ба эхний 50 ш вагоныг экспортод ашиглаж эхэлсэн ба дараагийн вагонуудыг оруулж ирэхээр ажиллаж байна.	“Хэрэгжих шатанд”-70%	
105	158	**Тэмдэглэл** 2023-01-25, № 5 Х.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	**ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА** “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг байгууллага, нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, дунд, богино хугацааны улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахад “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн холбогдох зорилт, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж холбогдох байгууллагад санал хүргүүлэн ажиллаж байгаа болно. Тухайлбал, 2023 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

			боловсруулахдаа уялдаа холбоог хангаж, уг үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх чиглэлийг баримталсан.		
	159	**Тэмдэглэл** 2023-01-25, № 5 Х.1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшнийг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	**ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА** “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг байгууллага, нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, дунд, богино хугацааны улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахад “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн холбогдох зорилт, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж холбогдох байгууллагад санал хүргүүлэн ажиллаж байгаа болно. Тухайлбал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр боловсруулахдаа уялдаа холбоог хангаж, уг үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх чиглэлийг баримталсан, эдгээр төсөлд Эдийн засаг, хөгжлийн яамны санал, зөвлөмжийг тусгасан.	“Бүрэн хэрэгжсэн”-100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
	160	**Тэмдэглэл** 2023-01-25, № 5 Х.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов.	**ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан хэрэгжүүлэхээр уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газрын болон өөрийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, дүгнэлт, зөвлөмжийг албан хаагчид, удирдлагад танилцуулж, мэдээлэл, арга зүйгээр ханган хэрэгжүүлэх арга хэмжээг авсан болно. Холбогдох арга хэмжээг байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Хэрэгжилтийн явцыг сар бүр хянаж, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цахим системээр дамжуулан мэдээлж байна.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
106	161	**Тэмдэглэл** 2023-02-01, № 6	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ, ХЭЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа	

		XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ямар нэгэн судалгааг зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгээгүй, захиалга аваагүй. Цаашид уг заалтаар өгсөн үүрэг чиглэлийг тухай бүрд хэрэгжүүлэх талаар анхаарч байна.	болоогүй” – ХБ.	
107	162	**Тэмдэглэл** 2023-02-20, № 9 IY.2.2. “Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024” арга хэмжээнд оролцох нэгдсэн зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК (Б.Мөнхбат) нарт даалгав.	**ТӨУЗГ – ТӨУЗХ** Холбогдох байгууллагуудтай хамтран уг олон улсын арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангуулахад анхааран ажиллаж байна. “Дэлхийн үүрэн холбооны конгресс 2023” арга хэмжээнд Монгол Улсын төлөөлөл оролцож, тодорхой туршлага судлан ирэх жилийн арга хэмжээнд оролцох асуудлаа тодорхой болгосон байна. “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК “Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024” арга хэмжээг зохион байгуулагч талтай хамтран ажиллаж, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Улсын павильоны байршил, хэмжээг харилцан тохиролцсон бөгөөд холбогдох төлбөрийг шилжүүлээд байна.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	
108	163	**Тэмдэглэл** 2023-03-01, № 10 XY.1. Иргэдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зорилгоор эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх орны хүртээмж, шаардлагатай эмнэлгийн байр, эрүүл мэндийн төвийн хүчин чадлын талаарх судалгааг гарган танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт, **авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас төрд хураагдсан**	**ТӨУЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ** Авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас төрд хураагдсан болон төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд дэх эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний төв, сургуулийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр ашиглах боломжтой байрны талаарх мэдээллийг гаргах хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны А-1/1458 дугаар албан бичгээр нийслэл, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газарт албан бичиг хүргүүлж, эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний төв, сургуулийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр ашиглах боломжтой байрны талаарх судалгаа авах хүсэлтийг хүргүүлсэн. 21 аймгийн Орон нутгийн өмчийн газраас ашиглалтгүй байр, талбай байхгүй бөгөөд ашиглалтын	“Хэрэгжих шатанд”-70%	

		болон төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд дэх эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний төв, сургуулийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр ашиглах боломжтой байрны талаарх мэдээллийг гарган танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгав.	шаардлага хангахгүй болсон, актлах шаардлагатай барилга, байгууламжийн жагсаалт ирүүлснийг нэгтгэх арга хэмжээ авав.		
109	164	**Тэмдэглэл** 2023-03-29, № 14 XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: 3.Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт;	**ТӨБЗГ – ЗУХ** Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн 2 мэргэжилтэн БНХАУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулсан “Бүс ба зам дагуух улс орнуудын төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн шинэчлэл, засаглал” сэдвээр Бээжин хотноо 21 хоногийн сургалтад хамрагдан суралцсан.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%.	
110	165	**Тэмдэглэл** 2023-04-12, № 16 XIX.1. ... Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанд хийсэн	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн ажилтнуудын төлөөлөл, Үйлдвэрчний эвлэлийн хорооноос 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр гаргасан гомдол, хүсэлтэд дурдсан асуудлыг	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Зохион байгуулал-тын арга хэмжээ авч, хэрэгжүүл-сэн.

		аудитын тайлан, дүгнэлт, үйлдвэрийн захирлын асуудлаарх ажилчдын шаардлагыг нягтлан шалгаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.	судалж тогтоох үүрэг бүхий Ажлын хэсгийг томилсон. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 14-ний өдрийн хооронд “Цемент шохой” ТӨХК-д ажиллаж, дор дурдсан чиглэлээр үйл ажиллагаа, баримт материалтай танилцан дүгнэж, тайланг нэгтгэн удирдлагын бүрэлдэхүүнд танилцуулав. Үүнд: 1.“Цемент шохой” ТӨХК-ийн үйлдвэрлэлийн бэлэн байдалтай танилцаж, чулуунцрын аюулгүйн нөөц бүрдүүлэлт зохих хэмжээнд байгаа эсэхийг шалгах; 2.“Цемент шохой” ТӨХК-ийн 2022 оны 04 дүгээр сараас хойших хүний нөөцийн чиглэлээр гаргасан Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэртэй танилцаж, хууль зүйн үндэслэлийг хянах; 3.Компанийн цалин хөлсний дүрэм журамтай танилцаж, дүгнэлт гаргах. Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 258 дугаар тогтоолоор “Цемент шохой” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд шилжүүлж, Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК байхаар тогтоосон болно.		“Цемент шохой” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд шилжүүлж, Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь “Эрдэнэс Монгол” ХХК тул цаашид хяналтаас хасуулах саналтай.
	166	**Тэмдэглэл** 2023-04-12, № 16 ХХ.1.2. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Улаанбаатар хотын тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулах, явган хүний болон унадаг дугуйн зам барьж байгуулах зорилтын хүрээнд “Сэлбэ**	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 173 дугаар тогтоолоор “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг өөрчлөн баталж, нийт 198 хүртэл орон тоотой байхаар тогтоосон байна. Уг өөрчлөлтөөр “Сэлбэ сэргэлт” төслийн нэгжийг 11 орон тоотой байхаар шинээр бий болгосон. 2023 оны улсын төсөвт “Сэлбэ сэргэлт” төсөл хэрэгжүүлэх нэгжийн зураг төслийн хяналтын орлогыг 300.0 сая төгрөг байхаар тусган баталсан. Зардлын хувьд “Сэлбэ сэргэлт” нэгжийн 11 ажилтны 2023 оны цалингийн сан 271.7 сая төгрөг, НДШ зардал 33.9 сая төгрөг, захиалагчийн хяналтын зардал 32.8 сая төгрөг, нормын хувцас, багаж хэрэгсэлд 9.9 сая төгрөг, бусад зардал 114.1 сая төгрөг, нийт 462.4 сая төгрөг зарцуулахаар “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын зардалд төлөвлөгдөж батлагдсан.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн, хэрэгжилт бүрэн хангагдсан тул цаашид хяналтаас хасуулах саналтай.

		сэргэлт” төслийг хэрэгжүүлэх нэгжийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтцэд байгуулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;			
111	167	**Тэмдэглэл** 2023-05-03, № 19 XYIII.2.4. Улс хоорондын байнгын ачаа тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зорчих зөвшөөрөл олгох эрхийг нүүрс олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлж байгаа “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захиралд хариуцлага тооцох арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захиралд арга хэмжээ авах тухай асуудлыг ТӨБЗГ-ын хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн олонхын саналаар улс хоорондын байнгын ачаа тээврийн хил нэвтрэх "С" зөвшөөрлийг нүүрс олборлох үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүдэд шилжүүлэх асуудал нь тус байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй тул хариуцлага тооцох үндэслэл болохгүй гэж үзсэн байна.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасуулах саналтай.
	168	**Тэмдэглэл** 2023-05-03, № 19 XYIII.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.	**ТӨБЗГ – ЗУХ** Уг тэмдэглэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бүртгэгдээгүй, заалтын агуулга бүрэн тодорхой бус байгаа тул тайлагнах боломжгүй байна. Эрх зүйн мэдээллийн https://legalinfo.mn/mn цахим системд Засгийн газрын хуралдааны тэмдэглэл ордоггүй.	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	Энэ тэмдэглэл ТӨБЗГ-т бүртгэгдээгүй байна. Цаашид хяналтаас хасуулах саналтай.
112	169	**Тэмдэглэл** 2023-05-17, № 21 XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол,	**ТӨБЗГ – ЗУХ** Хэрэгжилтийг хангахад чиглэсэн мэдээллийг хэлтсүүдэд мэдээлсэн. Энэ тэмдэглэл ТӨБЗГ-т албан ёсоор ирээгүй, бүртгэгдээгүй байна. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан https://legalinfo.mn/mn ороогүй байна.	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	Энэ тэмдэглэл ТӨБЗГ-т бүртгэг-

		шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.			дээгүй байна. Цаашид хяналтаас хасуулах саналтай.
113	170	**XXV.11. “Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тэмдэглэл** 2023-06-07, № 24 XXV.11.2. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын нээлттэй сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, томилох арга хэмжээ авахыг Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (Н.Энхбат)-д зөвлөж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 13/18 дугаар тогтоолоор орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын Төлөөлөгч Ц.Дэнээдоржоор ахлуулан байгуулсан байна. Тус ажлын хэсэг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А-1/1844 тоот албан бичгээр хүргүүлсэн журмын төслийн саналын дагуу 2023.10.10-ны өдөр хуралдаж, журмын төслийг боловсруулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит 14 дүгээр хуралдаанд танилцуулахаар бэлтгэсэн байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн дагуу хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий аймгийн ИТХ-ын Байгаль орчин, уул уурхай, хөдөөгийн хөгжлийн хорооны хурлаар тус журмыг хэлэлцээд, журмын төсөл нь хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлага хангахгүй байна гэсэн дүгнэлт гарсан тул хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй. Ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас дахин санал авч аймгийн ИТХ-ын ээлжит 15 дугаар хуралдаанд танилцуулахаар журмын төслийг дахин боловсруулан аймгийн ИТХ-ын Хууль эрх зүй, ёс зүйн хорооны хуралд танилцуулсан боловч журмыг дахин боловсруулах шаардлагатай гэсэн хорооны дүгнэлтээр хуралдааны хэлэлцэх асуудлаас мөн хасагдсан. Иймд “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам эцэслэн батлагдаагүй байна.	“Хэрэгжих шатанд” – 70%	

	171	**XXV.11. “Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тэмдэглэл** 2023-06-07, № 24 XXV.11.4. Цаашид “Тавантолгой” ХК-ийн санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод, нээлттэй явуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (Н.Энхбат)-д зөвлөж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.”	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл болон Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, Байгаль орчин, уул уурхай, хөдөөгийн хөгжлийн хорооны өргөтгөсөн хурал 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж, “Тавантолгой” ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн орлого, цэвэр ашиг, сүүлийн хагас жилийн бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны тайлантай танилцан, мэдээлэл солилцсон. Тус өргөтгөсөн хурлаас “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн орон нутгийн өмчийн төлөөлөлд 10 заалт бүхий чиглэл хүргүүлэн ажиллалаа. Мөн аймгийн ИТХ-ын Зөвлөл 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хуралдаж “Тавантолгой” ХК-ийн цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээлэл сонсож, нүүрс тээвэр, экспортыг цаг алдалгүй эхлүүлэх арга хэмжээ авч, улсын болон орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтэд анхаарч ажиллах талаар шаардлага хүргүүлсэн байна.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
	172	**Тэмдэглэл** 2023-06-07, № 24 XXV.16.1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн хяналт шалгалтын дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн хяналт шалгалтын дүнгийн дагуу “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлөх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгов;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд нэр дэвшигчийн тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд 373 дугаар тогтоолоор нэр дэвшигчийг хууль тогтоомжийн дагуу түр томилох асуудлаар удирдамж өгсөн. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд сонгон шалгаруулалт зарлаж, дүн гарах хүртэл хугацаанд түр томилогдохоор нэр дэвшсэн Б.Отгонсүхийг тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоолоор түр томилсон.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
	173	**Тэмдэглэл** 2023-06-07, № 24	**ТӨБЗГ – ТӨУЗХ**	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул

		XXV.16.2. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, томилохыг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгов;	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж, хууль тогтоомж, журмын дагуу дүнг гаргасан байна. Сонгон шалгаруулалтын дүнгээр түр томилогдон ажиллаж байгаа Б.Отгонсүх шалгарсан дүнтэй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А-1/2325 дугаартай албан бичгээр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд өгсөн удирдамж, энэхүү тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 23/32 дугаар тогтоолоор Б.Отгонсүхийг жинхлүүлэн томилсон байна. Гүйцэтгэх захирлаар томилогдсон Б.Отгонсүхтэй Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.		хяналтаас хасуулах саналтай.
	174	**Тэмдэглэл** 2023-06-07, № 24 XXV.17.4. Эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа, шинжилгээний албан ажлын томилолтоор орон нутагт ажиллах боломжийг хангах зорилгоор автомашинаар хангах зохицуулалт хийх асуудлыг судалж шийдвэрлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	**ТӨБЗГ – ТӨБАХ** Төрийн хэмнэлтийн хуулиар эрдэм шинжилгээний байгууллагуудад автомашин ашиглах эрхийг өгөөгүй. Энэхүү тэмдэглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын үйлчлэлд хамруулж, үйлчилгээний автомашиныг ашиглах эрхийг өгөхөөр судалгааг авч, тоо төрөл тогтоох шийдвэрийг гаргахаар ажиллаж байна.	“Хэрэгжих шатанд” – 70%	
114	175	**Тэмдэглэл** 2023-07-05, № 28 1.1.Дорноговь, Өмнөговь аймагт хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав.	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шууд хамааралтай 1 арга хэмжээ төлөвлөгөөнд тусгагдсан (1.12 дахь заалт) Уг арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж, дараах үр дүнд хүрсэн байна: Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 109 дүгээр тогтоолоор Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газарт балансаас баланст шилжүүлж, тус барилгыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ашиглуулах тухай шийдвэрлэсэн. Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхт Төлөөлөгчийн 2023 оны А/344 дугаартай “Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын барилгыг хүлээлцэх ажлын хэсэг байгуулах тухай” тушаал гарч, уг ажлын хэсэг Засгийн газрын ажлын хэсэгтэй энэ чиглэлээр хамтран ажилласан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 221 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2023	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

			оны 10 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Өмнөговь аймагт газар дээр нь ажиллаж, Мэргэжлийн хяналтын газрын тус барилгын 1-2 давхарт бүхэлд нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг түрээсээр байршуулахаар шийдвэрлэсэн байна. “Төрийн өмчийн түрээсийн гэрээ” байгуулахаар холбогдох журмын дагуу баримт материалыг бэлтгэж, Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хооронд ашиглалтын гэрээ байгуулан албажуулж, Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоол болон энэ тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт хангагдсан байна.		
	176	**Тэмдэглэл** 2023-07-05, № 28 1.12. Өмнөговийн Мэргэжлийн хяналтын байрыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас түр өгсөн байгаа, тус барилгыг “Эрдэнэс Тавантолгой” ХК”-д шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх	**ТӨБЗГ – ТӨБАХ** Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 109 дүгээр тогтоолоор Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газарт балансаас баланст шилжүүлж, тус барилгыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ашиглуулах тухай шийдвэрлэсэн. Засгийн газрын Онцгой Бүрэн Эрхт Төлөөлөгчийн 2023 оны А/344 дугаартай “Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын барилгыг хүлээлцэх ажлын хэсэг байгуулах тухай” тушаал гарч, уг ажлын хэсэг Засгийн газрын ажлын хэсэгтэй энэ чиглэлээр хамтран ажилласан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 221 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2023 оны 10 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Өмнөговь аймагт газар дээр нь ажиллаж, Мэргэжлийн хяналтын газрын тус барилгын 1-2 давхарт бүхэлд нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг түрээсээр байршуулахаар шийдвэрлэсэн байна. “Төрийн өмчийн түрээсийн гэрээ” байгуулахаар холбогдох журмын дагуу баримт материалыг бэлтгэж, Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хооронд ашиглалтын гэрээ байгуулан албажуулж, Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоол болон энэ тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт хангагдсан байна.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
115	177	**Тэмдэглэл** 2023-07-19, № 29 IX.3.5. "Тавантолгой түлш" ХХК-ийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшийг хэрэглэгчдэд хүргэх, үйлчлэх ажиллагааг нийслэлд шилжүүлэх асуудлыг судалж зохих арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл,	**ТӨБЗГ – ТӨУЗХ** “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/416 дугаар тушаалаар “Хэрэглэгчдэд үйлчлэх төв”-ийг Нийслэлийн ЗДТГ-т шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус ажилтай холбоотой хэрэгжүүлэх ажил болон чиглэл ирүүлэх тухай албан бичгийг тус компаниас хүргүүлсэн байна.	“Хэрэгжих шатанд” – 70%	“Тавантол-гой түлш” ХХК нь "Эрдэнэс Монгол" нэгдлийн харьяанд шилжсэн тул хяналтаас

		Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн)-д;			хасуулах саналтай.
	178	**Тэмдэглэл** 2023-07-19, № 29 IX.3.7. Сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг)-ийн төмөр замын тээвэрлэлтэд хөнгөлөлт үзүүлэх, тээвэрлэлтийн вагоны тоог нэмэгдүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат нарт;	**ТӨБЗГ - ТӨУЗХ** “Тавантолгой төмөр зам” ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн ТүГ-2023/08 тоот түрээсийн гэрээг байгуулан сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг) тээвэрлэлтийн вагоны тоог 100-аар нэмэгдүүлсэн. 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 165 вагон, нэмэлтээр “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 100 вагон нийт 265 вагоны хатуу хуваарьт зурмагийн дагуу сард 45,000 тн сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг) тээвэрлэх төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна. Цаашид вагоны тоог 350-аас доошгүй явуулж, зүүн, баруун үйлдвэрт зэрэг түүхий эд авах шаардлагатай талаарх саналыг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/1615 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яаманд хүргүүлсэн байна. ШӨХТГ-аас мидлинг тээвэрлэлтэд төмөр замын хөнгөлөлт үзүүлэх боломжгүй тухайгаа Зам, тээврийн яаманд мэдэгдсэн байна.	“Хэрэгжих шатанд” – 70%	
	179	**Тэмдэглэл** 2023-07-19, № 29 IX.1. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээний хэрэглэгчдэд үйлчлэх төвийн үйл ажиллагааг менежментийн гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан, Цахилгаан түгээх сүлжээний хэрэглэгчдэд үйлчлэх төвийн чиг үүргийг менежментийн гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, цахилгаан түгээх, хангах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн чиглэлээр өөрчлөн зохион байгуулах талаар хамтарсан Ажлын хэсэг байгуулан судалж, саналаа танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого,	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Ерөнхий сайдын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 130 дугаар захирамжаар эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудыг өөрчлөн зохион байгуулах, Хэрэглэгчид үйлчлэх төвийн чиг үүргийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судлах үүрэг бүхий Засгийн газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна.	“Хэрэгжих шатанд” – 70%	

		зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгав.			
116	180	**Тэмдэглэл** **X.V. “Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа төрийн өмчит компаниудын сэргэлтийн ажлын явцын тухай”** 2023-09-13, № 37 XV.2.1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, хэмнэхэд чиглэсэн доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүн, албан тушаалтанд даалгав:	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улс дахь Өмч хувьчлалын явц, Улсын Их Хурлаас баталсан Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаарх танилцуулга, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А-1/1977, А-1/1976 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, төрийн өмчит компаниудын өмчлөлийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, өрсөлдөөнийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих, төрийн өмчит компаниудын комплайнсын асуудлыг судлах, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас Франц улсын Парис хотод зохион байгуулсан 40 дэх удаагийн хэлэлцүүлэгт оролцож, OECD, EBRD болон БНХАУ-ын SASAC-тай цаашдын хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр тогтсон. OECD болон SASAC нар хамтран зохион байгуулсан 16 дахь удаагийн Азийн бүсийн төрийн өмчит компаниудын засаглалын чуулга, уулзалтад оролцож Азийн бүсийн улс, орнуудын Төрийн өмчит компанийн засаглалын бодлогын талаарх туршлагыг судаллаа. Сингапурын Засгийн газрын агентлаг болох Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай компанийн засаглалын сайн туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулж, Гадаад харилцааны яам болон Сингапурын талд хүргүүлсэн бөгөөд төслийг хянаж хариу өгсөн бөгөөд талууд зарчмын хувьд тохирсон асуудлуудыг эцэслэн баталгаажуулахаар бэлтгэж байна. Төрийн өмчит компаниудын үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. “Үндэсний давхар даатгал” ТӨХК -ийн IPO -г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК -ийн IPO хийх бэлтгэл ажлыг хангаж байна. Ерөнхий сайдын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 130 дугаар захирамжаар эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудыг үндсэн үйл ажиллагааны чиглэлийг нь харгалзан өөрчлөн зохион байгуулах, хэрэглэгчдэд үйлчлэх төвийн чиг үүргийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судлан үзэж санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолоор авто замын засвар арчлалтын ажил эрхэлдэг төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулсан. Тус нэгтгэл компанийн дүрмийг ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, 407 дугаар тогтоолоор баталсан. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд,	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	

			компанийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ТӨБЗГ-ын 527, 565 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг томилж, 485 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирлыг томилох удирдамжийг Төлөөлөн удирдах зөвлөлд өгсөн.		
117	181	**Тэмдэглэл** 2023-10-04, № 40 2.32. Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ашиглаж байсан байрыг Стандарт, хэмжил зүйн хэлтэст шилжүүлэх асуудлыг “Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж, шийдвэрлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;	**ТӨБЗГ – ТӨБАХ** Шүүх шинжилгээний ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Шүүх шинжилгээний хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг балансаас балант шилжүүлэх тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 33 дугаар тэмдэглэлээр дэмжсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023.11.13-ны өдрийн А-1/2138 дугаар албан бичгээр үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 33 дугаар тэмдэглэл зэргийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2024 оны 1 сарын 25-ний өдрийн 33 дугаар тогтоолоор уг асуудлыг шийдвэрлэсэн.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
118	182	**Тэмдэглэл** 2023-11-08, № 45 XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ЗУХ, ХЭЗХ** Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг холбогдох журмын дагуу хагас, бүтэн жилээр, сар бүрийн хэрэгжилтийн явцыг гарган тайлагнан мэдээлж байна. Тайлан, мэдээг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулан Засгийн газрын хяналт, үнэлгээнд хамруулж хэвшсэн. Тайлан, мэдээлэл бүрийг байгууллагын удирдлага, албан хаагчдад мэдээлэн танилцуулж, удааширч, тасарч байгаа шийдвэр, заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг тухай бүр аван ажиллаж байна.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасуулах саналтай.
119	183	**Тэмдэглэл** 2023-11-15, № 46 XVI.12.8. Төрөөс иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ танилт, нэвтрэлтийн “ДАН” систем ашиглахыг Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны байгууллагын удирдлагуудад даалгав.	**ТӨБЗГ – МТА** Төрөөс иргэн хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээ одоогоор байхгүй байгаа бөгөөд цаашид төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн системийг бий болгох арга хэмжээ системийн түвшинд хөгжүүлэлт хийгдэж, ашиглалтад орсон үед танилт, нэвтрэлтийн “ДАН” системийг ашиглахаар анхааралдаа авсан болно.	“Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ.	

		Тэмдэглэл: 38 шийдвэрийн 62 заалт	**100% - 32 заалт; 70% - 22 заалт; 30% - 1 заалт; ХБ. – 7 заалт.**	**Дундаж үнэлгээ: 86.73%**	
Найм. Засгийн газрын албан даалгавар					
120	184	**“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай** **2023-04-17, № 01** 1.3. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ны гүйцэтгэх захирал С.Наранцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	**ТӨБЗГ – ТӨУЗХ** Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэгтгэн хүргүүлэх тухай чиглэл өгсөн албан бичгийг Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудад тус тус хүргүүлэв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А-1/884 дүгээр албан бичгийг хүргүүлсэн байгууллагууд: Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, “Эрдэнэс Монгол” ХХК зэрэг болно. Уг албан даалгаврын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчийн 100 хувийн эрхийг хэрэгжүүлдэг компани, үйлдвэрийн газрын захирлуудын мэдээлэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цахим хаяг, 1 сарын цалингийн мэдээллийг гаргаж, 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А-1/1017 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлэв. “Шил ажиллагаа”-ны хүрээнд https://shilen.gov.mn цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулалтаар ханган ажилласны үр дүнд ТӨБЗГ-ын хариуцан нээлттэй болгох Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой 1634 мэдээлэл уг цахим системд бүртгэгдээд байна. Мөн ТӨБЗГ-тай байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан түрээслэгчдийн судалгааг гарган https://shilen.gov.mn/ цахим хуудсанд байршуулж, 2017-2023 оны 2944 түрээслэгч, түрээслэгчдийн мэдээллийг хамруулан нээлттэй мэдээлсэн байна.	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.
	185	**“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай** **2023-04-17, № 01**	**ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ХЭЗХ, ЗУХ, МТА** Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын	“Бүрэн хэрэгжсэн” – 100%	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас

		1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	газраас хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг компани, үйлдвэрийн газрын захирлуудын мэдээлэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цахим хаяг, 1 сарын цалингийн мэдээллийг гаргаж, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А-1/1017 дугаар албан бичгээр хүргүүлэв. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл хариуцагчийн ил тод болгож, нээлттэй мэдээлэх мэдээллүүдийг холбогдох хэлтэс, албан тушаалтанд хариуцуулан ил тод болгох ажлыг зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2022 оны хэрэгжилтийн байдлын тайланг гаргаж, удирдлагад танилцуулан Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан https://new.unelgee.gov.mn/transparent/ системийн холбогдох хэсэгт оруулан баталгаажуулж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулсан. Байгууллагын мэдээллийн нээлттэй байдлын тайлангийн дүнг албан хаагчдад танилцуулах, зарим мэдээллийг нээлттэй мэдээлэх шаардлагатай талаар холбогдох албан хаагчдад зөвлөгөө өгөх, нээлттэй байдлыг боловсронгуй болгох чиглэлээр санал солилцох зэрэг арга хэмжээ авав. Байгууллагын мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэн цаг үеийн мэдээллээр тогтмол шинэчлэх, гарын авлага, товхимол, мэдээллийг сурталчилгааны тусгай тавиур хэрэгслийг ашиглан албан хаагчид, олон нийтэд сурталчлан таниулах зэргийг хийж гүйцэтгэв. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг холбогдох цахим систем https://shilendans.gov.mn/organization/8324 болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлж байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны А/86 дугаар тушаалаар “Бид – Ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяныг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд уг аяны хүрээнд байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах үйл ажиллагааг эрчимжүүлэх, харьяа байгууллагад зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний хүрээнд холбогдох хууль тогтоомжийг таниулан сурталчлах, ил тод, нээлттэй байдлыг хангах талаар мэдээлэл, зөвлөгөө, хууль сурталчлах ажлыг зохион байгуулав.		хасуулах саналтай.
		Албан даалгавар: 1 шийдвэрийн 2 заалт	**100% - 2 заалт.**	**Дундаж үнэлгээ: 100%**	

(Нийт 8 төрлийн 120 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 185 заалтын хэрэгжилтийг тайлагнав. 7 шийдвэрийн 10 заалт нэмэгдсэн, 2024.02.15)

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

Д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл	Шийд-вэрийн тоо	Хэрэг-жилтийг тооцсон заалтын тоо	Үүнээс:					Хэрэгжилтийн явцын дүн (хувиар)
				Бүрэн хэрэгжсэн (100 %)	Хэрэгжих шатанд (70 %)	Хэрэгжилт хангалтгүй (30 %)	Хэрэг-жээгүй (0 %)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ.)	
1	Монгол Улсын хууль	4	**11**	9				2	**100**
2	УИХ-ын тогтоол	13	**27**	11	9	1		6	**83.81**
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	8	**15**	9	5			1	**89.29**
4	Ерөнхийлөгчийн зарлиг	3	**4**	4					**100**
5	Засгийн газрын тогтоол	51	**62**	40	12			10	**93.08**
6	Ерөнхий сайдын захирамж	2	**2**	2					**100**
7	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	38	**62**	32	22	1		7	**86.73**
8	Засгийн газрын албан даалгавар	1	**2**	2					**100**
Хэрэгжилтийн дүн		**120**	**185**	**109**	**48**	**2**	**0**	**26**	**90.06**

Тайланг нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ

Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

Д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл	Шийд-вэрийн тоо	Хэрэг-жилтийг тооцсон заалтын тоо	Үүнээс:					Хэрэгжилтийн явцын дүн (хувиар)
				Бүрэн хэрэгжсэн (100 %)	Хэрэгжих шатанд (70 %)	Хэрэгжилт хангалтгүй (30 %)	Хэрэг-жээгүй (0 %)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ.)	
1	Монгол Улсын хууль	4	**11**	9				2	**100**
2	УИХ-ын тогтоол	13	**27**	11	9	1		6	**83.81**
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	8	**15**	9	5			1	**89.29**
4	Ерөнхийлөгчийн зарлиг	3	**4**	4					**100**
5	Засгийн газрын тогтоол	51	**62**	40	12			10	**93.08**
6	Ерөнхий сайдын захирамж	2	**2**	2					**100**
7	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	38	**62**	32	22	1		7	**86.73**
8	Засгийн газрын албан даалгавар	1	**2**	2					**100**
Хэрэгжилтийн дүн		**120**	**185**	**109**	**48**	**2**	**0**	**26**	**90.06**

Тайланг нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН 2024.02.15. Х.ЭНХЧИМЭГ

Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ